



Байгаль, цаг уурын өөрчлөгдөл малчин өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлснийг судалсан нь

*Эрсдэл судлах ажлын хэсэг, ЖЭМР Зөвлөгөө өгөх
компаний судлаачид эл тайлангийн эхийг
бэлтгэж, боловсролын доктор Равсалын Оюун
нэгтгэн боловсруулав.*

Судалгааны багийн гишүүд ба хамтран ажилласан хүмүүсийн нэрсийн жагсаалт

Д.д.	Нэр	Тайлбар
Зөвлөхүүд:		
1	PhD Тогтох Н.	УИХ гишүүн, Эрсдэл судлал ажлын хэсгийн (ЭСАХ) ахлагч
2	PhD. Мөнхцэрэн Ш.	Ядуурлын Судалгааны нэгж, СЭЗЯ
3	Ричард Маршал	НҮБХХ зөвлөх, Ядуурлын Судалгааны нэгж, СЭЗЯ
4	ScD. Бизъяа Г.	Мал аж ахуй, МАА-н хүрээлэн, ЭСАХ гишүүн,
5	PhD. Манибазар Н.	Ургамал судлаач, ЭСАХ гишүүн, ЖЭМР ХХК
6	PhD. Хүчит А.	Хөдөө аж ахуй, ЭСАХ гишүүн, Монгол фермер сургууль
7	Жамсранжав Г.	Монгол хэл, ёс заншил, ЭСАХ гишүүн, ЖЭМР ХХК
8	PhD. Авирмэд Д.	Эколог, ЭСАХ гишүүн
9	PhD. Хосбаяр П.	Геологч, ЭСАХ гишүүн, Геологийн хүрээлэн
10	Бямбажав	Ургамал судлаач, ЭСАХ гишүүн, Монгол фермер сургууль
Төслийн баг:		
1	PhD. Оюун Р.	Багийн ахлагч, ЭСАХ зохицуулагч, ЖЭМР ХХК
2	Батбаяр Л.	Менежер, Малчдын санал асуулга, ЖЭМР ХХК
3	PhD. Баатар Р.	Хөрс судлаач, ЭСАХ гишүүн, Газарзүйн хүрээлэн
4	PhD. Ундармаа Ж.	Ургамал судлаач, ЭСАХ гишүүн, Ботаникийн хүрээлэн
5	PhD. Цэвээн	МААн эдийн засаг, Эдийн засгийн Их сургууль, МУИС
6	Төрбилэг	Малчдын нийгмийн асуудал, чөлөөт судлаач
7	Цогт Ж.	Цаг уурын аюулт үзэгдэл, УЦУХ
8	Цээсодролцоо	Ус цаг уурын нийгэмлэг
9	Амаржаргал	Цаг уурын аюулт үзэгдэл, УЦУХ
10	Баярбат	Малчин, Дундговийн Эрдэнэдалай
11	Болдбаатар Ш.	Гамшгийн удирдлага, ЭСАХ гишүүн, ИХГ
12	Гаадмаа	Малчин өрхийн судалгаа, УЦУХ
13	Даваасүрэн	Малчин өрхийн судалгаа, Хэнтий
14	Дорж	Малчин өрхийн судалгаа, Завханы Тосонцэнгэл
15	Дуламсүрэн	Хөдөө аж ахуйн цаг уур, УЦУХ
16	Жигмэддорж	Гангийн судалгаа, УЦУХ
17	Ловор Г.	Малчдын судалгаа, ЭСАХ гишүүн
18	Лхамсүрэн	Газарзүйн мэдээллийн систем, МТТ БОЯ
19	Мөнгөнцоож	Малчдын судалгаа, Дундговь
20	Мөнхтуяа Ш.	Газарзүйн мэдээллийн систем, МТТ БОЯ
21	Намхай	Гамшгийн удирдлага, ЭСАХ гишүүн, ИХГ
22	Пүрэвсүрэн С.	Малчдын судалгаа, Төв аймаг, Малчдын нэгдсэн холбоо
23	Үржинханд	Малчин өрхийн судалгаа, Хэнтийн Дадал
24	Чулуун	Ус цаг уур, Дундговь
25	Чулуунбаатар	Малчин өрхийн судалгаа, Хэнтий
26	Баясгалан С.	
27	Алтанзул Х.	Мэдээлэл боловсруулалт, Геомэдээллийн төв, ЖЭМР ХХК
28	Ариунаа С.	
29	Ганчимэг О.	
30	Мөнхбаатар У.	
31	Мягмарсүрэн.	

Гарчиг

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД БА ХАМТРАН АЖИЛЛАСАН ХҮМҮҮСИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ	2
1.0 ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Судалгааны удирдамж, түүний хэрэгжилт	4
1.2. Судалгааны ажлын тайлан	10
2.0 СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	13
2.1. Дүгнэлт	13
2.2. Санал, зөвлөмж	29
2.3. Туршилт.....	36
3.0 БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨГДӨЛ, ХУВЬСАЛ БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙД НӨЛӨӨЛСӨН НЬ.....	52
3.1. Улсын хэмжээнд.....	52
3.2. Судалгаа хийсэн аймаг, сумдад	58
4.0 БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨГДӨЛ, ХУВЬСАЛ МАЛЧИН ӨРХИЙН АМЬЖИРГААНД НӨЛӨӨЛСӨН НЬ.....	72
4.1. Улсын хэмжээнд.....	72
4.2. Судалгаа хийсэн аймаг, сумдын малчдын амьжиргаа.....	76
5.0 БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХИ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС.....	88
5.1. Хөгжлийн бодлого, стратеги	88
5.2. ядуурлыг бууруулах бодлого.....	92
5.3. Мал аж ахуйг хөгжүүлэх, эрсдлийг бууруулах бодлого	95
5.4. Уур амьсгалын өөрчлөгдлийн талаархи бодлого	101
5.5. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар Төв аймагт авч буй арга хэмжээ, үр дүн	103
5.6. Бодлогод тусгах зарим санал	109

1.0 ТАНИЛЦУУЛГА

1999 оноос хойшхи жил дараалсан ган, зудад Монгол Улсын нийт малын бараг гуравны нэг нь хорогдож хөгжлийн эрч саарч, олон мянган малчдын амьжиргаа доройтсон нь цаашид байгаль, цаг уурын аюул бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, өөрчлөгдөлд дасан зохицох, гарз хохирлыг багасгах асуудлыг бэлчээр-өвс тэжээл-отор нүүдэл, мал-малчин-мал маллагааны харилцан шүтэлцээ, өнгөрсөн-одоо-ирээдүйн буюу уламжлал-шинэчлэлийн хэлхээ холбоонд нарийвчлан шинжилж, тохирсон арга ухаан олж нэвтрүүлэх хэрэгтэй байгааг харуулсан.

1.1. Судалгааны удирдамж, түүний хэрэгжилт

Судалгааны зорилго, зорилт¹

Судалгааны ажлын үндсэн зорилго нь дэлхийн уур амьсгалын өөрчлөгдлийн улмаас давтамж, эрчимшил нь өсөн нэмэгдэж буй ган, зуд, шуурга, их цас, эрс хүйтрэлт, их халуун, үер зэрэг *аюулт үзэгдлийг бэлчээрийн мал аж ахуй, малчин өрхийн амьжиргаа, ядуурал*, энэ талаарх төр, засгийн бодлого шийдвэр, хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбон судалж тэдгээрийн хоорондын хамаарал, *харилцан үйлчлэл, нөлөөллийг* тодотгон үнэлж, улмаар *байгаль, цаг уурын аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, өөрчлөгдөлд зохицох бодлогын үндэслэлийг* хангай, хээр, говийн бүсээр ангилан гаргаж зөвлөмж боловсруулахад оршиж байв.

Дээрх үндсэн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. 5 аймагт судалгаа явуулж 500 малчин өрхийг хамруулж тэдний амьжиргааны эх үүсвэр - хөрөнгө, орлогод байгаль, цаг уур хэрхэн нөлөөлж буйг судлах, үнэлэх
2. Ган зудын улмаас малаа хорогдуулж ядуурсан малчдын амьжиргааг дээшлүүлэхийн тулд ямар арга хэмжээ авч болох талаар судлах
3. Байгаль цаг уурын бэрхшээлийг хохирол багатай даван туулах, уур амьсгалын өөрчлөгдлийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, зохицохын тулд малчид, орон нутгийн удирдлага, төр засаг юу хийх талаар орон нутгийн удирдлага, малчид ямар бодол саналтай байгааг судлах,
4. Холбогдох хууль эрхзүй, бодлогын баримт бичиг, судалгааны тайлан, ном хэвлэлийг судалж орон нутгийн удирдлага, малчид, мэргэжилтний дүгнэлт, санал өнөөгийн бодлого, үйл ажиллагаанд хэрхэн туссаныг тодруулах, үүний үндсэн дээр зөвлөмж боловсруулах; Үүнд дараах асуудлыг тусгах:
 - Төр, засаг, орон нутгийн удирдлага, малчин өрхийн төвшинд байгаль цаг уурын өөрчлөгдлөөс урьдчилан сэргийлэх, дасан зохицох ямар бодлого, шийдвэр гаргах,
 - Бүсчилсэн хөгжлийн бодлоготой хэрхэн уялдуулах,
 - Орлого багатай ядуу малчдын хувьд ямар арга хэмжээ авч болох,
 - Бэлчээр дагаж нүүдэллэсэн малчдын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх гэх мэт.

¹ ЯСН, НҮБ-ын мэргэжилтний зөвлөмжийг тусгасан удирдамж, хөтөлбөр

НҮБХХ-ийн зөвлөх Ричард Маршалл судалгааны ажлын зорилгыг тодотгож *нэгдүгээрт, байгалийн аюулт үзэгдлээс мал аж ахуй, малчин өрхийн орлого, хөрөнгөд, улмаар хөдөө дэх ядуурлын төвшинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох, хоёрдугаарт байгалийн үзэгдлийн улмаас улам төвөгтэй болж буй нөхцөл байдал, учир шалтгааныг задлан шинжлэхийг зөвлөсөн.*

Судалгаанд ган зудад нэрвэгдсэн аймаг сумдын цөөн, дунд, олон малтай малчин өрхийг хамруулах, дээрх хоёр зорилгыг хэрэгжүүлэх явцад байгаль цаг уурын бэрхшээлтэй үед малчдад туслах төр засгийн бодлого, арга хэмжээнд үнэлгээ өгөх, улмаар ядуурал, эмзэг байдлыг бууруулах бодлогод хэрэг болох зөвлөмжийг төгсгөлийн тайланд тусгахыг даалгасан.

Төсөл эхлэх үед ЯСН-ээс судалгааны үр дүнг ядуурлыг бууруулах стратеги боловсруулах, хөдөөг хөгжүүлэх, бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэхэд ашиглахаар төлөвлөж байв. Гэвч судалгаа дуусч үр дүн нь гарахаас өмнө 2003 оны 6 сард УИХ, Засгийн газраас Хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэх төрийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн 2010 он хүртэлх хөтөлбөрийг батлан гаргав. Мөн Монгол Улсын засгийн газрын “Эдийн засгийн өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах стратеги”-ийг 2003 оны 7 сард Дэлхийн банкны удирдах зөвлөл дэмжих шийдвэр гаргаж Олон Улсын Валютын сангаас сайшаажээ. Иймд батлагдсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх аргазүйн асуудалд түлхүү анхаарсан.

Судалгааны ажлын гүйцэтгэл

Судалгааны ажлыг бэлчээр, өвс тэжээлийн хомсдолд оруулж малыг үй олноор зүй бус хорогдуулдаг ган, зуд, эрс хүйтрэлт, хүчтэй цасан ба шороон шуурга зэрэг **аюул**, үүнтэй зэрэгцэн явагддаг гол ус ширгэх, намаг хатаж хуурайших, мөнх цэвдэг хайлах, түймэр гарах, үер болох, хортон шавьж, үлийн цагаан оготоно элбэгших, малын гоц халдварт өвчин гарах зэрэг **сөрөг үзэгдэл** болон эдгээрийн шууд нөлөөлөлд малчин өрхийн орлого багасах, амьжиргааны эх үүсвэргүй болж ядуурах, шилжилт хөдөлгөөнд орох **бэрхшээл** зэрэг байгаль, нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлсийн хоорондын харилцан уялдаа, хамаарлыг судалж үнэлэхэд чиглүүлсэн.

Судалгааны ажлын хүрээнд 9 зүйл үйл ажиллагаа явуулж удирдамжийг бүрэн биелүүлэв. Үүнд:

1. Ном, баримт бичгийн судалгаа:

- Сүүлийн жилүүдэд төр, засгаас байгаль, цаг уурын бэрхшээлийг даван туулах, малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах талаар гаргасан бодлого шийдвэр, хэрэгжүүлсэн арга хэмжээ болон олон улсын байгууллага, хандивлагчдын дэмжлэг тусламжтайгаар хэрэгжүүлж буй томоохон төслүүд, тэдгээрийн үр дүнг байгаль, цаг уурын өөрчлөгдөлтэй холбон судлав.
- Ус цаг уурын хүрээлэн (УЦУХ), Улсын Иргэний хамгаалалтын газар (УИХГ), ЖЭМР ХХК, “Эрсдэл судлал” ажлын хэсгээс 1990-2002 онд хийж гүйцэтгэсэн уур амьсгалын өөрчлөгдөл, ган, зуд, цасан ба шороон шуургын судалгаа, аюул, өртөнги, эрсдлийн үнэлгээний ажлын үр дүнг малчин өрхийн амьжиргаа, ядуурлын асуудалтай холбон судлав.

2. **Анкетийн судалгаа:** 5 аймгийн 14 сумын нийт 61 удирдлага, 508 малчин өрхөөс анкетийн судалгаа авав. Үүнд:

- Төв аймгийн Алтанбулаг, Баян Өнжүүл сум
- Дундговь аймгийн Эрдэнэдалай, Гурвансайхан, Өлзийт сум,
- Булган аймгийн Булган, Бугат, Тэшиг сум
- Хэнтий аймгийн Дадал, Баян Овоо, Өмнөдэлгэр сум
- Завхан аймгийн Тосонцэнгэл, Дөрвөлжин, Алдархаан сум

Анкетийн судалгааны төлөөллийг сумын нийт малчин өрхийн 6 хувийн төвшинд байлгахар тооцож асуулганд хамрагдах өрхийн тоог тогтоосон.

Анкетийн судалгааг ган зуд дараалан тохиолдож нийгэм, эдийн засгийн хохирол ихээр учирсан сүүлийн 5 жил буюу 1999-2003 оныг хамруулан хийв.

Бэлчээр, мал маллагаа, малын төрөл нь уур амьсгал, байгалийн бүс бүслүүрээр ялгаатай төдийгүй уламжлал заншил, зах зээл, дэд бүтэц зэрэг бусад хүчин зүйлээс хамаардаг. Судалгаа хийх аймаг, сумдыг сонгохдоо хангай, хээр, говийн бүсийг төлөөлөх болон ган зудад өртсөн байдлыг харгалзан үзсэн болно. Судалгааны ажилд орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, малчдыг оролцуулав.

3. **Мэргэжлийн судалгаа:** Цаг уур, уур амьсгал, бэлчээрийн ургамал, хөрс, нийгэм, эдийн засаг, бодлого судлалын мэргэжилтнээр нарийвчилсан судалгаа хийлгэж анкетийн судалгааны үр дүнг магадлав.
4. **Нөлөөллийн судалгаа, үнэлгээ:** Ган зуд, салхи шуурга, их халуун, эрс хүйтэн зэрэг байгалийн аюулт үзэгдлээс мал аж ахуй, малчин өрхийн орлого, хөрөнгөд, улмаар хөдөө дэх ядууралд үзүүлэх сөрөг нөлөөллийг анкетийн ба мэргэжлийн судалгаагаар тодорхойлов. Улмаар эл нөлөөллийг аймаг, сум, багаар хавар намар тогтмол үнэлж, сургамж авч болзошгүй эрсдлийг урьдчилан тооцоолж сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх асуудлыг судалж аргазүйн үндэслэл, аргачлал боловсруулж, орон нутагт хэлэлцүүлж, туршсан.
5. **Аюул, өртөнги, эрсдлийн үнэлгээ:** ЖЭМР ХХК, “Эрсдэл судлал” ажлын хэсгээс 2000 оноос хойш хийж буй гамшиг, эрсдлийн судалгааг малчин өрхийн амьжиргаагаар холбон гүнзгийрүүлж, улмаар эрсдлийн үнэлгээний аргазүйн үндэслэлийг нарийвчлан малчин өрхийн төвшинд эмзэг байдал, сум, багийн төвшинд эрсдлийг үнэлэх аргачлал гаргав. Аргачлалыг “Гамшгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох” төсөлтэй хамтран Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд ган зуд, шуурга, ойн түймэр, хүн малын гоц халдварт өвчин, Завхан аймгийн говь, хээрийн бүсийн сумд болон Идэр сумын мал өвөлжилт, хаваржилтын төлөвлөгөөний жишээн дээр туршив.
6. **Зөвлөмж:** Судалгааны үр дүнг нэгтгэн байгаль, цаг уурын эрс, гаж үзэгдлийн улмаас бэлчээрийн мал аж ахуй, малчин өрхийн амьжиргаанд учрах бэрхшээл аюулаас урьдчилан сэргийлэх, цаашид уур амьсгалын өөрчлөгдөлд зохицож амьдрах (ойрын 2-3 жилд), хөгжих (5-10 жилд) бодлогыг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий 3 багц 40 зүйл санал зөвлөмж боловсруулан “Зудын сургамж” зөвлөмжийг² баяжуулав:
- Зөвлөмж 1:* Ядуурлыг бууруулах
Зөвлөмж 2: Малчдыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх
Зөвлөмж 3: Байгаль цаг уур өөрчлөгдөж буй нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулах

² 1999 2000 оны зудын сургамж, НҮБХХ МОН/00/302 төсөл, УЦУХ, ЖЭМР ХХК, 2000

Зөвлөмж болгож буй зарим зүйлийг Дундговь, Завхан, Хэнтий аймагт бодит байдалд туршсан, үр дүнг нь НҮБХХ, Ядуурлын судалгааны нэгж, Гамшгийн Ерөнхий газраас зохион байгуулсан орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, малчдын сургалт, семинарт танилцуулж хэлэлцүүлсэн.

7. Өгөгдөл, мэдээлэл боловсруулалт:

Орон нутагт цуглуулсан мэдээллийг Үндэсний Статистикийн газар, УЦУХ, БОЯ-ны Мэдээлэл тооцооллын төв, Ядуурлын судалгааны нэгжийн мэдээлэл болон “Эрсдэл судлал” ажлын хэсэг, ЖЭМР ХХК-аас 2002 онд Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Ховд, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь аймгаар явж цуглуулсан уур амьсгалын өөрчлөгдлийн судалгааны өгөгдөл, мэдээлэлтэй нэгтгэн боловсруулж шинжлэв.

Байгаль цаг уурын өөрчлөгдөл ба малчин өрхийн амьжиргааны интеграл үзүүлэлт, индекс бодох аргачлалын үндэслэл гаргаж туршив.

Байгаль цаг уур, мал, малчны орлого, хөдөлмөрийг холбоход 24 улиралт календар хэрэглэв.

Мэдээлэл боловсруулалтын ажлыг Геомэдээллийн төв хариуцан гүйцэтгэсэн ба одоо MS Access-д малчин өрхийн амьжиргааны анхан шатны өгөгдлийн сан байгуулж байна.

8. **Хамтын ажиллагаа:** Монголын Ус цаг уурын нийгэмлэг, Ус цаг уурын хүрээлэн, Байгаль орчны яамны Мэдээлэл Тооцооллын төв болон “Уур амьсгалын өөрчлөгдлөөс бэлчээрийн мал аж ахуйд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, зохицох бодлого боловсруулах”, “Монголын Хөгжлийн гарц”, “Гамшгийн Удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох” төслүүдтэй хамтран ажиллав.
9. **Тайлан:** Судалгаа, үнэлгээний ажлын завсрын тайлан бичиж ЯСН-д хүлээлгэн өгч ирсэн. Судалгааны үр дүнг нэгтгэсэн тайлан ЯСН ийн загвараар Монгол, Англи хэлээр бэлтгэгдсэн.

Судалгааны объект, аргазүй

ЯСН-ээс тавьсан шаардлага

ЯСН –ээс судалгааны аргазүйн талаар **оролцооны арга, туршилтанд** тулгуурлахыг голлох боловч зохих **онолын үндэслэл** ашиглах шаардлагатай гэж үзээд судалгааг 3 үе шаттай явуулах, үе шат тус бүрт дараах асуудлыг анхаарахыг зөвлөмж болгосон:


1. Анхан шатны өгөгдөл, мэдээлэл цуглуулах (ном судлах, туршилт хийх):
 - Хэвлэгдсэн материал ба хоёрдогч эх үүсвэрийн өгөгдлийг нэг доор цуглуулах, албан ёсны байгууллагын үзэл бодлыг тусгахын тулд Кате Гриффингийн баг, Даниел Миллэр нарын тайлан, 1998 онд Үндэсний статистикийн газраас хийсэн судалгаа, 2000 оны зудын сургамж, 2001 онд Монголын Засгийн газраас баталсан Ган, зудаас хамгаалахад туслах Үндэсний хөтөлбөр зэргийг нарийвчлан судлах
 - Ядуурлын судалгаа нь анхан шатны өгөгдөл цуглуулах, асуулга асуух, судлах, малчид, орон нутгийн хүмүүсийг оролцуулсан уулзалт, бүтэцжсэн ярилцлагын арга зэргээр хийгдэж бодит амьдралд байгаль цаг уураас учруулж буй нөлөөлөлд анхаарах ёстой.
2. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах:

- Байгаль цаг уурын улмаас хөдөөгийн хүн ам, малчид ядуурч буй үзэгдлийг тодорхойлон гаргахад түлхүү анхаарах
 - Ядууралд хүргэж буй хавсарга хүчин зүйлсийг ч анхаарч үзэх
 - Үнэлгээнд байгаль цаг уурын үзүүлэлтүүдийг малчдын орлого, хөрөнгөтэй харьцуулан хэрэглэх (аюулд нэрвэгдэж болох хөрөнгө)
 - Аюул бэрхшээлээс хамгаалах сүлжээ, тусламж дэмжлэг үзүүлэх механизмын асуудлыг авч үзэх
3. Үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх, бодлогын талаархи зөвлөмж гаргах
- Зөвлөмж нь малчдын эмзэг байдлыг бууруулах практик ач холбогдолтой байхын зэрэгцээ шийдвэр гаргагчдад хэрэг болох бодлогын асуудлыг багтаасан байх
 - Судалгааны ажлын үр дүнг тайланд бүрэн тусгах, олон түмэнд ойлгомжтой энгийн хэллэг хэрэглэх, хүртээмжтэй болгох
 - Малчдын орлого, хөрөнгийн хохирол, байгаль цаг уурын эрхшээлд өртсөн байдлын өгөгдөл, шинжилгээний үр дүнг тайланд тусгах
 - Судлаачдыг ЯСН-ээс зохион байгуулах уулзалт, ярилцлагад оролцуулж судалгааны үр дүнг нийтэд мэдээлэх

Хэрэгжүүлсэн нь

ЯСН-ийн зөвлөмжийн дагуу **оролцооны аргаар** сум, багийн удирдлага, малчдаас анкетийн судалгаа авч байгаль, цаг уурын улмаас мал аж ахуй, малчин өрхийн амьжиргаанд учирсан хохирол, сөрөг үр дагаварыг тодруулж, нөлөөллийг үнэлсэн. Шинжлэх ухааны ба уламжлалт арга ухааныг хэрэглэсэн. Судалгаа, үнэлгээний объектод өөр хоорондоо уялдаа холбоо, харилцан шүтэлцээтэй дараах үзэгдэл юмсыг авч үзсэн (Зураг 1.1):

- Өөрчлөгдөж буй уур амьсгал, цаг уурын аюулт үзэгдэл
- Бэлчээр, тэжээл
- Мал, маллагаа
- Малчин, өрхийн амьжиргаа



Зураг 1.1 Судалгаа, үнэлгээний объект

Цаг уур, хөрс, ургамал, нийгэм, эдийн засаг, бодлогын талаар мэргэжлийн судалгаа хийн **онолын үндэслэл, мэргэжилтний дүгнэлт** гаргаж анкетийн судалгааны үр дүнг нягтлан магадлав. Бодлого шийдвэр болон амьдралд бодитой тус үзүүлэх зөвлөмж боловсруулахын тулд аймаг, сум, багийн удирдлага, малчид, мэргэжилтний ажил, амьдралд хэргцээтэй гэсэн зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх аргазамыг тодруулах зорилгоор **4 туршилт** хийсэн.

Судалгааны ажил дараах 3 үе шаттай хийгдсэн.

1. Анхан шатны өгөгдөл, мэдээлэл цуглуулах (ном судлах, туршилт хийх):

- Зөвлөмжинд заасан ном хэвлэл, баримт бичиг, тайланг бүгдийг судалж судалгааны ажилд ашигласан. Үүнээс гадна хууль эрхзүй, бодлого, шинжлэх ухааны нийт 27 ном хэвлэл, баримт бичгийг судалж буй асуудалтай холбон судалсан.
- Судалгааг малчдын амьжиргааны асуудалд төвлөрүүлэн анхан шатны өгөгдөл, мэдээллийг сум, багийн удирдлага, малчдаас авсан анкетийн асуулга, харилцан ярицлага, хэлэлцүүлэг, зөвлөгөөний аргаар цуглуулсан.
- Анкетийн судалгааны үр дүнг магадлах зорилгоор ус цаг уурын ажиглалтын мэдээлэл ашиглаж, бэлчээрийн ургамал, хөрсний хээрийн ажиглалт, хэмжилт хийж, дээж авч лабораторт шинжлүүлэн өгөгдөл мэдээлэл цуглуулсан.
- Судалгаа хийсэн аймаг, сумдаар уур амьсгал, цаг уур, бэлчээр, хөрс, газрын гадаргын зураг мэдээлэл бүрдүүлж ашигласан.

2. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах:

- Байгаль цаг уурын үзэгдлийн улмаас малчдын орлого, хөрөнгөд учруулсан хохирол, үр дагаварыг судалж шинжилсэн. Нөлөөллийн зэрэглэлээр үзэгдлүүдийг эрэмбэлсэн ба мэргэжлийн судалгаагаар нягталсан. Эрүүл мэнд муудах, хүүхэд сургуулиас завсардах зэрэг сөрөг үзэгдлийн учир шалтгааныг нарийвчлан тодруулсан.
- Аюул бэрхшээлээс хамгаалах сүлжээ, мал аж ахуй, малчин өрхөд тусламж дэмжлэг үзүүлэх механизмыг тодруулахын тулд ус цаг уур, байгаль орчны мониторингийн сүлжээ, гамшгаас хамгаалах тогтолцоо, хөдөлмөр, нийгэм хамгаалал болон хүнс, хөдөө аж ахуйн салбарын төв, орон нутгийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, бэлчээр ашиглалтын зураглал, бэлчээрийн хөрс, ургамалын төлөв байдал, нөөцийг судалж шинжилдэг байгууллагуудын үйл ажиллагааг бэлчээрийн мал аж ахуй, малчин өрхийн эмзэг байдал, эрсдэлийн асуудалтай холбон авч үзсэн. Үүний үндсэн дээр бэлчээр, мал, малчин өрхийн эмзэг байдал болон эрсдлийг үнэлэх, эрсдлээс сэргийлэх ажлыг төлөвлөх аргачлалыг³ сум, багийн төвшинд болгож ган зуд, их хүйтэн, их цас, хүчтэй салхи шуурга зэрэг аюулт үзэгдлийн хувьд Хэнтийн Өмнөдэлгэр, Завханы говь, хээрийн сумд, Идэр сумын жишээн дээр нарийвчлан туршсан.

3. Үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх, бодлогын талаархи зөвлөмж гаргах

³ Байгалийн гэнэт аюул ба удирдлага, зарлан мэдээлэл, НҮБХХ, Улсын Иргэний хамгаалалтын газрын Монгол Улсын гамшгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох төслийн дэд төслийн тайлан, “Эрсдэл судлал” ажлын хэсэг, ЖЭМР ХХК, 2002.

- Малжуулах, түлшний шинэ эх үүсвэр, тэмээ өсгөх талаар практик ач холбогдол өгөх зөвлөмжөөс гадна сум, багийн төвшинд эрсдлийн тогтолцоо бий болгох бодлого, аргагүйн зөвлөмж боловсруулсан.
- Судалгааны ажлын тайланг дэлгэрэнгүй, энгийн хэллэгээр бичиж график зураг ашиглан ойлгомжтой болгох талаар анхаарсан. Тайланг уншсан хүмүүс өөр өөрийн сонирхсон чиглэлээр мэдээлэл, сургамж авах, дүгнэлт хийх боломжтой байлгахын тулд судалгааны явцад цуглуулсан мэдээллийг хавсралтанд дэлгэрэнгүй оруулсан.
- Анкетийн асуулгын үр дүнгээр өгөгдлийн сан байгуулах, Интернэтэд тавих бэлтгэл ажил хийгдэж байна.
- Судалгааны үр дүнг ЯСН-ээс зохион байгуулсан мэргэжилтний уулзалт, бүсийн зөвлөгөөнд танилцуулж хэлэлцүүлсэн. Мандалговьд болсон бүсийн зөвлөгөөнд судалгааны ажил хийсэн төв, орон нутгийн 9, Арвайхээрт болсон зөвлөгөөнд 1 мэргэжилтэнг өөрийн зардлаар оролцуулж илтгэл тавиулсан.

Судалгаанд хэрэглэсэн аргагүйг доор жагсаав:

- Түүвэр судалгаа: Малчид, баг, сумын удирдлагаас тусгайлан боловсруулсан асуулгаар анкетийн судалгаа авсан.
- Ярилцлага: Эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Дундговь, Завхан, Хэнтий аймагт хэлэлцүүлж санал бодлыг нь тусгасан.
- Бүртгэл: Сум, багийн нийгэм, эдийн засгийн мэдээллийг сумын тоо бүртгэлээс түүвэрлэж авсан.
- **Ус цаг уурын судалгаа:** Судалгаанд хамрагдсан аймаг, сумдын нутгаар уур амьсгал, цаг уурын үзүүлэлтийг түүвэрлэн авч төрөл бүрийн үзүүлэлт бодох, ургамал, мал, малчны амьжиргаатай холбоход математик статистикийн болон экспертийн мэдлэг, логикийн арга хэрэглэсэн.
- **Ургамал, хөрсний судалгаа:** Геоботаник, хөрсний эрдэм шинжилгээний судалгаа, хээрийн ажлын аргагүй хэрэглэсэн.
- **Үнэлгээ:** Байгаль, нийгэм, эдийн засаг, бизнесийн салбарт хэрэглэдэг тодорхойлолт, үзүүлэлт, шинжилгээний аргыг хам хэрэглэн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдлийн тоон ба чанарын үнэлгээ хийсэн.
- **Туршилт:** “Шингэрүүлсэн хий”, “Баянцагааны илүү нугаламт хонины хурган хуц”, “Тэмээний ноосон хивс”, “Эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ” зэрэг туршилт хийсэн.
- **Мэдээллийн технолог:** Олон төрлийн өгөгдөл, мэдээллийг уялдуулах, нэгтгэн боловсруулахад өгөгдлийн сангийн удирдлагын систем, газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлал, Интернэт зэрэг хөгжингүй мэдээллийн технолог хэрэглэсэн.

1.2. Судалгааны ажлын тайлан

ЯСН-ээс тавьсан шаардлага

Судалгааны ажлын хамгийн гол үр дүн нь бэлчээрийн мал аж ахуйг байгаль цаг уурын эрхшээлээс, малчин өрхийг ядуурлаас хамгаалах асуудлыг давхар авч үзсэн, боломжит гарц, бодлогыг багтаасан тайлан байх ёстой гэж ЯСН-ээс үзсэн.

Тайланд өмнөх болон одоогийн хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ дүгнэлтийг оруулах ёстой. Монгол, Англи хэл дээрх тайланг ЯСН үндэсний ба олон улсын байгууллагуудад хүргүүлнэ. Тайлан ЯСН-ээс гаргасан загварын дагуу бэлтгэнэ.

Хэрэгжүүлсэн нь

Судалгааны эцэст “Байгаль, цаг уурын өөрчлөгдөл малчин өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлснийг судалсан нь” тайлан гарсан. Тайлан ЯСН-ээс гаргасан загварын дагуу Монгол, Англи хэлээр бэлтгэгдсэн.

Судалгааны ажлын үр дүн нь бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулах, мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах асуудал хариуцсан, сонирхсон гадаад, дотоодын байгууллага, төсөл, хүмүүст зориулагдсан.

Тайлангийн бүтэц:

1. Танилцуулга: Судалгааны ажлын удирдамж, түүний хэрэгжилт
2. Судалгааны үр дүн: Дүгнэлт, санал, зөвлөмж, туршилт
3. Судалгааны ажлын тайлбар: Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьсал бэлчээрийн мал аж ахуй, малчин өрхийн амьжиргаанд нөлөөлсөн нь, бодлогын судалгааны үр дүн

Тайланд байгаль цаг уурын эрхшээлд буй бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл, малчин өрхийн ядуурал, эмзэг байдлын асуудлыг авч үзэж эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах бодлого болон практик арга хэмжээнд тус болох дараах 40 зүйл санал зөвлөмжийг 3 бүлэгт ангилан тусгасан.

1. Ядуурлыг бууруулах
 - Судалгаанд хамрагдсан орон нутгийн удирдлага, ажилтны өгсөн санал зөвлөмж
 - Аюул, бэрхшээлтэй үед малчдад үзүүлэх нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох
 - Ядуурлыг бууруулах бодлого хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс
 - Малжуулахад анхаарах зүйлс
2. Малчдыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх
 - Эдийн засгийн хувьд бэхжүүлэх
 - Зах зээлийн эрсдлийг бууруулах
3. Байгаль цаг уур өөрчлөгдөж буй нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулах
 - Судалгаанд хамрагдсан малчдын өгсөн санал, зөвлөмж
 - Ус цаг уурын үйлчилгээг сум, баг, малчин өрхөд хүргэх
 - Эрсдлийг бууруулахын тулд ойрын хугацаанд авах арга хэмжээ
 - Эрсдлийг бууруулахын тулд дунд хугацаанд авах арга хэмжээ
 - Бэлчээр хамгаалах, ашиглалтыг сайжруулах

Судалгааны үр дүнг нягталсан байдал

Байгаль, нийгэм, эдийн засгийн салбарын эрдэмтэд, судлаачдыг оролцуулсан уулзалт, ярилцлага, онолын хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж судалгааны аргазүй, анкетийн асуулгыг сайжруулсан ба аймаг, орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, малчдын санал зөвлөмжийг ч авч тусгаж ажиллав.

Судалгааны үр дүн, үнэлгээний аргазүй, зөвлөмжийг дараах уулзалт, семинарт танилцуулж хэлэлцүүлэв:

1. Болзошгүй хохирол, эрсдлийг үнэлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө зохиох аргачлал, Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нарын сургалт-семинар:
 - i. Өндөрхаан, 2003-V-16-17
 - ii. Ховд, 2003-VI-24-26
2. Малчин өрхийн амьжиргаанд байгаль, цаг уурын өөрчлөгдлийн нөлөөллийн судалгааны үр дүн, Ядуурлын судалгааны нэгжээс зохион байгуулсан мэргэжилтний хэлэлцүүлэг, 2003-IX-5
3. Малчин өрхийн амьжиргаанд байгаль, цаг уурын өөрчлөгдлийн нөлөөллийн судалгааны үр дүн, Ядуурлын судалгааны нэгж, НҮБХХ-ээс зохион байгуулсан бүсийн ба нэгдсэн семинар:
 - i. Төвийн бүс: Мандалговь, 2003-IX-17-18
 - ii. Баруун бүс: Өлгий, 2003-IX-29-30
 - iii. Хангайн бүс: Арвайхээр, 2003-X-4-5
 - iv. Зүүн бүс: Баруун Урт, 2003-X-27-28
 - v. Нэгдсэн семинар: Улаанбаатар, 2003-XI-17
4. “Мал өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөлт” Завхан аймгийн сум, багийн удирдлага, мэргэжилтний сургалт-семинар:
 - i. Улиастай, 2003-X-2-3
 - ii. Идэр сум, 2003-X-5-6

Дээрх хэлэлцүүлэгт гарсан санал зөвлөмжийг судалгааны дүгнэлт, зөвлөмж, тайланд тусгасан.

2.0 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шинжлэх ухаан технолог өндөр хөгжиж, үйлдвэрлэл үйлчилгээ нэмэгдэж, дэлхийн олон улс оронд хүний ажиллах амьдрах ахуй орчин асар ихээр өөрчлөгдөж дэвшсэн энэ цаг үед Монгол Улсын эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй зуун зууны тэртээх байдлаар эрс тэс цаг уурын эрхшээл нөлөөлөлд өртсөөр, хүн ардын гуравны нэгийг эзэлж буй малчид тэнгэрийн аяс, газрын гарцаар нүүж суун амьдарсаар байгаа билээ. Ийн байхад уур амьсгалын өөрчлөгдөл хувьсал цаашид ч ноцтой сөрөг үр дагавартай байж болзошгүй тул аль болох хохирол багатай даван туулах аргыг нутаг нутгийн онцлог, хүн малын боломж чадавхид тохируулан нарийвчлан тодорхойлох асуудал тулгамдаж байна.

Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьслаас малчин өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг 1999-2002 оны ган, зудын бодит жишээн дээр статистик мэдээ, малчин өрхөөс авсан анкетийн судалгааны өгөгдөл мэдээлэлд тулгуурлан улсын болон судалгаанд хамрагдсан 5 аймаг, 14 сумаар үнэлсэн. Судалгаанд малчин өрхийг төлөөлж чадах бүх насны, эрэгтэй, эмэгтэй, янз бүрийн боловсролтой хүмүүс хамрагдсан. Асуултанд хариулсан хүмүүсийн 82% нь малчид байв. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин олон байв.

Судалгаа, үнэлгээний ажлын үр дүнгийн дүгнэлт, дэвшүүлж байгаа санал зөвлөмжийг товчлон нэгтгэж, судалгааны явцад хийсэн туршилтын хамт энэ бүлэгт тайлбарлан бичив. Үүнд:

Дүгнэлт:

1. Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьсал
2. Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьсал бэлчээрийн мал аж ахуйд нөлөөлсөн нь
3. Байгаль цаг уурын өөрчлөгдөл, хувьсал малчин өрхийн амьжиргаа, ядууралд нөлөөлсөн нь
4. Уур амьсгалын эрсдлийг бууруулж малчдын амьжиргааг дээшлүүлэхүй

Зөвлөмж:

1. Ядуурлыг бууруулах
2. Малчдыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх
3. Уур амьсгал, байгаль орчин өөрчлөгдөж буй нөхцөлд мал аж ахуйн эрсдлийг бууруулах

Туршилт:

1. Мал аж ахуйн эрсдлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх аргачлал
2. Шингэрүүлсэн хийн түлш бэлчээр хамгаална
3. Торниулж үржүүлэн малжуулах арга
4. Тэмээний эр ноосон хивс - тэмээ өсгөх хашүүрэг

2.1. Дүгнэлт

1. Байгаль цаг уурын өөрчлөгдөл, хувьсал

Уур амьсгал дулаарч, байгаль, цаг уурын эрс, цаг бус үзэгдлийн давтамж нэмэгдэж байна.

1999-2002 оны цаг агаарын бэрхшээл

1. **Хуурай, дулаан:** Олон жилийн дунджаас агаарын температур 0,3-2,7 хэм дулаан, хур тунадас 5-60 мм-ээр бага оров.
2. **Ган:** 6-9 сард температур 1,1-3,2 хэм дулаан, тунадас 8-50 мм-ээр бага, олон хоног үргэлжилсэн аагим халууны улмаас бэлчээр гандсан. Малын тарга хүч муу, өвс тэжээл хомс болов.
3. **Хахир өвөл, хавар:** Эрс хүйтэн, их цас, хавсарга шуурга олонтаа болсноос малын өвөлжилт, хаваржилтыг хүндэрсэн.

Уур амьсгалын олон жилийн дунджаар Монгол орны нийт нутгийн 75-аас дээш хувийг хамарсан ган 11-12 жилд нэг удаа тохиолддог атал 1999-2002 онд жил дараалан нийт нутгийн 60-80 хувийг хамарсан ган боллоо.

Цаашид уур амьсгалын дулааралт эрчимших, аагим халуун, эрс хүйтэн, ган, зуд, хүчтэй салхи шуурга зэрэг эрс үзэгдлийн давтамж нэмэгдэх, цаг бус үзэгдэл тохиох, үлийн цагаан оготоно, царцаа, хорхой шавьж олширч хөнөөлт гаж үзэгдэл хүрээгээ тэлэх, мөнх цэвдэг хайлах төлөвтэй байна.

1999 - 2002 оны жил дараалсан ган зуд, хүчтэй цасан ба шороон шуурга зэрэг байгаль цаг агаарын аюул, гамшиг нь мал сүрэг олноор хорогдох үндсэн шалтгаан болжээ.

Бэлчээрээ талхигдал, элсний нүүлт, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь Монгол Улсын хөгжлийн амин чухал асуудлуудын нэг мөн.

Судалгаа хийсэн 5 аймгийн 1999-2002 оны цаг агаарын байдал

508 малчин өрхөөс авсан судалгааны үр дүн: The m.

- Activities for рThe sМалчид байгаль цаг уурын гэнэтийн аюулын талаар мэдээлэл авч буй суваг нь радио (85%), сум, багийн удирдлага (81%), телевизэр (23%), явуулын хүн, ирсэн гийчэн (4%), сонин хэвлэл (4%) байна.
- Байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүлээж аваад тэдний 85 хувь нь малын хашаа хороогоо дулаалж, 81 хувь нь өвс тэжээлээ бэлтгэн, 69 хувь нь мал сүргийнхээ хариулгад анхаарч, 42 хувь нь хоол ундаа базааж, 25.7 хувь нь түлээ түлшээ бэлтгэдэг гэж хариулсан байна.
- Сум, багийн удирдлага, малчид цаг уурын эрс үзэгдэл, бэлчээрийн нөөцийн хомсдол, бэлчээрийн доройтлоор “Байгаль цаг уур өөрчлөгдөж байна” гэж үзэж, дараах өөрчлөгдлийг нэрлэж байна:

Цаг уурын үзэгдэл:

- Цас их хэмжээгээр унах болсон
- Гол горхи, булаг шанд хатах, ширгэж ундны ус хомсдсон
- Зуд байнга нүүрлэх болсон
- Ган гачиг дараалан тохиолдох болсон
- Үер ус нэмэгдсэн

Бэлчээрийн нөөц, хомсдол:

- Өвс ургамлын үржил шим муудсан
- Хадлан хадах ургац багассан
- Бэлчээр багассан
- Бэлчээр талхигдсан
- Цөлжилт ихэссэн

Судалгаа хийсэн 5 аймагт 1999-2002 онд ган, зуд, хүчтэй цасан ба шороон шуурга, эрс хүйтрэлт болж мал аж ахуйд хүндрэл бэрхшээл учруулсан байна.

Булган аймаг:

- 2002 оны зун аймаг даяараа гандуу, гантай байв.
- 1999, 2000 оны зун 5-19 хоног үргэлжилсэн аагим халуун болсон.
- 2000, 2001 оны 4, 2002 оны 12 сард 20-40 м/сек хүртэл хүчтэй салхи шуурга болсон.
- 2000 оны 1 сарын эцсээр -40 хэм хүрсэн эрс хүйтрэлт болсон.

Дундговь аймаг

- Аймгийн нутгийн 70-85 хувийг хамарсан ган сүүлийн 4 жилийн 3 жилд нь боллоо.
- Агаарын жилийн дундаж температур сүүлийн 4 жил дараалан олон жилийнхээ дундажаас 1.0-1.6 хэм дулаан байв.
- 1999, 2000, 2002 онд жилд орсон тунадасны хэмжээ олон жилийн дундажаас 6.8- 51.7 мм - ээр буюу 30% бага байв.

Завхан аймаг:

- 4 жил дараалан гантай, гандуу байв.
- 2000 оноос хойш 3 жил дараалан аймгийн нийт нутгийг хамарсан цагаан зуд боллоо.
- Агаарын жилийн дундаж температур 1999-2002 онд олон жилийн дундажаас 0.7-2.5 хэм дулаан болов.
- 1999-2002 онд орсон хур тунадасны хэмжээ 38-62 мм буюу олон жилийн дундажаас 21.9-39.7 хувиар бага байв.

Төв аймаг:

- 2000, 2001 оны зун ган болов.
- 2000 оны 4, 2000-2001 зааг, 2001 оны 4 сард 16-28 м/с хүрч хүчтэй шуурга болсон.
- 2001 оны 1 сард агаарын үнэмлэхүй бага температур хасах 35-40 градус хүрч эрс хүйтэрсэн.

Хэнтий аймаг

- Агаарын жилийн дундаж температур 1999-2002 онд олон жилийн дундажаас 0.6-1.8 хэм дулаан болов.
- 1999-2002 онд орсон хур тунадасны хэмжээ 5.9-95.2 мм буюу олон жилийн дундажаас 5.9-36.7 хувиар бага байв.

2. Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьсал бэлчээрийн мал аж ахуйд нөлөөлсөн нь⁴

Монгол Улсын эдийн засгийн үндэс, хүн ардын амьжиргааны эх сурвалж болсон бэлчээрийн мал аж ахуй нь байгаль, цаг уурын эрхшээл нөлөөлөлд байна. 1999 оноос хойшхи дараалсан ган зуд, хүчтэй шороон ба цасан шуурга нь малыг үй олноор хорогдуулж, мал аж ахуйн салбарт ноцтой хохирол учруулав.

Байгаль, нийгэм, эдийн засгийн олон зүйлийг хооронд нь уялдуулан хамтад нь авч үзэж эрсдлийг тооцоолж урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх боловсронгуй тогтолцоо дутагдаж байна.

⁴ Дэлгэрэнгүй тайлбар 3 дугаар бүлэгт

1999-2002 оны ган зудын үршиг: Улсын хэмжээнд⁵

Малын тоо: Цаг агаар тааламжтай 1993 - 1999 онд мал эрчимтэй өсч 1940 оноос хойшхи хамгийн олон 33.6 сая толгойд хүрсэн бол 1998 оноос хойшхи жил дараалсан аагим халуун, ган, зуд, хүчтэй цасан ба шороон шуурга зэрэг байгаль цаг уурын аюул, гамшигт олон сая мал хорогдсоноос 2002 оны эцсээр малын тоо 23.9 сая болж Монгол Улс 15 жилийн өмнөхөөс ч цөөн малтай болов.

Хорогдол, хохирол: 1999-2002 оны ган, зудад нийт 8.6 сая мал хорогдож, 333 тэрбум төгрөгийн шууд хохирол учирчээ. 2002 онд 1999 оныхоос тэмээ 29%, адуу 37%, үхэр 51%, хонь 30%, ямаа 17% цөөрсөн (доорхи хүснэгтээс харна уу).

	N ₁₉₉₉ сая толгой	N ₂₀₀₂ , сая толгой	N ₂₀₀₂ -N ₁₉₉₉ , сая толгой	(N ₂₀₀₂ -N ₁₉₉₉)/N ₁₉₉₉ , %
Нийт	33.6	23.9	- 9.7	- 28.9
Тэмээ	0.355	0.253	- 0.102	- 28.8
Адуу	3.163	1.988	- 1.175	-37.1
Үхэр	3.825	1.884	- 1.941	-50.7
Хонь	15.191	10.637	- 4.554	-30.0
Ямаа	11.034	9.135	-1.899	-17.2

Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь цаг агаар тааламжтай байсан 1999 онд 40.3% байсан бол 2002 оны эцэст 23.6% болов. Хөдөө аж ахуйн салбарын ДНБ 2002 онд 1999 оныхоос 1.6 дахин буурчээ (1995 оны үнээр).

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2002 онд 1999 оныхоос 25.3% буурсан байна (1995 оны үнээр). Мах үйлдвэрлэл 29% (нядалгааны жингээр), сүү үйлдвэрлэл 42% буурчээ.

Судалгаа хийсэн 5 аймагт⁶:

Дундговь аймаг 1999-2000, Завхан, Төв аймаг 1999-2000, 2000-2001 оны өвөл хавар олон мал алджээ. Булган, Хэнтий аймагт малын хорогдол бусад аймгуудаас бага хэдий ч 2000-2001 оны өвөл хавар үхэр нилээд хорогдсон байна. 2000 оны зудын дараах 3 жилд Дундговь аймгийн мал өссөн, харин Завхан, Төв, Булган аймгийнх цөөрсөөр байна. Дундговь, Завхан, Төв аймагт 1999, Булган, Хэнтий аймагт 2000 оноос хойш үхэр сүргийн тоо жил дараалан цөөрч байна.

Судалгаанд хамрагдсан аймаг тус бүрээр малын өсөлт, бууралтыг тухайн үеийн цаг агаарын нөхцөл байдалтай холбон дурьдвал:

- **Булган аймагт** 1998-1999 онд таван хошуу мал өсч нийт малын тоо 10,3 хувиар нэмэгдсэн. Гэвч 2000-2002 онд 3 жил дараалан ямаанаас бусад төрлийн мал, үүнээс үхэр 11.8-29.1%, адуу 8.2-10.2%, тэмээ 10-22.2% тус тус хорогдсон. Ган зудтай 3 жилээс 1999-2000 он адуунд, 2000-2001 он үхэрт, 2001-2002 он тэмээ, хонинд илүү халтай байжээ. Үхэр ихээр хорогдсон 2001 оны 1 сард 35-40 хэм хүрч хүйтэрсэн байна. Мал хорогдсон жилүүдийн цаг агаарын байдлыг авч үзвэл зун нь 30 хэмээс халуун өдөр олон хоногоор үргэлжилсэн, 34, 38, 40 хэм хүрсэн аагим халуун болсон, бэлчээр гандсан,

⁵ 1999-2002 оны статистикийн эмхэтгэл ашиглав.

⁶ Цээсодролцоо, Ус цаг уурын нийгэмлэг

өвөл нь 20, 29 см хүртэл цастай, хавар нь 24, 40 м/с хурдтай салхи шуургатай байжээ.

- **Дундговь аймагт** 1998-1999 онд бүх мал 4,9 хувиар, төрөл бүр дээрээ 0,6-10,5 хувиар хорогдсон. 1999-2000 онд хамгийн их хорогдол гарч аймгийн хэмжээгээр 602.5 мянган толгой мал хорогдсон. 2000 оны 1 сарын эхээр болсон их хүйтнээр 150 мянган мал хорогдсон. Нийт мал 39,1 хувиар, төрөл тус бүрээр 25,7-65,8 хувиар хорогдсон. Үүнээс адуу 47,8 хувиар, үхэр 65,8 хувиар хорогджээ. Мал хорогдсон цаг агаарын нөхцөл: 1999 оны зун гантай, 1999-2000 оны өвөл 20-40 см цасан бүрхүүлтэй, 1 сард их хүйтэн, хавар 28-40 м/сек салхи шуургатай байжээ. in
- **Завхан аймагт** 1999-2002 онуудад жил бүр малын хорогдол 5 төрөл дээр гарсан. Үүнээс 1999-2000, 2000-2001 онд нийт мал 20,2-23,4 хувь, адуу 26,7-27,7 хувь, үхрийн 41,8-43,8 хувь нь хорогдсон байна. Мал хорогдсон жилийн цаг агаарын нөхцөл: Дараалсан 3 жилийн ган, 2 жилийн зуд, 1999, 2000 оны 7 сарын 30-38 хэм халуун, 2001 оны 1 сарын S41- 51 хэм хүйтэн, 2000 оны 4 сарын 28-40 м/сек салхи шуурга.
- **Төв аймагт** 1999-2002 онуудад жил дараалан малын хорогдол гарсан . 1999-2000, 2000-2001 онуудад нийт мал 8,8-17,5 хувь, тэмээ 14,3-19,4 хувь, адуу 17,8-22,8 хувь, үхэр 23,6-34,8 хувиар хорогджээ. Харин ямаа хорогдоогүй. Мал хорогдсон цаг агаарын нөхцөл: 1999 оноос хойш жил дараалсан ган, 2001 онд 49 см, 2003 онд 38 см цасан бүрхүүлтэй байжээ.
- **Хэнтий аймагт** 1998-1999 онд бүх мал 5,3 хувиар, үүнээс адуу, үхэр, хонь 5,6-8,1 хувиар өссөн. 2001 онд ямаанаас бусад мал хорогдсон. Үүнээс адуу 9,5 хувь, үхэр 31,2 хувиар хорогдсон байна. Төв аймагтай адил ямаа хорогдоогүй, 1999 оноос хойш 17% өссөн. Хасах 49 - 51 хэм хүрсэн эрс хүйтрэлт, 28-40 м/сек цасан ба шороон шуурга мал хорогдох үндсэн шалтгаан болсон.

Судалгаа хийсэн 5 аймгийн малын өсөлт, бууралтын байдлаас дараах дүгнэлт хийж болохоор байна:

- Сүүлийн 3-4 жилийн малын хорогдол нь жил дамнан эхлэл, өрнөлт, бууралтын явцтай гарчээ.
- Их хорогдлын өмнөх жил бага хэмжээний хорогдол гарч дохио сануулга өгдөг ажээ. Хэрэв энэ үнэн бол мал хорогдох эрсдлийг жилийн өмнөөс мэдэж урьдчилан сэргийлэх, гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч болохоор байна. Гэвч үүнийг нарийвчлан судлах хэрэгтэй.
- Судалгаа хийсэн аймгуудад ган, зудын улмаас тэмээ, ямаа хорогдоогүй байна. Махны үндсэн эх үүсвэр үхэр, адуу, хонь хорогдсон нь тэмээний махны хэрэгцээг нэмэгдүүлсэн. Тэмээ өсгөх бодлого боловсруулж хэрэгжүүлбэл уур амьсгалын өөрчлөгдөлд зохицох нэгэн арга хэмжээ болно.

ᠨᠢᠵᠡᠭᠡᠢ 4 ᠡᠭᠡᠠ ᠠᠳᠡᠭᠡᠠ, ᠣᠶᠢᠳᠡᠡ ᠠᠡᠢᠶᠡᠢ ᠶᠢᠠᠠᠶᠢ ᠣᠶᠢ ᠣᠶᠡᠶᠡ 17-19% ᠶᠢᠶᠡᠶᠡᠶᠡ (ᠠᠠᠳᠡᠶᠡ ᠳᠢᠶᠡᠶᠡᠶᠡ ᠳᠠᠳ). ᠴᠣᠶᠡᠶᠡ ᠡᠶᠡ ᠠᠠᠳᠡᠶᠡᠶᠡ ᠣᠳᠣᠨᠣ ᠣᠶᠡ ᠠᠡᠢᠶᠡᠶᠡ ᠶᠢᠠᠠ ᠠᠠᠳᠡᠶᠡ ᠣᠶᠢᠳᠡᠶᠡᠶᠡᠶᠡ. with its cashmere

Аймгийн нэр	$(N_{2002}-N_{1999})/N_{1999}, \%$					
	Гэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Нийт
Булган	-30%	-25%	-47%	-14%	19%	-14%
Дундговь	-31%	-48%	-74%	-29%	-19%	-30%
Завхан	-35%	-51%	-69%	-43%	-21%	-41%
Төв	-36%	-39%	-55%	-31%	0%	-28%
Хэнтий	-15%	-13%	-37%	-5%	17%	-6%

Сумын төвшний нарийвчилсан судалгааг Дундговийн Эрдэнэдалай сумын жишээн дээр хийсэн. Зудын өмнө Эрдэнэдалай сум малын тоогоороо улсад тэргүүлж байсан. Зудын жил 110 мянган толгой мал хорогдуулж 4 тэрбум гаруй төгрөгийн шууд хохирол үзсэн. Хэрэв хорогдсон малын ашиг шимийг тооцвол 1999 - 2000 онд нийт 6.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Үхэр 4 дахин, адуу бараг 3 дахин цөөрсөн. Зудын өмнөх жил 1998 онд нэг өрхөд дунджаар 7 сая төгрөгөөр үнэлэгдэх мал ногдож байсан бол зудын дараа 2000 оны эцсээр 3 сая орчим болж буурчээ. at the end of 2000.

Бэлчээр, хөрсөнд нөлөөлж буй нь

Санал асуулгын үр дүн⁷:

Судалгаанд хамрагдсан малчдын 97.6 хувь нь нутаг орныхоо байгаль, цаг уур өөрчлөгдөж байгааг тэмдэглээд байгаль цаг уурын дараах өөрчлөлтүүдийг тодруулан нэрлэсэн байна. Булган, Хэнтийд нэг талаас цасны хэмжээ нэмэгдэж, нөгөө талаар ундны ус ховордож байгааг, Булган, Завханд ган гаичиг дараалан тохиолдож байгааг, Төв, Завхан, Булганд зуд байнга нүүрлэх болсон гэж олонхи малчид үзэж байна. Булган, Завхан, Хэнтийд гол гохи ширгэж, хадлангийн ургац буурч, Булган, Дундговь, Хэнтийд ургамлын шим муудаж, Дундговь, Завхан, Төв аймагт элсний нүүдэл, цөлжилт эрчимшиж байгааг малчид нэрлэжээ.

Зун бороо хур бага, олон өдөр дараалан халах, намар цас их унаж хайлж мөстөх, өвөл цастай шуургатай хүйтэн зуд болох, хавар салхи шуурга, хавсаргатай байх хандлага сүүлийн 10 шахам жил байнга давтагдсанаас булаг шанд, худаг хатаж ширгэх, усан хангамж дутагдан бэлчээрийн ургамалын бүрхэвч гандаж өөрчлөгдөж, шарилж хамхуул зэрэг ганд тэсвэртэй ургамал, мөн үл танигдах өргөст ургамалууд зонхилон ургаж мал дуртай идээшилдэг хиаг, ерхөг, хялгана, царгас болон бусад шимт ургамалын хэмжээ буурч, зарим газарт бүрэн арилснаас мал сүргийн тарга хүч, ноос, ноолуур, хөөвөр бүрдэх явц буурахаас гадна сүү сааль татран малын ашиг шим буурах хандлагатай байгааг малчид ярьж байлаа.

Мэргэжлийн судалгааны үр дүн⁸:

Судалгаанд хамрагдсан сумдын бэлчээрийн ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн төдийлөн өөрчлөгдөөгүй боловч бударгана, лууль, хамхуул, таана, хөмүүл зонхилж байна.

⁷ Төрбилэг

⁸ Н.Манибазар, Ж.Ундармаа, Р.Баатар,

Цаг уурын хүчин зүйл, түүний дотор хур борооны хомсдолоос шалтгаалан бэлчээрийн ургац буурах үзэгдэл ажиглагдаж байна. Олон жил дараалсан ган нь хур бороо элбэг байсан 2003 оны ургацад ч сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, Дундговь аймгийн хуурай хээрийн 2003 оны бэлчээрийн ургац нь Бэлчээр тэжээлийн зурагт заагдсан хэмжээнээс ойролцоогоор 2 дахин бага байна.

Ургацад мал сайн иддэг ургамлын эзлэх хувь буурч, мал тааруу иддэг ургамлуудын эзлэх хувь нэмэгдэж байгааг Дундговь аймгийн хуурай хээрт явуулсан судалгааны дүн харуулж байна. Бэлчээрийн ургацын бүрэлдүүнд, ялангуяа талхилсан бэлчээрт лууль, хамхуулын эзлэх хувь өндөр байгаа нь бэлчээрийн тэжээлийн шимт чанарыг бууруулж, өвөл хаврын бэлчээрийн нөөц эрс багасахын дохио - үзүүлэлт болно.

Судалгааны дүнгээс үзэхэд хээрийн элсэнцэр хүрэн болон цайвар хүрэн, говийн бор хөрсний үржил шимийн хэм хэмжээ цаг уурын нөхцлөөс хамаарч гантай, хуртай алин болохын аясыг даган хэлбэлзэж энэ хөрсөнд ургаж буй ургамлын ургац, хэмжээ ч жил жилд нилээд хэлбэлзэнэ. Гэвч цаг агаарын аясыг даган гандуу жил бага ургацтай байвч хур бороотой жилд дахин ургац ихэсдэг нь хөрсний байгалаас заяасан үржил шимийн нөөц хадгалагдсаар байгааг харуулж байна. Харин хүний үйл ажиллагаа, ялангуяа мал олноор ээлж сэлгээгүй бэлчээрлэснээс ургамлын ургах, сэргэх, нөхөн үржих нөхцөлийг нь хүчтэй алдагдуулж хөрсний үржил шим доройтох хандлага зарим нутагт ажиглагдаж байна. Иймээс ургамал халцрах, сийрэгжих, улмаар хөрс нүцгэрэх, үүний улмаас хөрс салхи, усны элэгдэл, эвдрэлд өртөх, хөрс элсэн хучаастай болох, элсэн хөрс малын хөлд талхлагдаж элс ихсэх, шавранцар хөрс нягтрах, улмаар чийг, температурын горим нь алдагдах, хатуурах, чийгээ алдах, хуурайших нь ихсэх зэргээр өөрчлөгдөж байна. Өнөөгийн төвшинд хөрс мэдэгдэхүйц өөрчлөгдөхөд малын бэлчээрлэлт, хүний үйл ажиллагаа гол хүчин зүйл болж байна.

Бодлого, удирдлага⁹

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн стратеги, мал аж ахуй, байгаль орчин, уур амьсгал болон ядуурлыг бууруулах асуудлаархи хууль эрх зүй, стратеги, бодлогын баримт бичиг хангалттай байна. Харин тэдгээрийг хэрэгжүүлэх нөөц дутагдалтай, аргачлал тодорхой биш, тогтолцоо нь бүрдээгүй байна. Тухайлбал, бэлчээрийн мал аж ахуйн оновчтой, шуурхай удирдлага, зохион байгуулалтанд хэрэгцээтэй мэдээ, мэдээлэл дутагдалтай, малын тоо, хорогдлын мэдээлэл эргэлзээтэй, жилийн доторхи өөрчлөгдөл нь тодорхойгүй байна. Малын хорогдлыг цаг агаарын аюулт үзэгдэл тус бүрээр судлах мэдээлэл дутагдалтай байна.

Мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа сул, мэргэжлийн байгууллагуудаас сум, баг, малчдад хүрч үйлчлэх боломж муу, чадавхи сул байна. Сумдын Байнгын онцгой комисс нь мэргэжлийн байгууллага, хүмүүсийн хамтын ажил үйлчилгээг хэрэгжүүлэх бүтэц мөн боловч энэ нь аюул гамшгийн үед ажилладаг, үйл ажиллагаа хязгаарлагдмал хүрээнд байна.

Эрсдлийн удирдлага, урьдчилан сэргийлэх, дасан зохицох бодлого нь аюул, өртөнги, эрсдлийн үнэлгээнд тулгуурлах ба үнэлгээ нь мэдээлэл, мэдлэгийн үндсэн дээр хийгдэнэ. Өргөн уудам нутагт сийрэг таруу амьдрах хүн ард бүхий Монгол оронд байгалийн бэрхшээл ба ядуурлын улмаас бий болсон ноцтой байдлыг даван туулахад мэдээлэл холбооны технолог нэн чухал ач холбогдолтой. Байгаль, цаг уурын мэдээллийг бэлчээр, тэжээл, мал, малчин, өрхийн амьжиргааны мэдээлэлтэй холбон боловсруулж удирдлагын бодлого, шийдвэр гаргахад хэрэг болохуйц хувилбаруудыг

⁹ Н.Тогтох, Р.Оюун, Мөнгөнцоож

гаргахад мэдээллийн технолог, түүний дотор зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн системд (GIS) суурилсан экспертийн систем бий болгох шаардлагатай.

Төлөөрөө өсч, зах зээл, хэрэглээ, байгаль цаг уураас шалтгаалан хоног, сар, улирлаар өөрчлөгддөг малын тоог жилийн эцсээр нэг удаа гаргадаг нь бодит байдлын явцын судалгаа, үнэлгээ, төлөвлөлтөнд хангалтгүйн дээр одоогийн баримталж буй татварын бодлого нь малын тоо толгойг дарагдуулахад хүргэж байна.

Өгөгдөл, мэдээлэл дутагдалтайгаас өнгөрсний сургамж, өнөөгийн үнэлгээ дүгнэлт, ирээдүйн төлөв тодорхойгүй, мал аж ахуйд олон асуудал тулгамдаж тэдгээрийг шийдвэрлэх нарийвчилсан аргачлалгүй байна.

Бэлчээрийн ба эрчимжсэн мал аж ахуйн талаар¹⁰

1999-2002 оны ган, зудад үхэр ихээр хорогдсоноос говь, хээрийн бүсэд аргал түлш ховордож хүүхэд хөгшидгүй бут сөөгөө түлэх болсон нь бэлчээрийг доройтуулж цөлжилтийг эрчимжүүлэх аюултай.

Монгол малыг чанаргүй гэж ярьж бичих явдал дэлгэрэх төлөвтөйд малчид төдий л санал нийлэхгүй байна. Ерөөсөө мянга мянган жилийн ган зудыг давж шалгарсаар ирсэн монгол мал дэлхийд хосгүй аминчадавхитай. Иймээс түүнийг “чанаржуулна” гэдэгт мал маллагааны уламжлалт технологгоо сэргээх замаар монгол малын генийн санг хадгалахыг ойлговол зохистой.

Ашиг шим өндөртэй сайн угсааны малын асуудал нь суурин маллагаатай эрчимжсэн мал аж ахуйн нэгэн хэсэг боловч монгол бэлчээрийн малыг тэдгээрийн сүү, мах, ноосны хэмжээнд хүртэл “чанаржуулах” нь ус тэжээлийн нөөцийг бүрдүүлээгүй цагт бүтэшгүй зүйл. Түүний оронд бэлчээрийн монгол мал, түүний тэжээлийн бааз нь байгалийн бэлчээр хэвээрээ байгаа цагт маллагааг нь уламжлалт хэмжээнд байлгахыг эрхэм болгож тодорхой бодлого, ажил зохиох нь хамгаас чухал.

Мал аж ахуйг эрчимжүүлнэ гэдэгт малчид тухайн нутгийн байгаль цаг уурын нөхцөлд дассан, гэсвэр сайтай, бие томтой, ноос ноолуур, мах, сүүний гарц нь арай илүү эцэг мал олж хээлтүүлэх, үр төлийг нь хамгаалан өсгөх, малын цус ойртохоос урьдчилан сэргийлж хээлтүүлэгчийг 2 жил тутам сэлгэхийг ойлговол зохино.

Баянцагааны илүү нугаламт хонины хурган хуц авч Эрдэнэдалайн 30 айлд өгсөн туршлагыг дэлгэрүүлж тухайн нутагт тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа таван төрөлд тохирох шилмэл омгийн хээлтүүлэгч олж үржлийн ажлыг судалгаатай, мэдлэгтэй, бүртгэл хяналттай явуулж болох талаар малчид ярьж байна.

Эрдэнэдалайд хурдан адуу, ноолуур сайтай, тулман хөхтэй ямааг (Сүхбаатарын Цагаандэлгэрийн улаан, эсвэл нутгийн хөх ямаа) сонирхож, ноосны үнэ нэмэгдвэл тэмээ өснө гэж байна. Нутгийн үхрийг 1960 аад онд казакийн цагаан толгойтоор сайжруулах оролдлого хийгээд амжилтгүй болсон сургамж бий. Одоо нутгийн үхрийг хамгаалан өсгөх нь чухал гэж үзэж байна.

Малыг сайн үүлдрийн хээлтэгчээр хээлтүүлэх ажлыг зөв зохион байгуулбал ашиг шим ахиутай малын тоо толгой геометрийн прогрессээр нэмэгдэж болохыг “Баянцагааны 30 хурган хуц” төслийн тооцоо харуулж байна.

¹⁰ Г.Бизъяа, Н.Манибазар, Н.Баярбат

3: Байгаль цаг уурын өөрчлөгдөл, хувьсал малчин өрхийн амьжиргаа, ядууралд нөлөөлсөн нь

1999 оноос хойшхи дараалсан ган зуд, хүчтэй шороон ба цасан шуурга нь малыг үй олноор хорогдуулж, олонхи малчдын амьжиргаанд ноцтой нөлөөлж ядуурлыг эрс нэмэгдүүлэв. Малчдын амьжиргаанд байгаль цаг уурын өөрчлөгдөл, хувьслын нөлөөллийг үнэлдэг, бодлого шийдвэрт тусгадаг, эрсдлээс хамгаалдаг байнгын жигд үйл ажиллагаатай тогтолцоо үгүйлэгдэж байна.

- **Нэг хүнд ногдох малын тоо:** 2002 оны эцсээр 9.7 болж 1940 оноос хойшхи хугацааны хамгийн бага үзүүлэлт боллоо.
- **Нэг хүнд ногдох мах, сүү:** 2002 онд 1999 оныхоос мах 32%, сүү 43% буурсан.
- **Малчдын ядуурал:** 1999-2002 онд 12100 өрх огт малгүй болж, мал бүхий өрхийн тоо 26.7 мянга, 200– аас олон малтай өрх 15.1 мянгаар тус тус цөөрчээ.
- **Өвчлөл:** 2000 онд Дундговь, Өвөрхангай, Говь-Алтай аймагт өмнөх 1999 оноос 3 дахин олон хүн халдварт өвчнөөр өвчилж бүртгэгдсэн байна. Төв, Завхан, Увс, Хөвсгөл, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотод 2000, 2001 онд халдварт өвчнөөр өвдөгсдийн тоо 1999 оныхоос эрс нэмэгджээ.

Судалгаа хийсэн 5 аймагт

Санал асуулгын үр дүн

- Ган зудын уршгаар ядуу, бага орлоготой айл өрхийн тоо нэмэгджээ. Малчин өрхийн шилжих хөдөлгөөн нэмэгджээ. Ган зудад нэрвэгдсэн аймгуудад халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо эрс нэмэгджээ.
- Судалгаанд хамрагдсан малчдын 54.3 хувь нь амьдрал ахуй 5 жилийн өмнөхөөс дордсон гэж хариулсан байна. Амьдрал дордсон шалтгаанаа тэдний 92.1 хувь нь байгаль, цаг уурын аюул гамшиг, эрсдэлтэй холбоотой гэж тайлбарласан.
- Судалгаанд хамрагдсан малчдын 77-92% нь нутаг орныхоо байгаль, цаг уур өөрчлөгдөж байгааг тэмдэглээд байгаль цаг уурын дараах өөрчлөлтүүдийг тодруулан нэрлэсэн байна. Булган, Хэнтийд нэг талаас цасны хэмжээ нэмэгдэж, нөгөө талаар ундны ус ховордож байгааг, Булган, Завханд ган гаичиг дараалан тохиолдож байгааг, Төв, Завхан, Булганд зуд байнга нүүрлэх болсон гэж олонхи малчид үзэж байна. Булган, Завхан, Хэнтийд гол гохи ширгэж, хадлангийн ургац буурч, Булган, Дундговь, Хэнтийд ургамлын шим муудаж, Дундговь, Завхан, Төв аймагт элсний нүүдэл, цөлжилт эрчимшиж байгааг малчид нэрлэсэн байна.
- Судалгаанд хамрагдсан өрхийн 92% нь сүүлийн 5 жилийн ган зуд, байгалийн бэрхшээлд хохирол амсчээ. Үүнд 53% нь малынхаа талаас илүүг хорогдуулж, үүнээс 17% нь бүх малаа алджээ.
- Судалгаанд хамрагдсдын 35% нь хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр тооцсон ба тэдний гаргаснаар хохирол нь 100 мянгаас 4 сая төгрөг болсон байна.
- Судалгаанд хамрагдагсдын малын талаар судалж үзэхэд, 58% нь малгүй буюу 100 хүртэл толгой малтай, 21% нь 101-250, 10% нь 251-400, 6% нь 400 аас олон толгой малтай байна.

- Малчин өрхийн орлого малын ашиг шимээс хамааран улирлын шинж чанартай. Тэтгэвэрийн хүнгүй малчин өрх тогтмол мөнгөн орлогогүй. Сарын орлого нь жигд биш. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 33% нь сард 30 мянган төгрөгөөс бага буюу өдөрт 1000 төгрөгөөс бага орлоготой байна. 37 хувь нь жилд 500000 төгрөгөөс бага, зөвхөн 7 хувь нь 1 сая төгрөгөөс их орлоготой байна. Ер нь малчид малын тоо, өрхийн орлогын талаар мэдээлэл өгөхдөө дуртай биш тул эдгээрийг ерөнхий баримжаа авахад л хэрэглэж болно.
- 1990-ээд оноос өмнө өндөр насанд хүрч тэтгэвэр авдаг болсон хөгшчүүлээс бусад малчдын хөдөлмөр эрхлэлт бүртгэгддэггүй, нийгмийн даатгалд хамрагддаггүй тул тэд өндөр насанд хүрэхэд тэтгэвэр авахааргүй байна. Ялангуяа залуу малчдыг нийгмийн даатгалд хамруулах ажил хийгддэггүй байна.

Малчдын хөрөнгө, орлогод үзүүлсэн сөрөг нөлөөлөл

Монгол Улсын мал сүрэг хувийн өмчинд байдаг. 2002 оны эцсээр мал бүхий 243 мянган өрх тоологдсоноос 72% буюу 176 мянга нь малын ашиг шимээр амьжиргаагаа залгуулдаг малчин өрх байна.

Малчдын **хөрөнгө** нь мал, даруухан тавилга бүхий гэр орон, малын хашаа хороо, тэрэг машин болон мал маллагаа, ашиг шим авах боловсруулахад хэрэглэдэг цөөн тооны тоног, багаж хэрэгсэл юм.

Малчдын орлого нь малын ашиг шим, тэтгэвэр тэтгэмж, арьс шир элдэх, мужаан дарх, оёдол хийх, хадлан, түлээ бэлтгэх зарим ажил үйлчилгээ болон арилжааны бага сага орлого зэргээс бүрдэж байна. Мал болон түүний ашиг шим нь дангаараа малчдын орлогын 60-100 хувийг бүрдүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөгдөл, сөрөг нөлөөлөлд малчид аймаг, хотын суурин иргэдээс илүү өртөмтгий байна. Сумын төвийн малчин бус айл өрхийн амьжиргаа ч малаас хамааралтай байна.

Ган, зуд, гэнэтийн цасан ба шороон шуурга, үер ус нь малчин өрхийн амьжиргааны эх сурвалж - үндсэн хөрөнгө болсон малыг хорогдуулж (шууд нөлөөлөл), улмаар орлогын эх үүсвэр болсон малын ашиг шимийг бууруулж (шууд бус нөлөөлөл) байна. Их цас, хүчтэй салхи шуурга, үер ус, ой хээрийн түймэр зэрэг нь малчдын гэр орон, малын хашаа хороо, тоног хэрэгсэл, бусад зүйлд шууд болон дам хохирол учруулжээ.

Ядуурлын төвшинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл

Малчин өрхийн амьжиргааны төвшинг харуулах нэг үзүүлэлт бол малын тоо толгой юм. 1999 онд 100 хүрэхгүй малтай өрхийн тоо нийт мал бүхий өрхийн 58 хувийг эзэлж байсан бол 2002 онд 69 хувь болж нэмэгдсэн. Харин малчин өрхийн хувьд авч үзвэл, тооцоогоор 1999-2002 онд 100 хүрэхгүй малтай малчин өрхийн тоо 20 гаруй мянгаар нэмэгдэж нийт малчин өрхийн 60 шахам хувийг эзлэх болсон байна. Ер нь нэг малчин өрх 200 аас цөөнгүй толгой малтай бол хэвийн амьжиргаатай байна гэж үздэг.

Мал хувьчлалаар олон мянган малчин өрх малтай болсон боловч мал маллах арга ухаан, дадлага туршлага дутсанаас, мөн байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас 1999-2002 онд малаа хорогдуулж амьжиргаа нь дордсон. 1990- 1999 оны цаг

агаар тааламжтай үед мал өсч олон малтай айл өрх олширсон. Харин 2000 оны зудын дараа олон малтай өрх цөөрч, огт малгүй, цөөн малтай өрхийн тоо нэмэгдсэн.

1999 оноос хойшхи ган, зуд нь малчдын ядуурлын төвшинг эрс нэмэгдүүлсэн. 1998 оноос хойш ядуурлын үзлэлтүүдийг улсын хэмжээнд судалж тогтоогоогүй байна. 2002 онд Үндэсний статистикийн газраас явуулсан өрхийн орлого, зарлагын судалгааны үр дүн нь хараахан гараагүй байна.

Судалгаа хийсэн 5 аймагт 1999 оноос 2002 оны хооронд малчин өрхийн малын тоо хонин толгойд шилжүүлснээр 16-46% цөөрчээ. Ган зуд Завхан аймагт хүнд туссан бөгөөд нэг өрхөд хамгийн цөөн мал ногдож байна.

Өрхөд ногдох малын тоо

Аймгийн нэр	Хонин толгойд шилжүүлсэн малын тоо			1999 онтой харьцуулсан хувь
	1999 он	2002 он	Зөрүү	
Булган	256	184	-72	-28%
Дундговь	334	200	-133	-40%
Завхан	229	124	-106	-46%
Төв	208	133	-75	-36%
Хэнтий	205	172	-33	-16%

Судалгаанд хамрагдсан малчин өрхийг малын тоогоор ангилахад Завханы 3 сумын малчдын 66% нь 100-аас цөөн малтай байхад Дундговийн 3 сумын малчин өрхийн 27% нь 100-аас цөөн малтай байв. Гэхдээ өрхөд ногдох малын тоо дангаараа амжиргааны төвшинг илэрхийлэх үзүүлэлт биш юм. Малын төрөл, сүргийн бүтэц, ашиг шим, зах зээлээс алслагдсан байдал амьжиргаанд нөлөөлж байна. Малчин өрх ган, зуд, байгалийн аюул бэрхшээлд малаа хорогдуулж ядуурах асуудал нь байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гадна өрхийн гишүүдийн амьдрах, мал маллах арга ухаан, туршлага, хүн хүч, хөрөнгө санхүүгийн нөөц, зах зээлд хүрэх боломж зэргээс шалтгаалж байна. Хэнтийн Дадал, Булганы Тэшиг сумдын малчид цөөн тооны ашиг шим сайтай үхэртэй, хадлан тэжээл сайн бэлтгэдэг, цөцгий, цөцгийн тос хийж, талх барьж, ногоо тарьж, өрхийн хэрэгцээгээ ч хангаж, зах зээлд ч борлуулж, ган зудаас шалтгаалахгүй амжиргаа сайтай байна.

Зудын өмнө Эрдэнэдалай сумын 3 өрх малгүй, 7 өрх амьжиргааны төвшнөөс бага орлоготой байжээ (сумын нийт өрхийн 0.4%). 2000 оны зудын жилд 100 айл ядуу өрхийн тоонд бүртгэгдэж (сумын нийт өрхийн 5.7%), дараа жил нь энэ тоо 173 (сумын нийт өрхийн 9.8%) болон нэмэгдсэн байна. 2001 онд огт малгүй 139 өрх бүртгэгджээ.

Судалгаанд хамрагдсан сум, багийн удирдлагууд ядуурлыг бууруулах арга хэмжээнүүдээс малжуулалт, мал аж ахуйг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөөд ажлын байр бий болгох, урт хугацааны, малчдад зориулсан бага хүүтэй, урт хугацааны зээлийн бодлого хэрэгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхийг дэмжих, найдвартай эрчим хүчээр хангах, мал аж ахуй, газар тариаланг хослуулах зэргийг чухалчлан үзэж санал болгосон байна.

Статистикийн мэдээгээр малчдын тоо 2002 онд 1999 оныхоос 30 мянгаар цөөрсөн байна. Насны хувьд ч өөрчлөгдөж байна. 16-35 насны залуу болон тэтгэвэрийн насны малчдын тоо 2000 оноос хойш жил дараалан цөөрч байна.

Судалгаа хийсэн аймгуудаас Төв аймгийн малчид хөдөлмөрөө, багаж хэрэгслээ хорших, хамтрах талаар илүү идэвхитэй байна. Байгаль цаг уурын бэрхшээл нь алслагдсан нутгийн малчдад хүрэх нийгмийн үйлчилгээ, зах зээлд хүрэх боломж нөхцлийг хүндрүүлж байгаагаас малчид төв, сууринд бараадах хандлагатай болж нүүдэл нэмэгдэн, үүний улмаас алслагдсан бэлчээр эзгүйтэж, төв, суурин газрын бэлчээр, усны даац хэтэрч, талхигдаж байна.

Малчдын эрүүл мэнд, сургуулийн хүүхдэд нөлөөлсөн нь

Санал асуулгын үр дүн

- Халуун хүйтэн, салхи шуурга, үер уснаас болж малчид өвчин тусах, аль нэг эрхтнээ хөлдөөж гэмтээх, тахир дутуу болох, амь насаа алдах явдал гарчээ.
- Мал сүргээ хорогдуулсан малчид сэтгэл санаагаар унах (66%), эрүүл мэнд муудах (26%), өрөнд баригдах (18%), хүүхэд сургуулиас завсардах (17%), хоол хүнсээр гачигдаж өлсөх (10%), архинд орох, гэр бүл салах, хулгай дээрэм хийж гэмт хэрэгт холбогдох, амиа хорлох зэрэг сөрөг үр дагавар гарсан байна.
- 89% нь өвчин туссан үедээ эмнэлгийн тусламж авсан байна. Харин эмнэлгийн тусламж авч чадаагүй малчид шалтгаанаа эмнэлгээс хол, эм тарианы болон шинжилгээ, эмчилгээний төлбөрийг төлж чадахгүй зэргээс болсон гэж хариулжээ.
- Судалгаанд хамрагдсан өрхийн 18% нь хүүхдээ сургуулиас завсардуулжээ. Шалтгаан нь мал маллахад хүн хүч дутагдсан, сургуулийн ном, дэвтэр, хэрэгсэл болон хүүхдийн гутал, хувцасыг бэлтгэх боломжгүй байсан гэж хариулжээ.

Малчдын шилжих хөдөлгөөнд нөлөөлсөн нь

Монгол шиг нүүдлийн уламжлал бүхий, шилжих хөдлөхөө төвөггүй хийж сурсан ард түмэнтэй улс орны хувьд макро төвшний нийгэм, эдийн засгийн болон байгаль цаг уурын хүчин зүйлсийн цогц нөлөөллийг хүн амын шилжих хөдөлгөөнөөр үнэлж болох юм. Сүүлийн хэдэн жилд Монголд “их нүүдэл” явагдаж байна. Өнгөрсөн 10 гаруй жилд хоёр төрлийн нүүдэл болсны эхнийх буюу 1990-1998 онд хотоос хөдөөд шилжих хөдөлгөөн давамгайлж байсан бол 1999 оноос хөдөөгөөс хотод шилжих нь эрчимшиж байна. Эхний шилжилт хөдөлгөөний гол шалтгаан нь эдийн засгийн шилжилт, бүтцийн өөрчлөлт, хувьчлалтай холбоотой байсан бол сүүлийн шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгаан нь жил дараалсан ган, зуд болон Газрын тухай шинэ хууль хэрэгжиж хот, суурин газрын хүн ам газар өмчлөх эрхтэй болсонтой холбоотой гэж үзэж байна. Газрын хууль хэрэгжиж эхэлсэн эхний жил болох 2003 онд 29 мянган айл өрх хөдөө орон нутгаас Улаанбаатарт шилжин ирсэн байна.

Хүн амын сүүлийн хэдэн жилийн шилжилт хөдөлгөөн нь хот, сууринд ажилгүйдэл, ядуурал, бэлчээрийн талхигдал, байгаль орчны бохирдлыг нэмэгдүүлж, нөөцийн хүртээмж болон нийгмийн үйлчилгээнд нэмэлт дарамт учруулж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын сургуулиудын анги дүүргэлт хэтэрч, 40-50 хүүхэдтэй хичээллэдэг боллоо. Зарим сургуулиудад анги танхим хүрэлцэхгүй, 3 ээлжээр, хичээлийн ба завсарлагааны цагийг богиносгон сургалт явуулж байна. Хүн амын шилжилт хөдөлгөөний одоогийн хурдыг тооцвол Улаанбаатар хотод жил бүр 5-6 сургууль

шинээр барих хэрэгтэй гэсэн тооцоо ч гарсан байна¹¹. Олноор шилжих хөдөлгөөнд Улаанбаатар хот болон Төвийн бүс их өртөж байна. Улаанбаатарт, 1995-2000 онд нийт 95.4 мянган хүн шилжин ирсний 39.5 мянга нь зөвхөн 1999 онд шилжин иржээ. 2002 оны статистик мэдээгээр хотын хүн ам 57.4% нь хот, суурин газарт амьдарч байгаагийн 34.2% нь Улаанбаатарт байна.

Засгийн газраас хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэхгүй, шилжих хөдөлгөөн энэ хурдаар цаашид өрнөвөл 2025 он гэхэд хүн амын 42% нь Улаанбаатарт амьдрах болно гэсэн тооцоо ч мөн гарчээ¹¹.

Санал асуулгын үр дүн

- Уур амьсгал өөрчлөгдөж, байгаль цаг уурын аюулт үзэгдлийн давтагдал нэмэгдэж байгаа ч олонхи малчид үүнээс сургамж авч, эл нөхцөлд зохицон нутаг орондоо малаа маллан амьдрах бодолтой байна. Санал өгсөн малчдын 65% нь нутаг орондоо амьдрах, 15% нь хот суурин бараадах, 4% нь байгаль, цаг уур тааламжтай өөр нутагт шилжих санал бодолтой байна. Үлдсэн нь энэ талаар яах учраа олоогүй байна.
- Шилжих хөдөлгөөний жишээг Эрдэнэдалай сумаар авч үзвэл, 1998 оноос хойш жил бүрийн шилжилт сумын айл өрхийн 2-5% байсан ба 5 жилд нийтдээ 328 айл шилжжээ.

Малжуулалт

1990- 1999 оны цаг агаар тааламжтай үед мал өсч олон малтай айл өрх олширсон. Харин 2000 оны зудын дараа олон малтай өрх цөөрч, огт малгүй, цөөн малтай өрхийн тоо нэмэгдсэн тухай өмнө өгүүлсэн.

Мөн санал асуулгад хамрагдсан малчдын 65% нь нутаг орондоо малаа маллан амьдрах хүсэлтэй байгааг дээр өгүүлсэн. Нутаг орондоо малаа маллан амьдрах хүсэл зоригтой малчдыг ядуурлаас гаргахад сайн чанарын мал л хэрэгтэй. Гэтэл ган зудын гамшгийн улмаас ядуурсан олон малчин өрх хязгаарлагдмал хүрээнд явагдсан малжуулалтанд хамрагдаж чадаагүй үлджээ.

Малчдыг малжуулах цогц бодлого, түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан аргачлал шаардлагатай байна. Малжуулалт, түүний зээлийг буцаан төлөх өнөөгийн дүрэм журам бодит амьдралд нийцэхгүй байна.

Малчдын хүнс

Санал асуулгын үр дүн

- Сдулгаанд хамрагдсан малчдын 10% нь хоол хүнс хомсдолтой, өлсдөг гэж хариулсан.
- Малчдын 58% нь хоол хүнсэнд зориулж сард 50 мянган төгрөгөөс илүүг зарцуулж чаддаггүй ажээ.
- Малчдын хүнсний бүтэц нь улирлын шинж чанартай, голчлон үхэр, хонь, адуу, ямааны мах, сүү, тараг, ааруул, аарц, цөцгий, гурил, будаа, давс, элсэн чихэр, ургамлын тос гэсэн цөөн хэдхэн зүйлээс бүрдэж байна. Малчид ногоог бага зэрэг хэрэглэж байна.

¹¹ Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний талаархи судалгааны материалаас, 2003 оны 11 сар

- Ядуу өрхийн хүмүүс хоногт авах ёстой хоол хүнсний элчлэгийн 58-68 хувийг авч байна гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Ялангуяа зудад нэрвэгдсэн аймаг, сумдын малчдын хувьд хоол хүнсээр гачигдах явдал их гарсан гэж санал асуулганд орсон малчид ярьж байна.
- Цаашид малчдын хоол хүнсний асуудлыг тэдний эрүүл мэндтэй холбон нарийвчлан судлах шаардлагатай.
- Малчид бол Монголын хүнсний голыг үйлдвэрлэгчид бөгөөд хот, сууринд амьдардаг үр хүүхэд, эцэг эх, хамаатан садан, зуны дэлгэр малчдын гэрт зочилдог айлчин гийчин, тавиул хүүхдийг үнэгүй хооллодог ачтай буянтай хүмүүс мөн.

Хүн амын хүнсний хамгамжийг авч үзэхэд мах үйлдвэрлэл дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ экспортод гаргаж байна. Статистик мэдээгээр нэг хүнд ногдох мах, махан бүтээгдэхүүн нэмэгдэж 120 кг болсон бол харин сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаас дотоодын хэрэгцээг хангаж чадахгүйд хүрч, импортын хэмжээ нэмэгдэж байна.

2001 онд мах үйлдвэрлэл нэмэгдэж, сүүний үйлдвэрлэл буурчээ. Хүнсний хангамжийн асуудалд мах, сүү чухал байр эзэлдэг бөгөөд цаашид ч эрчимжүүлэн хөгжүүлэх шаардлагатай. Махны экспорт мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Засгийн газар “Махны хөтөлбөр” батлан хэрэгжүүлж эхэлсэн. Цаашид мах боловсруулалтыг гүнзгийрүүлэх, ангилал, сав баглаа боодол, хадгалалтыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх шаардлага тавигдаж байгаа аж.

Хувьчлалын жилүүдэд сүүлийн фермууд задарснаар сүү сааль, сүүн бүтээгдэхүүний бэлтгэлд уламжлалт, өрхийн аж ахуй илүү үүрэг гүйцэтгэх болсон. 1990 онд 61.5 мянган тонн сүү үйлдвэрийн аргаар боловсруулагддаг байсан бол сүүлийн 2 жилд дөнгөж 1.3 мянган тонн сүү үйлдвэрт боловсруулагджээ.

Засгийн газар Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын талаархи Үндэсний хөтөлбөр 2001 оноос хэрэгжүүлж байгаа ба үүний үр дүнд нийт хүнсний үйлдвэрлэл, түүн дотроо малын гаралтай хүнс - мах, сүүний үйлдвэрлэлд ахиц дэвшил гарах ёстой.

4. Уур амьсгалын эрсдлийг бууруулж малчдын амьжиргааг дээшлүүлэхүй

Малчин өрхийн амьжиргаанд байгаль цаг уурын эрхшээлээс учирсан нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэл хохирлыг үнэлдэг, урьдчилан тооцоолдог, сэргийлэх арга хэмжээ шуурхай авдаг тогтолцоо байхгүй байна.

Малчин айл өрхийн амьжиргааны асуудалд байгаль, нийгэм, эдийн засгийн олон зүйл агуулагдаж байна. Гэтэл төр засаг, орон нутгийн удирдлага болон мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа хоорондоо уялдаагүй, мэдээ мэдээлэл нь цаг хугацаа, орон зайн масштабээр холбогдохгүй байна.

Манай улсад нөлөөллийн судалгаа, үнэлгээ, дүгнэлт баталгаа, төлөвлөлт хяналтын иж бүрэн систем бий болж хөгжсөн нэгэн туршлага байгаль орчны салбарт бий. Энэ нь 1990 ээд оны дунд үеэс суурь нь тавигдаад одоо хууль эрх зүй орчин, удирдлага хэрэгжүүлэлтийн бүтэц, зохион байгуулалт, байгууллага, боловсон хүчний тодорхой нөөц, шинжлэх ухааны үндэслэлтэй аргазүйн иж бүрдэл бүхий систем болтлоо хөгжсөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хяналтын тогтолцоо юм. Үүнээс сургамж авч нийгэм, эдийн засгийн тогтолцооны нөлөөлөл, эрсдлийн үнэлгээ, төлөвлөлт, хяналтын системийг бий болгууштай.

Сумдад хүрч буй ус цаг уурын үйлчилгээ

Судалгаа хийгдсэн сумдын 5 нь цаг уурын станцгүйгээс агаарын температурын хоног, сар, улирал, жил, олон жилийн дундаж үзүүлэлтийг гаргах боломжгүй, 3 нь ус цаг уурын ажиглалтын жил цөөн учир уур амьсгалын норм тогтоогоогүй байна. Иймд сүүлийн жилүүдэд болсон үзэгдлийг харьцуулах үзүүлэлт үгүй, эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ өгөхөд хүндрэлтэй байлаа. Мөн хөдөө аж ахуйд хамгийн их хэрэг болдог дулааны болон хүйтний улирлын төлөв байдал, сарын урьдчилсан мэдээнд олон жилийн дундаж утгаас их, бага байна гэж заадаг атал чухам тэр олон жилийн дундаж утга гэдэг нь тодорхойгүй нутаг оронд уг урьдчилсан мэдээг хэрхэн ойлгож хэрэглэх нь ойлгомжгүй юм.

Малчид тэнгэрийн байдлыг сар, улирлаар урьдчилан мэдэж амьдрал ахуйгаа зохицуулах хэрэгцээ их байна. Гэтэл сар, улирлын прогноз зохиох аргагүйг боловсронгуй болгох, таарцыг нь сайжруулах судалгаа шинжилгээний ажил бараг хийгдэхгүй байна. Энэ чиглэлээр одоо ажиллаж буй судлаач, мэргэжилтэн ч цөөн байна.

Сумын төвд байгаа цаг уурын станцын мэдээг тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын гадарга, байгалийн ялгавартай нөхцлийг тооцон буулгах аргагүй байхгүй байна.

Цаг уурын станцын хашаан доторхи ургамлыг бүртгэдэггүй, цөөн тооны ургамлаас бусдад ажиглалт хийдэггүй учраас мал иддэг олон төрөлзүйл ургамлын хөдлөлзүйн талаархи мэдээлэл хомс, ургамал, цаг уурыг холбож олон жилийн өөрчлөгдлийг судлах, цаашдын хандлагыг тогтоох боломж муу байна.

Уур амьсгалын өөрчлөгдөл ба бэлчээрийн судалгаа¹²

Манай улсад уур амьсгалын судалгаа тогтмол, нэгдмэл аргачлалтайгаар 1980-аад оны дунд үеэс эхлэн харьцангуй урт хугацаагаар хийгдэж арвин ашиглагдуун бүрдүүлж тэдгээрийн боловсруулалт ч багагүй хийгдэж 20, 40, 70, 100 жилийн дараах уур амьсгалын талаар зохих тооцоо, дүгнэлт, таамаг буй болжээ.

Үүнчлэн ургамал, ургамалжлын судалгаа ч багагүй хийгдэж ургамлын үзэгдэлзүйн дам үзүүлэлт - ургацын хэмжээ, хэлбэлзлэлийг эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн газрууд бараг нэлдээ хийж иржээ.

Харин дээрхи хоёрыг нэгэтгэсэн судалгаа олонгүй. Иймээс уур амьсгалтай холбогдох мэдээллийн зарим гол эх сурвалж: бэлчээр-ургамалжил үүсгэгч зонхилогч ургамлын уур амьсгалын өөрчлөгдөлд зохицох орчинзүй, аминзүйн чадавхи: үр, үржлийн ургал эрхтний ичмэл байдалд орших хугацаа, сэхэн ургах чадвар, K.S.R стратеги, үзэгдэлзүйн үе шат, тэдгээрийн хэлбэлзлэл, дүйвэлзэл (Fluctuatio), гадаад дотоод гарвалт уламлааны (Successio) хугацаа, талбай, чиг хандлага зэргийг судлаагүй буюу заримыг (ургамалжлын өөрчлөгдөл, ургамлын үзэгдэлзүй зэргийг) эхэлсэн ч дэлхий нийтээр хамгийн дулаан болсон сүүлийн арваад жилд орхигдсон байна.

Бэлчээрийн ургамлын судалгаа, үнэлгээний стандарт аргачлал байхгүй байна. Судалгааны байгууллага, мэргэжилтнүүд өөр өөрийн аргачлалтай, хоорондоо зохицолгүй, дүгнэлт, үр дүн нь зөрчилтэй, хэрэглэгчид буюу сум, багийн удирдлага, мэргэжилтнүүд энэ талаар нарийн ойлгоц мэдлэггүй, идэвхгүй, бүртгэл, судалгаагүй байна.

¹² Н.Манибазар

Бэлчээрийн төлөв байдал, хянан баталгааны нэгдсэн аргазүй байхгүй, хийгдсэн зураг, хээрийн судалгаа, бодит амьдралын хооронд зөрүүтэй байна.

Бэлчээрийн даацын анхан шатны өгөгдөл, үнэлгээний үзүүлэлт, аргазүйд мэргэжилтнүүд шүүмжлэлтэй хандаж байгаагийн зэрэгцээ үнэлгээний үр дүнг ч эргэлзээтэй гэж үздэг.

Зуны дэлгэр цагт хөдөө гарч явуулын, богино хугацааны судалгаа хийдэг хот газрын судлаач мэргэжилтнүүд орон нутаг, малчдын бодит хэрэгцээг хангах үр дүн гаргаж байгаа эсэх нь эргэлзээтэй. Нөгөө талаар орон нутгаас хотын судлаач мэргэжилтнүүдээр хийлгэх захиалга даалгаварт ажил үйлчилгээ бас дутагдалтай байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгал өөрчлөгдөж байгааг нуталсан эрдмийн хурал, мэдээлэл олширч ургамал ургаж эхлэх, цэцэглэх хугацаа хойшилсон, урагшилсан, уртассан богиноссон, түүгээр ч үл баран говийн хил хойшилж буй мэт яриа мэдээ түгсээр боловч тэдгээрийг ургамалзүйн талаас нь магадалж баримтжуулсан нь ч үгүй байна. Цаашилвал уур амьсгалын нөлөөллийн чухал үзүүлэлт - цөлжил, ус, салхины үүдэлтэй эвдрэл мэт нь ургамалжилзүйн баримт нуталгаагаар дутмаг байна.

Дээр дурьдсан шалтгааны улмаас IPCC-ийн гуравдугаар нэгдсэн тайланд¹³ Монголын өргөн уудам нутгийн ургамалтай холбоотой үг үсэг огт ороогүй гэж үзэж болохоор байна. Энэ бүхэн нь ургамал, ургамалжил буюу мал, амьтны бэлчээрийн ирээдүйн арван хоёр жил, жараны (25, 50, 100 жилийн дараахи) дүр төрхийг уур амьсгалын өөрчлөгдөлтэй уялдуулан гаргахын (IPCC-ийн TAR-ын Q8-д хариулахын) тул “өнөөдрөө” сайн мэдэхэд бэрхшээл учруулж байна.

Уур амьсгалын өөрчлөгдөл ба нийгэм эдийн засгийн судалгаа

Уур амьсгалын өөрчлөгдлийг олон жилээр тооцоолдог бол нийгэм, эдийн засгийн зорилго, зорилт, хөтөлбөрийг 5-10 жилээр л гаргаж байна. Иймд эдгээрийг хослуулан судлах нь төвөгтэй, ийм чиглэлийн судалгаа хийгдсэн нь ховор байна.

Нэг талаас малчдын амьжиргааг дээшлүүлэх нь малчдыг байнгын орлоготой болгох, ядуурлыг бууруулах, эрсдлийг багасгах, малчдын нийгмийн идэвх, нэгдэл нягтралыг нэмэгдүүлэхийг багтаасан өргөн ойлголт бөгөөд байгалийн нөөцийн нэн ялангуяа бэлчээрийн зохистой удирдлагыг бий болгохгүйгээр хэрэгжих боломжгүй юм. Нөгөө талаас малчдын амьжиргааг баталгаажуулахгүйгээр, ядуурлыг бууруулахгүйгээр бэлчээрийг зохистой ашиглаж чадахгүй, байгаль, цаг уурын өөрчлөгдөлд зохицох асуудлыг шийдвэрлэхэд улам бүр хүндрэлтэй байх болно. Ядуу малчин нь отор нүүдэл хийж бэлчээрийг сэлгээтэй ашиглах, эсвэл өндөр ашиг шимт мал бүхий фермийн аж ахуй эрхлэх боломж муутай байна.

Эдийн засгийн өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх явцад байгаль цаг уурын бодит нөхцөл байдлыг тооцож эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг үнэн зөв хийсний үндсэн дээр оновчтой бодлого, шийдвэр гаргаж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

¹³ Уур амьсгал өөрчлөгдлийн асуудлаархи Засгийн газар хоорондын мэргэжилтний хэсэг (IPCC) –ийн гуравдахь удаагийн нэгдсэн тайланд (Climate Change 2001: TAR Synthesis Report) авч үзсэн “Уур амьсгал өөрчлөгдөл судлалын тулгуур 9 асуудал”- ыг “Эрсдэл судлал” ажлын хэсгээс хийх уур амьсгалын судалгааны чиг, аргачлалын баримжаа болгосон.

Зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн системийн технолог хэрэглэх нь

Байгаль орчны яамны Мэдээллийн төвд дэлхийн хиймэл дагуулаас (ДХД) өдөртөө хэдэн удаа мэдээ авч буй боловч түүнийг уур амьсгалын аюул бэрхшээл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, ядууралтай холбох, ургамалжилзүйн утгаар ойлгож ашиглах, үнэлэх аргачлал өрөөсгөл, манай орны хувьд зүгшрээгүй, бодит амьдралд хэрэглэхгүй байна.

Хиймэл дагуулын мэдээгээр 10 хоног тутам бодож буй ургамалжлын индексийг зэрэгцээ оршиж буй Ус цаг уурын хүрээлэнгээс гаргадаг зуншлагын зурагт ашиглахгүй байна. Өргөн уудам нутагт цаг уурын ажиглалтын цөөн өртөө, харуулын мэдээллийг орон зайд интерполяци хийхэд хиймэл дагуулын мэдээлэл чухал ач холбогдолтой. Хиймэл дагуул ба газрын хэмжилтийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, төлөвлөлтөнд хэрэглэгдэх мэдээлэл бэлтгэх ажил дутагдалтай байна. Энэ талаар судалгаа хийх, аргазүй, мэдээллийн технолог боловсруулах шаардлагатай.

Төр засгийн зүгээс ч, эл ажлыг хариуцсан байгууллага, удирдлагын зүгээс ч хөгжингүй мэдээллийн технологийг эдийн засгийн үндсэн салбарууд, тухайлбал, мал аж ахуй, газар тариалангийн эрсдэл, байгалийн түргэн хувьсах нөөцийн мониторинг хийх, үнэлгээ өгөх, прогнозолх, мэдээлэл, мэдлэгт тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад ашиглах хэрэгсэл болгон нэвтрүүлэх талаар эрдэмтэн мэргэжилтний санал, санаачлагыг ойлгох, дэмжих ажил дутагдалтай байна.

2.2. Санал, зөвлөмж

1. Ядуурлыг бууруулах

Сүм, багийн удирдлага, ажилтны өгсөн санал, зөвлөмж

1. Судалгаанд хамрагдсан сум, багийн удирдлага, ажилтнууд ядуурлыг бууруулахын тулд дараах арга хэмжээ авахад түлхүү анхаарахыг зөвлөж байна:
 - Малжуулах
 - Мал аж ахуйг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх,
 - Мал аж ахуй, газар тариаланг хослуулах
 - Цаг ашиглалтыг бүх төвшинд сайжруулах
 - Зохистой хэрэглээний соёл нэвтрүүлэх
 - Хөдөөд ажлын байр бий болгох,
 - Малчдад зориулсан бага хүүтэй, урт хугацааны зээлийн бодлого хэрэгжүүлэх,
 - Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхийг дэмжих,
 - Найдвартай эрчим хүчээр хангах

Аюул, бэрхшээлтэй үед малчдад үзүүлэх нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох

2. Байгаль цаг уурын бэрхшээлд хохирол амссан үед сум, багаас малчидтай тулж ажиллах, сэтгэл санааны дэм үзүүлэх

3. Ган зудтай нөхцөлд төлбөрийн чадваргүй малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эмчлэх
4. Байгалийн гамшиг болсон нутагт хөнгөлөлттэй зээлийн бодлого хэрэгжүүлэх
5. Гамшигт малаа эрс хорогдуулсан айл өрхийн хүүхдэд хичээлийн хэрэгсэл, ном, дэвтэр, гутал хувцасны дэмжлэг үзүүлэх, дотуур байрны зардлыг хөнгөлөх

Ядуурлыг бууруулах бодлого хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс

6. Зудад малаа алдаж ядуурсан малчдыг ядуурлаас гаргахдаа дараах 3 ангилалаар ялгавартай хандах шаардлагатай¹⁴:
 - *Зудтай чадах ядахаараа тэмцсэн ч арга туршлага дутсан малчид*: Ийм малчдын мал маллаж амьдрах хүсэл зориг нь мохоогүй бол тэднийг малжуулах бодлого баримтлах, гэхдээ тэднийг дутуу төрсөн хүүхдийг “инкубаторт” бойжуулдагийн жишээгээр “гүйцэт торниулж биеий нь даалгах” цогц арга хэмжээ авах. Хэрэв тэд мал маллах хүсэл итгэлгүй болсон бол тэднийг амжиргаагаа залгуулах орлогын өөр эх үүсвэр олох ажил үйлчилгээ эрхлэхэд сургах, мэргэшүүлэх
 - *Зудтай тэмцэхэд дотоод нөөц боломж (хүн хүч, хөрөнгө мөнгө, гэх мэт) хүрэлцэхгүй байсан, гадны дэмжлэг тусламж дутсан малчид*: Мал маллахад зайлшгүй хүн хүч хэрэгтэй тул угаас бүл муутай ядуу айл өрхийг малжуулах нь үр дүн муутай байж болзошгүй. Иймд тэднийг малаас өөр ажил үйлчилгээ эрхлэх, зах зээлийн нөхцөлд амжиргаагаа залгуулах арга ухаанд сургаж мэргэшүүлэх, ажлын байраар хангахад анхаарах.
 - *Ажил муутай, арчаагүй, залхуу, хүмүүжил муутай малчид*: Ийм хүмүүсийг албадан хөдөлмөр хийлгэж “Эзэн хичээвэл заяа хичээнэ” гэдгийг ухамсарлуулж хүмүүжүүлэх, сургах. Ажилгүй эцэг эхийг төлөвшүүлэх хугацаанд үр хүүхдийг нь төр засаг, орон нутаг халамжиндаа авч хамгаалах, сургах, өсгөн хүмүүжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.
7. Ядуурлын асуудалд байгаль цаг уур, нийгэм, эдийн хүчин зүйлсийг тооцон цогц хандах, албан ба албан бус салбарын оролцоог тэгш хангахуйц нээлттэй сүлжээт тогтолцоог бий болгож ажиллуулах, шинжлэх ухаан, технологийн ололтыг уламжлалт мэдлэг, туршлагатай хослуулан хэрэглэж ядууралд хүргэж буй шалтгааны уг үндсийг олж арилгахад анхаарах
8. Ядууралтай холбогдох ямар мэдээлэл хаана байгаа талаархи лавлах мэдээллийн сан бүрдүүлэх, Интернэтэд нээлттэй, динамик Вэб ажиллуулах

Малжуулахад анхаарах зүйлс

9. Торниулах, өсгөх, үржүүлэх 3 шатлалт аргыг малжуулалтанд хэрэглэх:
 - Дундговийн Эрдэнэдалайн “Баянцагааны 30 хурга хуц” 3-шатлалт малжуулалтын туршилтыг өрхийн амьжиргааны эх үүсвэрийг хангах сүргийн бүтцийн хэмжээнд өргөжүүлэн тооцоо судалгааг нарийвчлан, аргачлалыг гүнзгийрүүлэн боловсруулж тодорхой сум, багт турших.

¹⁴ Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын малчин Н.Баярбатын зөвлөснөөр

- Малжуулалтанд хамрагдах ядуу айл өрхийг амьжиргаагаа даагаад явах төвшинд хүрэх 2-3 жилийн хугацаанд нь Инкубацид байна гэж тооцож дараах зүйлийг харгалзан үзэх
10. Ган зудад малаа алдаж цөөн малтай үлдсэн, цаашид малаа өсгөж амьжиргаагаа залгуулах хүсэл сонирхолтой айл өрхийг малжуулалтанд хамруулах, малчдын өөрсдийнх нь санал хүсэлтийг үндэслэл болгон малын төрөл, сүргийн бүтцийг хүн хүч, туршлагад нь тохируулах
 11. Малжуулах айл өрхийг нутгийн хүмүүсийн оролцоотойгоор нээлттэй шалгаруулах
 12. Малжуулалтанд хамрагдахаар шалгарсан айл өрхийг төр, орон нутаг (эсвэл хөрш зэргэлдээ халамжлан даах туршлагатай малчид), малчин өрхийн гурвалсан гэрээгээр “Инкубац”-д оруулах, гэрээний биелэлтийг улирал, хагас жилээр дүгнэж биелүүлээгүй нөхцөлд Инкубациас гаргах
 13. Малжуулалтанд хамрагдсан айл малаа өсгөж сүргийн бүтэц нь амьжиргааг нь хангахад хүрэлцэхүйц болох бодит байдлаар Инкубацид байх хугацааг тодорхойлох.
 14. Малжуулалтанд хамрагдсан айл 3 дахь жилээс эхлэн 3 жилийн хугацаанд малжуулалтаар авсан малаа буцаан өгч тухайн орон нутгийн “Төмөр сүргийг” бүрдүүлэх. Мал буцаан өгөх хуваарь болон малын тоо, төрөл, хүйс, насыг гэрээгээр тохирох хэрэгтэй.
 15. Инкубацид байх хугацаанд дараах дэмжлэг үзүүлэх:
 - Тухайн айлын ам бүлийн тоогоор гурил, будаа, цай, давс, элсэн чихэр зэрэг хүнсний, алчуур саван оо сойз зэрэг ариун цэврийн гол хэрэглээний зүйлээр улирлын давтамжтай хангах
 - Өрх бүрийг халамжлан хүмүүжүүлэгчид хариуцуулж өрхийн гишүүдийг сургаж дадлагажуулах: Уламжлалт мал маллагааны арга эзэмшүүлэх, малын гэжээл бэлтгүүлэх, өрхийн аж ахуй эрхлэхэд сургах, нэмэлт орлого олох арга эзэмшүүлэх
 - Малын үүлдэр, чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
 - Бэлчээр, отор нүүдэл, хашаа бууцын зохицуулалт хийх
 - Малжуулахаар өгсөн малы нь даатгуулах. Үүнд даатгалын төлбөрийн 50-иас доошгүй хувьд хөнгөлөлт үзүүлэх
 - Инкубацид байх, түүнээс гарсны дараахи 3 жилд элдэв татвараас чөлөөлөх

2. Малчдыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх¹⁵

Эдийн засгийн хувьд бэхжүүлэх

Улс, орон нутгийн хэмжээнд малчдын хөрөнгө, орлогыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах хэрэгтэй. Үүний тулд:

16. Малчдын хөрөнгө, орлогыг нэмэгдүүлэхэд, мөн тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд ямар хувь нэмэр оруулж байна вэ гэдгээр нь хөгжлийн стратеги, үндэсний хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдийг

¹⁵ М.Мэндбилэг, С.Пүрэвсүрэн, Н.Баярбат, Г.Бизъяа нарын зөвлөснөөр

үнэлэх, хэрэгжилтийн байдлыг бодит байдалд судлах, үнэлгээ өгөх, санал зөвлөмжид тусгах

17. Малчдын хоршоог дэмжин хөгжүүлэх
18. Сумдад малчдын хоршоололд түшиглэн МАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг үйлдвэрийг хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх
19. Залуу малчдын сургуулийг сумдад байгуулж тогтмол ажиллуулах, малчдыг зах зээл, удирдлагын арга ухаан болон байгаль цаг уурын бэрхшээлд мал сүргээ хамгаалах арга ажиллагаанд сургадаг тогтолцоог бий болгох
20. Зах зээлээс алслагдсан байдал болон байгаль цаг уурын эрхшээлийг тооцсон уян хатан татварын бодлого хэрэгжүүлэх, үхэр болон тэмээ өсгөхийг дэмжих, малчдын орлогод нэмэр өгдөггүй тугал, ботго, унагыг эхний 2 жилд 5 хонин толгойгоор бодож татвар оногдуулдагийг өөрчлөх
21. Судалгааны ажлыг нэгэнт гарсан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд тус болох тодорхой санал дэвшүүлэх, турших, аргазүйн зөвлөмж гаргахад чиглүүлэх, мөн салбар дундын асуудлыг уялдуулахад тус болох аргазүй боловсруулах судалгаанд түлхүү анхаарах

Зах зээлийн эрсдлийг бууруулах

22. Малчдыг зах зээлийн эрсдлээс хамгаалах тогтолцоо бий болгох:
 - Сумын төвд хүнс, түүхий эдийн бөөний цэг байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
 - Гадны зах зээлийн нөлөөгөөр үнийн хэлбэлзэл ихтэй байгаа арьс шир, ноолуур зэрэг түүхий эдийг худалдан авч үндэсний үйлдвэрүүдэд борлуулж малчид, үйлдвэрлэгчдийн эрсдлийг бууруулах механизм, тогтолцоо бий болгох

3. Байгаль цаг уур өөрчлөгдөж буй нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулах

Судалгаанд хамрагдсан малчдын өгсөн санал, зөвлөмж

23. Өөрчлөгдөж буй байгаль, цаг уурын нөхцөлд мал аж ахуйн эрсдлийг бууруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ?
 - Бэлчээрийг усжуулах, хамгаалах
 - Малын хашаа хороог сайжруулах
 - Сумын эрсдлийн сан байгуулах, бэхжүүлэх
 - Мал аж ахуйг эрчимжүүлэх
 - Өвлийн бэлтгэлийг сайжруулах
 - Бэлчээр нутгийг оновчтой сонгох, отор нүүдэл хийх
 - Малчдын хоршоо байгуулах
 - Байгаль цаг уурын таатай нөхцлийг сайн ашиглах
24. Уур амьсгалын өөрчлөгдөлд зохицохын тулд малчид юу хийх вэ?
 - Хадлан тэжээл бэлтгэх
 - Малаа чанаржуулах: үүлдэр угсааг сайжруулах, чийрэгжүүлэх, сүргийн бүтцийг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх
 - Хашаа хороо бууцаа бэлтгэх, дулаалах

- Мал маллагаанд анхаарах, малдаа тарга хүч авахуулах
 - Отор нүүдэл хийх: Бэлчээрээ зөв сонгох, 4 улиралд зохицож нүүх (өвөл өнтэй орох, хавар хавсрага бага тавих, зун бороо ногоо сайтай нутаг сонгох г.м.)
 - Бэлчээрийн усан хангамж: худаг ус гаргах, дулаалах, хамгаалах
 - Хувийн бэлтгэл хангах: хувцас хунар, хоол хүнс, унаа хөсөг, бэлэн мөнгө, малаа даатгуулах
25. Уур амьсгалын өөрчлөгдөлд зохицохын тулд аймаг, орон нутгийн удирдлага юу зохион байгуулах вэ?
- Малчидтай тулж, хамтарч ажиллах: малчдын холбоо байгуулахад туслах, малчдын хорших тал дээр анхаарч хоршоо байгуулахад нь туслах, ядуу хүмүүсийг харж үзэх, малчдад анхаарал тавих, малчдын саналыг уламжлах, малчидтай хамтарч ажиллах
 - Чанар сайтай эцэг мал олж малыг чанаржуулах
 - Өвс тэжээл: ган зуд, цаг агаар хүндэрсэн үед малчдад зээлээр өвс тэжээл өгч дараа нь төлүүлэх, хямд өвс тэжээлээр хангах, өвс тэжээлийн тусламж үзүүлэх
 - Хүн, малын эрүүл мэндэд анхаарах
 - Отор нүүдэл: отор нүүдэл хийх гарц олж өгөх, отрын нутаг сонгоход туслах, отор хийх бүс нутгийн гэрээ хэлэлцээрийг эрт тохирч өгөх, оторт хол нүүх шаардлагатай болж байгааг анхаарч сайн зохион байгуулах
 - Бусад: Худаг усыг нэмэгдүүлэх, Гэрэл цахилгаантай болгох, Тусламж дэмжлэгийн ажлыг шударга сайн зохион байгуулах, Залуучуудад хуулийн сурталчилгаа хийх
26. Уур амьсгалын өөрчлөгдөлд зохицохын тулд төр, засаг юуг дэмжих, бодлого, шийдвэртээ юу тусгах вэ?
- Өвс тэжээл: өвс тэжээлийн фонд бий болгох, цаг агаар хүндэрсэн үед малчдыг хямд үнэтэй өвс тэжээлээр хангах, тэжээлийн нөөцийг нэмэх,
 - Үнийн зохицуулалт, татварын хөнгөлөлт: малын татварыг хөнгөлж анхаарах, татвар, газрын татаас бууруулах, малын хөлийн татварыг зохицуулах, малын бүтээгдэхүүний үнийг өсгөх, түүхий эдийн үнийг зохицуулах, бензиний үнийг хямдруулах, үнийг тогтворжуулах боломжийг хангах түүхий эд, тэжээлийн бааз бий болгоход дэмжлэг үзүүлэх, алсын отор нүүдэл хийхэд татвар авдаггүй болох
 - Малчдын амьжиргаа: амьжиргаа дээшлүүлэх төсөл арга хэмжээг үе шаттай, үр дүнтэй явуулах, малчдын ахуй амьдралыг төрийн бодлогоор онцгой анхаарч зохицуулах, малчдыг төрийн бодлогоор дэмжиж туслах, ажлын байр бий болгох, малжуулах
 - Бэлчээрийн менежмент: ус, бэлчээрийн асуудлыг зохицуулах, бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах, уст цэгийг олшруулах, отрын бүс нутагт худаг ус гаргах
 - Бусад: Малчдын амьдралд хэрэг болох бодлого шийдвэрийг нээлттэй байлгах, төр засгийн бодлого шийдвэр шударга байх, олон түмэнд ойр дотно байх, малын даатгал, хамтарч ажиллах, хоршоо байгуулахыг бодлогоор дэмжиж зохицуулах, сум багийн дарга нар үнэн зөв мэдээлэл цаг тухайд нь өгдөг болгох, эрүүл мэнд сурч боловсрох орчин нөхцөл бүрдүүлэх, шударга байдлыг бий болгох, хил хязгаарын маргааныг зогсоох

Ус цаг уурын үйлчилгээг сум, баг, малчин өрхөд хүргэх

27. Ус цаг уурын мэдээллийг сум, баг, малчдын хэрэгцээг хангахуйцаар нарийвчлан сайжруулах:

- Сум бүрт ус, цаг уурын үзүүлэлтийн хоног, сар, жилийн дундаж утга бодох, уур амьсгалын норм тогтоох, цаг уурын станцын мэдээллийг орон зайд интерполяци хийх аргагүй боловсруулж нэвтрүүлэх, ус цаг уур, уур амьсгалын үзүүлэлтийг бэлчээрийн ургамал, хөрс, малын талаарх мэдээлэлтэй уялдуулан мал аж ахуй, бэлчээрийн менежментэд хэрэглэх
- Байгаль, цаг уурын эрс, гаж үзэгдлийн “Аюулын бүс”-ийг сумын нутгаар нарийвчлан тодорхойлж, сум, баг, малчдад хүргэн үйлчлэх аргагүй, технолог боловсруулан нэвтрүүлэх
- Ус цаг уурын дунд, урт хугацааны прогнозын агуулгыг баяжуулж, чанар, хэлбэрийг сайжруулах, энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэн гүнзгийрүүлэх
- Орон нутгийн удирдлага, малчдын хэрэгцээг хангахуйц байгаль цаг уурын мэдээллээр шуурхай үйлчлэх зах зээлийн механизм, хариуцлагын тогтолцоог бий болгох

Эрсдлийг бууруулахын тулд ойрын хугацаанд авах арга хэмжээ

28. Багийг аравтын зохион байгуулалтанд оруулж шуурхай мэдээлэл, хяналт удирдлагын бүтэц бий болгон малчин өрхийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, хөрөнгө, орлогыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаардаг болох

29. Мал тооллогыг жилийн эцсээр хийх, харин тоо толгойн өөрчлөгдлийг баг, сумдад улирал, хагас жилээр гаргадаг болох, улмаар малчин өрхийн эмзэг байдал, сум, багийн төвшинд эрсдлийн үнэлгээ хийж эрсдлийг бууруулах арга хэмжээг байнга төлөвлөн хэрэгжүүлдэг тогтолцоо бий болгох. Үүний тулд:

- Бэлчээрийн мал аж ахуйн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээний экспертийн системийг бий болгоход хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- НҮБХХ-ийн “2000 оны зудын сургамж”, “Гамшгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох” төслүүд, Улсын Иргэний хамгаалалт, Ус цаг уурын хүрээлэн, ЖЭМР Зөвлөгөө өгөх компани, Эрсдэл судлах ажлын хэсгээс 2000-2003 онд хийсэн судалгааны ажлын үндсэн дээр боловсрогдсон “Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг үнэлж, болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх аргачлал”-ыг Ховд, Хэнтий аймгийн сумдын Тамгын газрын дарга нар, иргэний хамгаалалт, ус цаг уур, мэдээллийн технологийн байгууллага, мэргэжилтнүүд оролцсон олон удаагийн хурал семинарт хэлэлцүүлж, 2002 оны 3 сарын 18-21– ний нийт нутгийг хамарсан онц аюулт салхи шуурга, Хэнтийн Өмнөдэлгэр сумын нутагт ган зуд, шуурга, тарваган тахал, ой хээрийн түймэр болон малын халдварт өвчин, Завхан аймагт мал өвөлжилт, хаваржилтын төлөвлөгөө хийх жишээн дээр туршиж улам нарийвчлан сайжруулсаар байгаа тул цаашид ядуурлын судалгаа хийгдсэн бусад сум, багт нэвтрүүлэх
- Эрсдлийн үнэлгээг мал сүрэг, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн даатгалд хэрэглэдэг болох

- Өрхийн амьжиргаанд байгаль цаг уурын хүчин зүйлийн үзүүлдэг нөлөөллийг жилд 2 удаа үнэлдэг, мөрөөр нь арга хэмжээ авдаг болох
 - 24 улиралтай каледар хэрэглэж цаг уур, бэлчээр, мал, малчин өрхийн амьжиргааны өгөгдөл, мэдээллийг уялдуулан холбох
30. Сум, аймгийн төвшинд олон төрлийн мэдээллийг цуглуулах, хуримтлуулах, нэгтгэн боловсруулахад өгөгдлийн сүлжээ, хөгжингүй мэдээллийн технолог хэрэглэх

Эрсдлийг бууруулахын тулд дунд хугацаанд авах арга хэмжээ

31. Амьд тэмээний ашиг шим өндөр байх бодлогоор тэмээ өсгөж үхрийн хорогдлыг нөхөх
32. Нутгийн байгаль цаг уурын нөхцөлд дассан, тэсвэр сайтай, бие томтой, ноос ноолуур, мах, сүүний гарц нь илүү эцэг мал олж хээлтүүлэх, үр төлийг нь хамгаалан өсгөх, малын цус ойртохоос урьдчилан сэргийлж хээлтүүлэгчийг 2 жил тутам сэлгэх замаар мал аж ахуйг эрчимжүүлэх, малыг эдэлж чанаржуулах
33. Уур амьсгал өөрчлөгдлийн төлвийг улс, аймаг, сумын төвшинд 5, 10 жилээр гаргах
34. Уур амьсгалын өөрчлөгдлийн төлвийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегийн бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтанд ашигладаг болох
35. Уур амьсгалын өөрчлөгдлийн улмаас нийгэм, эдийн засагт, ялангуяа хөдөө аж ахуй болон айл өрхийн амьжиргаанд учирч буй нөлөөллийг 3-5 жил тутамд үнэлж мөрөөр нь арга хэмжээ авдаг тогтолцоо бий болгох

Бэлчээр хамгаалах, ашиглалтыг сайжруулах

36. Дэлхийн уур амьсгалын өөрчлөгдлийн нөхцөлд нүүдлийн мал аж ахуйг хөтлөх арга замыг зохицуулах баримтлал, арга барилыг боловсруулах нь тулгамдсан асуудал болж буй тул цаашид бүс, аймаг, сум бүрт малын бэлчээрийн ургамалжил, ургацыг нарийвчлан судалж, бэлчээрийн даац, талхигдал, цөлжилт зэрэг асуудлыг тодруулах шаардлагатай.
37. Говь, хээрийн бүсэд түлшний шинэ эх үүсвэр – шингэрүүлсэн хийг бодлогоор дэмжин нэвтрүүлэх
38. Бэлчээрийн хөрс, ургамлын судалгааны стандарт арга зүйтэй болох, энэ чиглэлийн судалгааны ажлын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулж, улмаар бодлого шийдвэр боловсруулах, сумын газар ашиглалт / бүрхэвчийн зураг хийж бэлчээрийн менежментэд хэрэглэдэг болох
39. Бэлчээрийн хөрс, ургамлын өөрчлөгдөл, хувьслын мониторингийн судалгааг хөхиүлэн дэмжиж үр дүнг нь бэлчээрийг хагас жил, улирлаар зохистой ашиглахад хэрэглэдэг болох
40. Бэлчээрийн усан хангамж, ургамал, тэжээллийн нөөцийг бодитой үнэлж сум, багийн удирдлага, малчдыг тогтмол үйлчлэх механизм, тогтолцоо бүрдүүлэх

2.3. Туршилт

Туршилт 1: Мал аж ахуйн эрсдлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх аргачлал

Хэрэгцээ:

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг байгалийн аливаа эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ

Хүн хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, 2003

Мал өвөлжилт, хаваржилтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж, сумын ИТХ батлуулан хэрэгжүүлэх..

Малыг ган зудаас хамгаалахад туслах Үндэсний хөтөлбөр, 2001

Зудын эрсдэл, байгаль цаг агаарын аюул, гамшиг хохирлыг бодитойгоор үнэлэх, баримжаалах, тооцоолох аргачлал боловсруулж бүх төвшинд шийдвэр гаргахад хэрэглэх

Эл туршилтын хүрээнд сум, багийн төвшинд бэлчээр, мал, малчин өрхийн эмзэг байдал, ган зуд, цасан ба шороон шуурга, хүн, малын халдварт өвчин, ой хээрийн түймэрт өртөх аюул, эрсдлийг үнэлэх, улмаар эрсдлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх аргазүйг турших ажлыг гүйцэтгэсэн. Туршилтыг Хэнтий, Завхан, Дундговь аймгийн нийт 12 суманд хийсэн. Туршилтын үр дүн, аргачлалыг Хэнтий, Ховд, Завхан аймагт болон Улаанбаатар хотод аймаг, сум, багийн удирдлага, мэргэжилтэн оролцсон семинараар шүүн хэлэлцсэн. Мөн малчин өрхийн индекс бодох, хөрөнгө, орлоготой уялдуулан судлах ажлыг гүйцэтгэсэн. Туршилт бүхэлдээ сайн үр дүнтэй болсон ба аргазүйг нэгтгэн батлуулах, улмаар сум, багийн төвшинд нэвтрүүлж болох дүгнэлт гарсан.

Туршилтын зарим үр дүнгийн талаар доор сийрүүлэв:

- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын эрсдлийн судалгаа
- Завхан аймгийн говь, хээрийн 9 сумын эрсдлийн судалгаа
- Завхан аймгийн Идэр сумын Мануустай багийн эрсдлийн судалгаа
- Өрхийн индекс хэрэглэсэн нь
- 24 улирлалт календарь хэрэглэсэн нь
- Дундговь аймагт шингэрүүлсэн хийн түлш хэрэглэх талаар туршилт, судалгаа
- Үхэр хорогдвол тэмээ өсгөх


Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум:

Ган зуд, шороон ба цасан шуурга, ойн түймэр, тарваган тахал, малын боом, шүлхий өвчний эрсдлийн үнэлгээ хийх, эрсдлийг бууруулах ажлыг төлөвлөх аргыг туршсан. Энэ ажлын үр дүн:

- Сумын тамгын газрын дарга нараас авсан санал асуулга, эхний дүн шинжилгээ, тайлан

- Өнгөрсөн хугацаанд болсон аюулт үзэгдэл, гамшгийн сургамж
- Өнөөгийн байдал, ирэх зуны цаг агаарын төлөв байдлын прогнозад тулгуурласан өнөөгийн ба болзошгүй эрсдлийн үнэлгээ
- 5 төрлийн аюул тус бүрээр эрсдэлтэй газар нутгийн зураглал
- Аюул тус бүрээр эрсдлийг бууруулах төлөвлөгөөний загвар

Туршилтын явцад хийсэн эрсдлийн үнэлгээний зургийн жишээг доор харуулав.



Зураг 2.1 Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум, ган зуд, цасан ба шороон шуурганы эрсдлийн үнэлгээний зураг

Завхан аймгийн говь, хээрийн 9 сум

Туршилтын явцад говь, хээрийн бүс, сумын хилийг гаргаж аюулт үзэгдлийн жагсаалт гаргаад үзэгдэл тус бүрээр давтамж ихтэй нутгийн хил, бүсийг тодорхойлсон. Бэлчээр, мал, малчин өрхийн эмзэг байдлыг үнэлсэн, аюулт үзэгдэл тус бүрээр болзошгүй нөлөөллийг гаргасан, өнгөрсөн зудын болон аюулт үзэгдэл тус бүрээр сургамжийг бичсэн. Эцэст нь 2003-2004 оны өвөлжилт, хаваржилтын эрсдлийг бууруулах төлөвлөгөө гаргасан.

Хүснэгт 2.4. Завхан аймгийн говь, хээрийн сумдын аюулын үнэлгээ

	Сумын нэр	Салхи шуурга	Харын зуд	Их цас	Их хүйтэн	Онооны нийлбэр	Сумын зэрэглэл
1	Алдархаан	2	2	3	3	10	3
2	Дөрвөлжин	3	3	1	3	10	3

3	Завханмандал	3	3	1	2	9	4
4	Сантмаргац	2	3	1	2	8	5
5	Ургамал	3	3	1	2	9	4
6	Цагаанхайрхан	2	1	2	3	8	5
7	Цагаанчулуут	3	3	3	3	12	1
8	Шилүүстэй	3	2	3	2	10	3
9	Эрдэнэхайрхан	3	3	3	2	11	2
	Онооны нийлбэр	24	23	18	22	87	
	Аюулт үзэгдлийн зэрэглэл	1	2	4	3		

Тайлбар: Аюул их 3 Дунд 2 Аюул бага 1

Дүгнэлт: Аюулын үнэлгээгээр бэлэн байдлын зэрэглэлийг тогтооно. Дээрх жишээнээс харахад хамгийн их аюул учруулах нь хүчтэй салхи шуурга, хар зуд ба Цагаанчулуут, Эрдэнэхайрхан сумын хувьд бэлэн байдлыг хангах асуудлыг илүү анхаарах хэрэгтэй байна.

Хүснэгт 2.5. Бэлчээрийн өртөнгийн үнэлгээ

	Сумын нэр	Элсэрхэг хөрстэй, ургамал сийрэг, %	Үлийн цагаан оготонд идэгдсэн, %	Хадлан	Ургамлын төрөлзүүл цөөрсөн	Дундаж, %	Сумын зэрэглэл
1	Алдархаан	15	0	0	70	21%	8
2	Дөрвөлжин	40	10	10	50	28%	6
3	Завханмандал	30	20	10	60	30%	4
4	Сантмаргац	15	0	0	60	19%	9
5	Ургамал	40	10	5	60	29%	5
6	Цагаанхайрхан	25	5	0	70	25%	7
7	Цагаанчулуут	30	15	10	70	31%	3
8	Шилүүстэй	40	0	60	100	50%	1
9	Эрдэнэхайрхан	60	0	30	70	40%	2
	Онооны нийлбэр	33%	7%	14%	68%		
	Бэлчээрийн зэрэглэл	2	4	3	1		

Дүгнэлт: Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумын бэлчээрийн өртөнгийн зэрэглэл илүү байна.

Хүснэгт 2.6. Малын өртөнгийн үнэлгээ

	Сумын нэр	Тарга хүч муу	Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаагүй	Хашаа хороо муу	Өвс хадлан бэлтгээгүй	Хуижр бэлтгээгүй	Гар гэжээл бэлтгээгүй	Усан хамгамж муу	Хуурай бууцны нооц	Дундаж, %	Сумын зэрэглэл
1	Алдархаан	0	0	10	0	0	0	0	25	4%	7
2	Дөрвөлжин	5	0	40	10	0	0	40	60	19%	3
3	Завханмандал	3	0	50	0	0	0	40	60	19%	3
4	Сантмаргац	4	0	30	10	0	30	20	40	17%	5
5	Ургамал	10	0	30	0	0	0	40	60	18%	4
6	Цагаанхайрхан	0	0	65	0	0	0	30	50	18%	4
7	Цагаанчулуут	5	10	0	14	47	30	30	70	26%	1
8	Шилүүстэй	5	0	10	0	0	0	25	70	14%	6
9	Эрдэнэхайрхан	0	0	40	20	0	30	30	40	20%	2
	Онооны нийлбэр	4%	1%	31%	6%	5%	10%	28%	53%		
	Малын үзүүлэлтийн зэрэглэл	7	8	2	5	6	4	3	1		

Дүгнэлт: Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумын мал илүү эмзэг ба 2003-2004 оны мал өвөлжилт, хаваржилтанд хуурай бууц бэлтгэх, хашаа хороогоо сайтар янзлах нь чухал байна.

Хүснэгт 2.7. Малчин өрхийн өртөнгийн үнэлгээ

	Сумын нэр	Малчин өрхийн тоо	Түлш муутай	Дулаан хувцас муутай	Хоол хүнс муутай	Хүн хүч хүрэлцээгүй	Дундаж, %	Сумын зэрэглэл
1	Алдархаан	340	15	0	0	25	10%	4
2	Дөрвөлжин	320	16	6	0	22	11%	3
3	Завханмандал	240	30	0	0	15	11%	3
4	Сантмаргац	330	10	0	0	20	8%	5
5	Ургамал	395	29	3	0	30	16%	1
6	Цагаанхайрхан	358	0	50	0	15	16%	1
7	Цагаанчулуут	330	0	20	10	20	13%	2
8	Шилүүстэй	482	10	0	0	20	8%	5
9	Эрдэнэхайрхан	350	20	0	0	30	13%	2
	Онооны нийлбэр		14%	9%	1%	22%		
	Өрхийн үзүүлэлтийн зэрэглэл		2	3	4	1		

Дүгнэлт: Ургамал, Цагаанхайрхан сумын малчид илүү эмзэг байна. 2003-2004 оны өвөл хавар хүн хүч дутагдалтайн дээр түлш бэлтгэх асуудал чухал байна.

Дараах хүснэгтэд аюул, өртөнгийн үнэлгээг нэгтгэн эрсдлийг үнэлсэн жишээг харуулав.

Table 2.8. 2003-2004 оны өвөлжилт, хаваржилтын эрсдлийн үнэлгээ

	Сумын нэр	Аюулын зэрэглэл	Эмзэг байдлын зэрэглэл	Эрсдлийн зэрэглэл
1	Алдархаан	3	4	4
2	Дөрвөлжин	3	3	3
3	Завханмандал	4	2	3
4	Сантмаргац	5	4	6
5	Ургамал	4	2	3
6	Цагаанхайрхан	5	3	5
7	Цагаанчулуут	1	1	1
8	Шилүүстэй	3	3	3
9	Эрдэнэхайрхан	2	1	2

Дүгнэлт: 2003-2004 оны өвөл, хавар Цагаанчулуут, Эрдэнэхайрхан сум илүү эрсдэлтэй байна. Болзошгүй хорогдлоос сэргийлэх арга хэмжээг сайтар төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.

Завхан аймгийн Идэр сумын Мануустай багийн 2003-2004 оны өвөл, хаврын эрсдлийн үнэлгээ, эрсдлийг бууруулах төлөвлөгөө

Мануустай баг нь 172 өрх, 686 хүн амтай, 15 мянга 300 малтай. Их цас орох, эрс хүйтрэх, хүйтэн цасан шуурга тавих зэрэг аюулт үзэгдэл болдог. Ямаат, Жаргалант, Шургахын эх, Зүүн эхэд их цас ордог, Шургахын эх, Зүүн эх, Толгодоод хүйтэн цасаар шуурдаг бол их хүйтний голомтууд Шургах, Манхан, Төмөрт, Цоортын хоолойнууд болон Идэрийн голын хөндийд байдаг ажээ.

Туршилтад Мануустай багийн Засаг дарга, Идэр сумын төвийн мэргэжилтнүүд оролцсон. Туршилтын явцад их цас, их хүйтэн болон цасан шуурганы бүс, голомтын зураглал хийж, тэндхийн бэлчээрийн байдал, тэнд өвөлжих мал, малчдын эмзэг байдлаг үнэлсэн. Энэ үнэлгээний үндсэн дээр өвөлжилт, хаваржилтын төлөвлөгөөний төсөл гаргасан.

Их цасанд өртөж болзошгүй Ямаат, Жаргалантад эрсдлийг бууруулах талаар хийгдэх ажлыг жишээ болгон доор харуулав. Энэ газрууд нь сумын төвөөс 67 км, багийн төвөөс 53 км зайд байдаг. Тэнд 9 малчин өрхийн 1250 мал өвөлжинө. Жаргалантад өвөлжих 2 айл өвс хадлан, гар тэжээлээ гүйцэт бэлтгэж чадаагүй, хуурай бууцгүй, эмчийн үзлэг, үйлчилгээ шаардлагатай 1 хүн байдаг тул эмзэг байдлын зэрэглэл өндөр, эрсдэл ихтэй гэж үнэлэгдэв.

Хүснэгт 2.9. Эрсдлийг бууруулах төлөвлөгөөний жишээ

Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Шаардаг-дах хөрөнгө	Хөрөнгийн эх үүсвэр
Жаргалантын 2 айлд өвлийн цаг агаарын төлвийг танилцуулж, өвс тэжээл, хуурай бууц бэлтгэх талаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх	Х.10 - 20	Багийн ЗД, суурийн ахлагч	80000	Малчин
Малыг заазлах ажлыг зохион	Х.20 - XI.10	Багийн ЗД,		

байгуулна		суурийн ахлагч		
Нэмэгдэл тэжээлийн малыг ялгаж тэжээлд оруулах	XI.1 - III.1	Малчин	20 богт 115200 төг	Малчин
Бог малын шилбийг хамгаалах 130 бог	XI.1 - III.1	Малчин	10000 төг	Малчин
Бүх өрхийн хүн амд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх, өргөн хэрэглээний эмийн сангай болгох	X.1, I.10	Сум, багийн эмч	20000 төг	Төсөв
Жирэмсэн эх, нярай хүүхэд, өндөр настан, архаг хууч өвчтэй хүүхдийг сумын төвд байршуулах	X.1, I.10	Сум, багийн эмч	30000 төг	
Дүн			250 000	




Дүгнэлт: Их цасны бүсэд өвөлжих 9 айлын эрсдлийг бууруулах арга хэмжээ нь 250 мянга орчим төгрөгт багтах тооцоо гарч байна. Сумын төсвөөс эмнэлгийн үйлчилгээний 20 мянган төгрөгийг гаргана. Үлдсэн 230 мянган төгрөгийг малчид гаргана. Эмзэг бүлгийн 2 өрхийн өвлийн бэлтгэлд 50 мянга орчим төгрөг хэрэгтэй, сумаас үүнийг гаргах боломжгүй тул үүнийг багийн дарга, хэсгийн ахлагчтай хамтран зохион байгуулж хамаатан садан, хөршийнх нь оролцоо дэмжлэгтэйгээр өвс тэжээл, түлш бэлтгэх ажлыг хангана.

Хялбаршуулсан өртөг-үр ашгийн тооцоогоор Мануустай багийн 22800 толгой малын зах зээлийн үнэ 600 сая төгрөг (Үүнээс 500 сая нь мал, 100 сая нь түүний нэг жилийн ашиг шим), өвөлжилтийн бэлтгэлийн нийт зардал айл өрхийн төвшинд 20 сая орчим, сум болон аймгийн эрсдлийн сангаас тус бүр 6 сая орчим төгрөг гарахаар байна. Төлөвлөсөн хэмжээний өвс, тэжээл бэлтгэх зардал нь нийт малын зах зээлийн үнэ цэний 5 хувиас хэтрэхгүй байна. Хэрэв нийгмийн хамгааллын асуудлыг багтаавал 10 хувиас ихгүй байна. Иймд мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах эрсдлийн санг аймаг, сумын төвшинд нийт малын зах зээлийн үнийн 5-10 хувиас багагүй хэмжээнд үнэлэгдэх хөрөнгийн эх үүсвэртэй байгуулж 7-10 сард ашиглах боломжтой болгох ба цаашид эргэх, нөхөн нэмэгдэх механизмыг олж нэвтрүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Өрхийн индекс

Малчин өрхийн эмзэг байдал, эрсдлийн тоон үнэлгээ гаргахын тулд өрхийн ам бүлийн тоо, нас, хүйс, боловсрол, эрүүл мэнд, авъяас, мал малласан жил зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэн *Өрхийн Индекс* бодох аргачлал гаргаж Дундговь аймгийн судалгаа хийсэн 3 сумын 135 өрхийн мэдээгээр туршиж үзэв. Энэ үзүүлэлт нь ам бүлийн тооноос хамаараад зогсохгүй өрхийн гишүүдийн боловсрол, туршлага, эрүүл мэнд бусад үзүүлэлтээс шалтгаалан ихээхэн ялгаатай гарч байна. Эхний туршилтаар энэ үзүүлэлтийг өрхийн чадавхи, бүтээмжийн үнэлгээнд ашиглаж болохоор үр дүн гарсан. Өрхийн индекс ба ам бүлийн тоо, зудын өмнөх ба дараах малын тоог зах зээлийн үнээр мөнгөн дүнд шилжүүлээд өрхийн индекстэй харьцуулсан зургийг доор жишээ болгон харуулав. Судалгааг үргэлжлүүлэн индексийг эцэслэн гаргах шаардлагатай.

Зураг 2.2 Өрхийн индекс ба түүний хэрэглээ



24 улиралт каледарь

Малчин айл өрхийн амьжиргаа нь байгаль, нийгэм, эдийн засгийн олон асуудлыг агуулж байна. Гэтэл холбогдох өгөгдөл мэдээлэл нь цаг хугацаа, орон зайн масштабаар ялгаатай, хоорондоо холбогдохгүй байна. Иймд Эрсдэл судлал ажлын хэсгээс 24 улиралтай каледар хэрэглэж цаг уур, бэлчээр, мал, малчин өрхийн амьжиргааны өгөгдөл, мэдээллийг уялдуулан холбох туршилт хийсэн.

Эл календарийг ашиглан малчны ачаалал, мал маллагааны үйл ажиллагааны схем болон түүнд байгаль цаг уур хэдийд, ямар нөлөөлөл учруулж болохыг үнэлэх, прогнолох боломжтой. Хэрэглээний жишээг доор харуулав.

Зураг 2.2. Өрхийн индекс, түүний хэрэглээ

Туршилт 2: Шингэрүүлсэн хийн түлш бэлчээр хамгаална**Хэрэгцээ:**

Харгана, Заг зэрэг **сөөг ургамал** нь манай улсын говь хээрт олон зүйл ургамал өтгөн ургах нөхцөл бүрдүүлж хөрс шороог салхинд хийсэх, усанд угаагдах эвдрэлээс хамгаалахаас гадна малд уураг ихтэй өөг шимтэй тэжээл болдог байгаль орчинзүйн болон хэрэглээний хэмжээлшгүй **чухал ач холбогдолтой**.

1999-2002 оны ган, зудад үхэр ихээр хорогдсоноос говь, хээрийн бүсэд аргал түлш ховордож хүүхэд хөгшидгүй **бут сөөгөө түлэх** болсон нь бэлчээрийг доройтуулж **цөлжилтийг эрчимжүүлэх** аюултай.

Зудын хүнд үед хамгийн хэрэгцээтэй зүйл нь гурил будаа, **түлээ түлш** лүлээн гүтэл хувнас гэж малчил хэлж байна

Монгол орны говь хээрийн сөөг ургамал, түүний малын бэлчээр, ургамалжилд үзүүлэх нөлөө, ач холбогдол¹⁶

Сөөг ургамалд говийн цөлийн Загаас (орон нутагт мод гэдэг) эхлэн Харгана, Бүйлс зэргүүд хамаарагдана. Цөлийн бүсэд Заг нь өргөн уудам нутагт тархсан байдаг бол үхэр Харгана, алтан Харгана, бор Харгана, тэмээн Харгана мэт олон зүйл нь хээр болон говийн буюу цөлийн хээрт элдэв Шаваг, Хотир, Хармаг, Хуйрга мэт сөөг, сөөглиг, сөөгөнцөр болон Хялгана, Хазааргана, таана Сонгино, хөмөл Сонгино зэрэг өвслиг ургамалтай холилдон ихэд тархан Төв Азийн сөөгт хээрийг үүсгэнэ.

Харгана, Заг зэрэг сөөг ургамал манай улсын говь хээрт элбэг ч гэсэн тэр хирээр нь усдаж ховордуулж үл болох баялиг мөн. Тэдгээр нь бүгдээрээ тус орны байгаль орчинзүйн болон хэрэглээний хэмжээлшгүй чухал ач холбогдолтой. Олонхи сөөг ургамлын ургаа **газар нутагт** хөрс шороо салхинд хийсэх, усанд угаагдах мэт эвдрэл ховрын дээр бутанд нь элс шороо торж нүүхгүй болохоос эхлэн тэрхүү хурсан элс шороонд нь олон зүйл ургамал өтгөн ургах таатай нөхцөл (конденсацийн ус) бүрдэнэ, **малд** бол Харгана мэт нь уураг ихтэй өөг шимтэй тэжээл болохын хамт жавар салхинаас хаацайлах нөмөр болох, **малчдад** бол заг зэрэг нь түлшний чухал ач тустай. Дашрамд өгүүлэхэд Монос, Өрөл, Долоогоно, Тавилгана, Сарна, Чацаргана, Шээг зэрэг олон зүйл сөөг нь **хот суурины** ногоон байгууламжид өргөн ашиглагддаг.

Гэвч бор Харганыг түлээнд ихэд бэлдэж усдан бэлчээрээ хувхайруулсан газар буйн дээр загийн элс шорооны нүүдэл - салхины элэгдлийг бууруулах саатуулах ач холбогдлыг үл тооцон хавийн загийг давс шаргаахад ашигласаас (Гурван Тэсийн) амны давсны уурхай элсэнд булагдсан зэрэг гунигт баримт бийн дээр өдгөө олон аймаг, сумдын төв, суурин газарт өвслиг ургамал нь хүн - унааны хөлд усдаснаас элсэнд даруулах явдал үргэлжилсээр байгаа бөгөөд тэр “аюулаас” гарах замаа “сөөг тарих явдал” гэж үзэхэд хүрсэн талтай.

¹⁶ Н.Манибазар, 2003

Харин сая дурдсаныг эс тооцвол сөөг ургамлын, байгаль орчны өнгөрсөн болоод ирээдүйн ач холбогдлыг тусгайлан судлаагүй гэж болно. Иймээс Харгана мэт сөөгийн гарвалийн талаар эсрэг тэсрэг баримтлал, аргачлал байсаар. Тус орны бэлчээрийн доройтол тодорхой шатанд хүрэхэд сөөгтэй болно гэсэн аргачлал байх, түүнд итгэсэн баримтлал ч үзэгдэх нь Харгана мэтийг хамгаалах гэвэл бэлчээрийг тодорхой хэмжээгээр малд талхилуулах хэрэг гарах мэт. Ус чийгтэй газрын бэлчээрийг ашиглахгүй удвал сөөгөнд баригддаг нь нуталгаа шаардахгүй үнэн боловч саяхи мэт дадал (empegic) баримтлал манайд одоо хир зохих нуталгаагаа олоогүй байгаа зэрэг нь сөөг ургамлыг судлахгүй байгаагийн уршиг гэлтэй.

Дундговь аймгийн нэлээд сумдаар явахад олонхийн дэвсгэрт Харгана ургах нь нэгж талбайн 30-40-өөс 80-90 % -д хүрэх юм. Тэр нь гантай жил ч ногоорон ургаж зуд болоход гэжээлийн чухал нөөц болсоор ирсэн нь түүний ач холбогдлыг тодорхой харуулна. Харин түүний хамт зарим сумын айл Харганыг (говийнхны заг түүж овоолж ашигладаг шиг) үндэстэй нь сугачин авч хураасан явдал тааралдсан бөгөөд түүнийг сүүлийн жилүүдэд үхэр сүрэг хорогдсоноос түлэх аргал ховордсон тул харганы үндэс түүхэд хүрлээ гэж тайлбарлаж байх юм. Говь талынхны түлээ нь аргал байдаг бол одоо Харгана болох нь. Ийм байдал бусад аймагт ч газар авах хандлага сүүлийн үед бий болж байгаа. Хэрэв энэ “туршилга” газар авбал сүүлийн жилүүдэд ган зуд болж өвс ургамлын гарц буурч байхад тэдгээрийг хэвийн байдлаар ургахад таатай нөлөөлдөг Харгана маань “баяртай” болж магадгүй. Манай урд хөршид сөөг ургамал нь усдсан газарт Харгана мэтийг тариж үржүүлэх ажил төрийн бодлогын хэмжээнд тавигдан амжилттай хэрэгжиж буйг далимд дурдсу.

Харганыг устгавал малын бэлчээр аяндаа доройтох, салхи усанд эвдэрч усдах, дамаа малын хорогдол гаарах магадлалтай. Харганаа (зэрэг бусад мод сөөг ургамлыг) усдахгүй байх, малчдаа түлээтэй байлгах хоёр чухал асуудлын нэгийг нөгөөгөөр орлуулаж болохгүй нь мэдээж. Малчид өвөл хаврын улирал ялангуяа отор нүүдэлтэй үед хамгийн ихээр гачигддаг юмны нэг нь түлээ байдаг. Энэ үед нь Харганаар аргалаа орлуулах гэхийн оронд буюу тэвдсэн үед нь “тэвнэ” болгож төр засгийн газраас түлээний өөр эх үүсвэр (нарны салхины эрчим хүч, газрын тосны гаралтай гм) олж өгч туслууштай. Тэр үеийн аливаа түлээ бол зөвхөн малчин хүний хоол ундаа болгох дулаацах арга хэрэгсэл төдийгүй, тэдний эрүүл мэнд, тохи дух-нийгмийн асуудал болох ба малд ч маш чухал хэрэгтэй юмны нэг. Учир нь тухайн үедээ бээрч ядарсан, өлдсөн малд бүлээсгэсэн ус өгөхийн чухлыг нуталсан шинжилгээний ажил, түүний ач тусыг амссан явдал ч байдаг оршно. Гэвч малд тустай тэр зөвлөмжийг түлээний гачигдалтай малчин хэрэгжүүлэх гэдэг эргэлзээтэй.

Сөөг ургамлыг түлээнд өргөн ашиглаж эхэлвэл түүнийг хамгаалах, тарьж үржүүлэхээс эхлэн нийгмийн зарим асуудлыг хүртэл хөндөх бололтой. Мал, хүн, ургамал гурваа хамгаалах олон аргын дотор дулаан хүйтний улиралд говь, хээрийн малчдыг (хот сууриныхинд ч хамааралтай) хямд төсөр үнэтэй түлээгээр хангах асуудал бол тус оронд ядуурлыг бууруулах арга хэмжээний нэгэнд тооцогдох ёстой арга хэмжээ буюу.

Шингэрүүлсэн хийн төхөөрөмжийг хөдөөгийн 62 хэрэглэгчдэд ашиглуулж түршсан нь

Сүүлийн жилүүдийн ган зудад үхэр сүрэг ихээр хорогдсоноос говь хээрийн бүсэд аргал түлш ховордсон. Дундговь аймагт судалгаа хийж явахад айлууд бут сөөг, модлог ургамлыг үндэстэй нь сугачин авч гаднаа хураан түлж байгаатай таарч байсан. Малчид ч түлшний гачигдалд орж буй талаар ярьж байсан.

Энэ нөхцөлд УИХ-ын гишүүн, “Эрсдэл судлал” ажлын хэсгийн ахлагч Н.Тогтох хөдөөд түлшний шинэ эх үүсвэр ашиглуулж турших санаачлага гарган зохион байгуулж 2003 оны 7 сард Дундговь аймгийн 8 сумын 62 хэрэглэгчдэд 30-ийн торхтой шингэрүүлсэн хий, плитка, гэрлийн төхөөрөмж суурилуулах ажлыг хариуцан гүйцэтгэв. Туршилтын явцад дараах судалгаа хийсэн:

- Малчин айлын түлшний хэрэгцээ, аргалын олдоц, үнэ өртөг:** Хийн төхөөрөмж туршиж буй сумдад ЗИЛ - 130 машины тэвш аргал 50000 төгрөгийн үнэтэй байна. Тэвшинд 50 кг-ийн 100 шуудай аргал багтдаг аж. Дунджаар нэг шуудай бууцны аргал 15 кг, хашааны аргал 13 кг, түүвэр аргал 11 жинтэй. Тооцоолбол нэг шуудай аргал **500 төгрөгийн үнэтэй, 1 кг бууцны аргал 33.3 төг, хашааны аргал 38.5 төг, түүвэр аргал 45.5 төгийн үнэтэй** байна. Зудад үхэр ихээр хорогдсон сумдад аргал ховор, эрэлт хэрэгцээ их, өвөл хаврын түлш бэлтгэхэд малчид хөрөнгө мөнгөний дутагдалтай байна.
- Шингэрүүлсэн хийн төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ашиглалтын горим:** Хөдөөд шингэрүүлсэн хий хэрэглэсэн туршлага бараг үгүй тул ашиглалтын заавар журам горим үгүй байна. Хий нийлүүлэгч нь аюулгүй ажиллагааны заавартай, харин ашиглалтын талаар судалгаа хийгээгүй, горим тогтоогоогүй байна.

Хийн төхөөрөмж нь хий зарцуулалтын янз бүрийн төвшинд тохируулан ажиллуулах боломжтой хэдий ч чухам ямар төвшний горим сонгох нь нилээд нарийн асуудал юм. Төвшин бүрт хий зарцуулалтын хэмжээ, хугацаа өөр өөр байна. Бид туршилтанд хамрагдсан хэрэглэгчдийн хий ашигласан бүртгэл мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хий зарцуулалтын **2.16 г/мин, 4.11 г/мин** гэсэн хоёр горим хэрэглээ, зардлын үзүүлэлтээр хамгийн оновчтой болохыг тогтоов.

Энэ хоёр горим хий зарцуулалтын хувьд ижил ч ус буцалгах хурд нь ялгаатай (Хүснэгт 2.10). 2.16 г/мин горимд 5 л ус 26 минут буцалж байгаа нь ус буцалгалтын хувьд төв суурин газрын сууцны байшингийн ханан пийшинтэй адил байна. Харин 4.11 г/мин горим нь гэрийн ердийн зуухтай ойролцоо, 5 л усыг 13 минутанд буцалгаж байна.

Хүснэгт 2.10. Аргал, шингэрүүлсэн хийн зарцуулалт

No:	Буцалгасан усны хэмжээ	Үзүүлэлт	Бууцны аргал	Шингэрүүлсэн хий	
				2.16 г/мин	4.11 г/мин
1	7 литр	зарцуулалт, гр	2235 - 2780	73.4	74.0
		хугацаа, мин	23 - 35	34	18
2	5 литр	зарцуулалт, гр	1830 - 2300	56.2	53.4
		хугацаа, мин	18 - 27	26	13
3	3 литр	зарцуулалт, гр	1110 - 1765	43.2	37.9
		хугацаа, мин	10 - 18	20	9.0

- Шингэрүүлсэн хийн үнэ, ашиглалтын зардлыг бусад эх үүсвэртэй харьцуулсан судалгаа:** 5 л ус буцалгахад зарцуулах хийн түлшний өртөг 55-58 төгрөг байгаа нь бууцны аргалынхаас 15-31% хямд байна. Хийн түлшний өртөг 1 квт нь 54 төгрөгийн үнэтэй цахилгаантай ойролцоо, түүнээс дээш өртөгтэй цахилгаанаас 60 хүртэл хувь хямд байна (Хүснэгт 2.11).

Хүснэгт 2.11. Аргал, цахилгаан, шингэрүүлсэн хийн өртөг, төг

No:	Буцалгасан усны хэмжээ	Бууцны аргал	Цахилгаан	Шингэрүүлсэн хий	
				2.16 г/мин	4.11 г/мин
1	7 литр	76.0 - 92.7	47 - 138	76.0	76.6
2	5 литр	61.0 - 76.7	42 - 92	58.2	55.3
3	3 литр	37.8 - 60.0	33 - 64	44.7	38.2

4. **Шингэрүүлсэн хийн хангалт, ашиглалтыг тасалдалгүй жигд болгох асуудал:** Туршилтанд оролцогчид хийн түлшийн талаар “хэрэгтэй зүйл, ашигтай эд, цаашдаа хэрэглэнэ” гэх мэт ам сайтай байгаа ч торхтой хий дуусахад орон нутагтаа цэнэглүүлэх боломжгүй тул хий нь дууссан 8 хэрэглэгчийн 2 нь л Улаанбаатар хотод ирж цэнэглүүлсэн байна. Үүнд 30 литрийн торхонд 12.5 кг хий цэнэглүүлэхэд 12937 төг, тээврийн зардалд 20000 төгрөг зарцуулжээ. Ийм маягаар торхыг ганц нэгээр тээвэрлэж цэнэглүүлэх нь хийн өртгийг 2.5 дахин нэмэгдүүлэх тул цэнэглэх, тээвэрлэх асуудлыг зохион байгуулалтанд оруулах шаардлагатай. Дундговь аймгийн баруун хойт 5 сумын жишээн дээр хийсэн тооцоогоор 20 хоног тутам 40 торх хийг Улаанбаатараас Эрдэнэдалай сумын төвд хүргэж түгээгээд, 40 хоосон торх буцааж авчран цэнэглэх ажиллагааг тогтмол явуулбал тээвэрлэлт, ханган нийлүүлэлт эдийн засгийн хувьд алдагдалгүй байх бөгөөд үүний тулд наад зах нь 120 хэрэглэгч байх хэрэгтэй гэж гарч байна. Ийм тооны хэрэглэгч бэлтгэн нийлүүлэлт- ашиглалтын тогтвортой горимд ортол туршилтыг үргэлжлүүлэх шаардлагатай.

Туршилт 3: Торниулж үржүүлэн малжуулах арга

Хэрэгцээ:

Уур амьсгал өөрчлөгдөж, байгаль цаг уурын аюулт үзэгдлийн давтагдал нэмэгдэж байгаа ч малчид үүнээс сургамж авч, эл нөхцөлд зохицон нутаг орондоо малаа маллан амьдрах бодолтой байна. Нутаг орондоо малаа маллан амьдрах хүсэл зоригтой малчдыг ядуурлаас гаргахад мал л хэрэгтэй.

Ган зудын гамшгийн улмаас ядуурсан олон малчин өрх хязгаарлагдмал хүрээнд явагдсан малжуулалтанд хамрагдаж чадаагүй үлджээ.

Малжуулах, түүний зээлийг буцаан төлөх асуудал, аргачлалыг бодит амьдралд нийцүүлэн нарийвчлан боловсруулах шаардлагатай.

Малчид, орон нутгийн удирдлага байгаль цаг уурын бэрхшээлийг хохирол багатай даван туулах, улмаар өөрчлөгдөж буй уур амьсгалд зохицоход малын үүлдэр угсааг сайжруулах, чанаржуулах, ашиг шимийг нэмэгдүүлэх асуудал чухал гэж үзэж байна

Баянцагааны илүү нугаламтай хонины 30 хурган хуцыг Дундговь аймгийн Эрдэнэдалайн 30 малчин өрхөд тодорхой болзолтой өгөв.

Эрдэнэдалай сумын Тэнгэлэг багийн малчин Н.Баярбат хониныхоо үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Төв аймгийн Баянцагааны илүү нугаламтай хонины хуц авах санал гаргасныг “Эрсдэл судлал” ажлын хэсгийн ахлагч, УИХ ын гишүүн Н.Тогтох, Инфокон ХХК ний захирал Б.Наранцэцэг нар дэмжиж, баяжуулан судалж, санхүүжилт олж, зохион байгуулж хэрэгжүүлсэн.

Энэ ажил нь хот хөдөөд амьдарч буй, өөр мэргэжлийн хүмүүс бие биесээ дэмжиж нэгэн сэтгэлээр хамтран ажиллавал ямар үр дүнд хүрэхийг харуулсан сайхан жишээ болохын дээр малын үүлдэр угсааг сайжруулах, малчдыг малжуулах, ядуурлаас гаргахад түгээмэл ашиглаж болох сонин санаа агуулж байгаа юм. Хурган хуц авсан эхний 30 айл 2 жилийн дараа тус бүр 3 хурган хуц 3 айлд өгөх (нийт 90 айлд), хоёр дахь ээлжинд хуц авсан 90 айл мөн 2 жилийн дараа тус бүр 1 хургыг 3 дахь ээлжийн 90 айлд өгөх болзолтой (Хүснэгт 2.12).

Хүснэгт 2.12 Хурган хуц авах айлын тоо

Он	Хуц авах ээлж			Хуц авах айлын тоо
	I	II	III	
2003	30 хурга			30
2004	30 төлөг			
2005		90 хурга		90
2006		90 төлөг		
2007			90 хурга	90
2008			90 төлөг	
	30	90	90	210

Дээрх загвараар явахад 2004 оноос хойш гарсан хурганаас Эрдэнэдалайн сумын бүх айл өрх илүү нугаламтай хуц тавих хурга авч малынхаа үүлдэр угсааг сайжруулах бололцоотой юм. Цаашилбал 2010 он гэхэд сумын нийт хонин сүргийн үүлдэр угсаа сайжирч ашиг шим нь нэмэгдэнэ.

Торниулж үржүүлэн малжуулах арга

Дээрхи туршилт нь ган зудад малаа алдсан малчдыг малжуулахад ашиглаж болох Торниулах-Үржүүлэх-Малжуулах 3 шатлалыг агуулж байна.

1. **Торниулах:** Хуцан хургыг мал маллах туршлага, боломж сайтай айлд өгч торниулснаар сайн үүлдрийн хээлтүүлэгчтэй болно. Хурга авах нь нас бие гүйцсэн хээлтүүлэгч авахаас хямд тул бага хэмжээний хөрөнгийг олон айлд хүртээх боломж олгоно. Олон малтай, ажилтай, амьжиргаатай малчдад малынх нь үүлдрийг сайжруулахад тус болсноор мах бэлтгэл, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

Энэ үе шат нь Япон, Солонгос зэрэг орнуудад шинээр бий болсон бизнесийн салбарт хэрэглэж амжилттай үр дүнд хүрэх нь нотлогдсон, тэдний туршлагаар манай оронд мэдээллийн технологийн салбарт хэрэглэж эхэлж буй “Инкубаци”-ийн аргатай (дутуу төрсөн хүүхдийг инкубаторт торниуулдагтай нэгэн адил) төстэй юм.

2. **Үржүүлэх:** Боломжтой айл авсан хургаа торниулж хээлтүүлэгч болгоод түүнээс сайн үүлдрийн төл авч түүнээсээ 3 хуцан хургыг 3 ядуу айлд өгнө. Ингэснээр хурга болон хурга авсан айлын тоо 3 дахин олон болно. Өөрөөр хэлбэл малжуулалтанд зарцуулсан эхний хөрөнгө 3 дахин өснө гэсэн үг. Ингэж хөрөнгө өсгөх асуудлыг малжуулалтын анхны хөрөнгө оруулагч биш чинээлэг малчид хариуцаж нутаг орондоо ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулна. Хурга өгсөн айлаа халамжлан тусална.

Энэ үе шат нь “хязгаарлагдмал” хөрөнгийг үржүүлнэ.

3. **Малжуулах:** Хурга авсан ядуу айл 3 жилийн дараа нэг хургыг өөр нэг ядуу айлд өгнө. Ингэснээр ядуу айл нь малаа өсгөөд зогсохгүй дараагийн ядуу айлд тус болох хариуцлага хүлээж ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах болно.

Энэ үе шат нь цааш давтагдан үргэлжилсээр “Зудын сургамж” зөвлөмжид санал болгосон “Төмөр сүрэг” – ийг бүрдүүлж байнгын эргэлтийн малтай малжуулалт болно.

Туршилт 4: Үхэр хорогдвол тэмээ өсгөх: Тэмээний ноос

Хэрэгцээ:

1970 оноос хойшхи малын зүй бусын хорогдолд үхрийн эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна.

Уур амьсгалын өөрчлөгдлийн нөлөөгөөр говийн бүс тэлж, хангайн бүс багасах төлөвтэй байна.

Байгаль цаг уурын улмаас үхрийн идэш тэжээл муудаж тоо нь цөөрвөл мах, сүүний үйлдвэрлэлд сөрөг нөлөөлөл учирна.

Сүүлийн хэдэн жилийн ган зудад тэмээ зүй бусаар хорогдоогүй.

Хэрэв уур амьсгалын өөрчлөгдөл эрчимжиж байгалийн бүс бүслүүрийн хил хойшилж говь нэмэгдэж хангай багасвал үхрийн амьдрах орчин багасч тэмээнийх тэлнэ. Нэгэнт байгалийн аятай таатай нөхцөл бүрдвэл тэмээгээ өсгөх, улмаар үхрийн хорогдлоос учрах хохирлыг багасгах, нөхөх бодлого хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгтэй.

“Эрсдэл судлал” уур амьсгал өөрчлөгдөлд зохицох асуудлыг судлах явцад “Үхэр их хорогдвол тэмээ үхрийг орлож чадах уу?” гэсэн асуулт тавьж үхэр тэмээний ашиг шимийг харьцуулан судалсан бөгөөд тэмээний эр ноосыг ашиглан хивс нэхэх талаар зарим туршилт хийж эхэлсэн. Туршилтын үр дүн хараахан гараагүй байна.

Өнөөдөр тэмээний ашиг шим мах, өөх, эм ноосоор хязгаарлагдаж, машин тэрэг олширсон болохоор тэмээг уналга ачилгад хэрэглэх нь ховор, тэмээний сүү, хоормог тэмээтэй айлын хэрэгцээгээс хэтрэхгүй шахам, ноосны 30 гаруй хувийг эзэлдэг эр ноос бараг хэрэглээгүй болсон гэх мэт амьд тэмээний ашиг шим, ач холбогдол тун бага байгаа энэ үед тэмээ өсгөх бодлого шийдвэрийг оночтой гаргах нь ач холбогдолтой. Ялангуяа тэмээний сүү, хоормог, ааруул идээний хүнс, эмчилгээний ач холбогдлыг судлах, хэрэглээг нэмэгдүүлэх, ноосонд нь өнгө оруулах, зөөлрүүлэх, эр ноос хэрэглэн төрөл бүрийн нэхмэл сүлжмэл эдлэл хийх технолог боловсруулах, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зэрэг асуудалд хандсан бодлого шийдвэр хэрэгтэй болох нь анхан шатны судалгаагаар харагдаж байна.

3.0 Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьсал бэлчээрийн мал аж ахуйд нөлөөлсөн нь


Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьслаас бэлчээрийн мал аж ахуйд үзүүлэх нөлөөллийг 1999-2002 оны ган, зудын жишээн дээр мэргэжлийн байгууллага, статистикийн мэдээ, сум, багийн удирдлагаас авсан анкетийн судалгаанд тулгуурлан улс, Булган, Дундговь, Завхан, Төв, Хэнтий аймаг, 14 сумаар судалсан ба үр дүнг нь энд өгүүлэв.

3.1. Улсын хэмжээнд

Зураг 3.1. Малын тоо



Монгол Улсын эдийн засгийн үндэс, хүн ардын амьжиргааны эх сурвалж болсон бэлчээрийн мал аж ахуй нь байгаль, цаг уурын эрхшээл нөлөөлөлд байна. Цаг агаар тааламжтай 1993 - 1999 онд мал эрс өсч 1940 оноос хойшхи хамгийн олон 33.6 сая толгойд хүрсэн.

Харин 1998 оноос хойшхи жилүүдийн аагим халуун, ган, зуд, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн аюулд олон сая мал хорогдсоноос 2002 оны эцсээр малын тоо 23.9 сая болж 15 жилийн тэртээх 1989 оныхоос ч цөөрөв.



Нэг хүнд ногдох малын тоо 2002 онд 9.7 хүртэл буурч 1940 оноос хойшхи хугацааны хамгийн бага үзүүлэлт болов (Зураг 3.2). 1988, 1993 онд нэг хүн амд ногдох мал 11.3, 11.2 байсан нь ХХ зууны хамгийн бага үзүүлэлт болсон. Харин 2002 оны эцсийнх тэдгээрээс ч бага, бүр “рекорд” болов.


Зураг 3.2. Нэг хүнд ногдох малын тоо



Зураг 3.3

ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь цаг агаар тааламжтай байсан 1999 онд 40.3% байснаа 2002 оны эцэст 23.6% болж 16.8 хувиар багыг эзлэх болжээ.

Хөдөө аж ахуйн салбарын ДНБ 1995 оны үнээр 1999 онд 252.4 тэрбум төгрөг байсан бол 2002 онд 152.6 тэрбум төгрөг болж 1.6 дахин буурчээ.



Монгол оронд тохиолдож байсан гангийн давтагдлаас үзэхэд нийт нутгийн дөрөвний гурваас дээш хувийг хамарсан ган 11-12 жилд нэг удаа, нутгийн дөрөвний нэгээс бага хувийг хамарсан ган 2-2.5 жилд нэг удаа тохиолдож байсан бол 1999 оноос хойш нутгийн 60-аас дээш хувийг хамарсан ган жил дараалан болов (Хүснэгт 3.1). Гангийн дараа хөлдүү гачиг, зуд, хавсарга залгаж хүн мал халдварт өвчинд нэрвэгдэж ихээхэн хохирол үзэв.

Хүснэгт 3.1. 1999-2002 оны ган, зудын хамарсан хүрээ

Хугацаа	Ган		Гантай, гандуу нутгийн эзлэх хувь	Хугацаа	Цагаан зуд	
	Хамарсан				Хамарсан	
	Аймгийн тоо	Сумын Тоо			Аймгийн тоо	Сумын тоо
1999 оны зун	8	45	60 орчим	1999-2000 оны өвөл	14	58
2000 оны зун	12	44	60 гаруй	2000-2001 оны өвөл	17	98
2001 оны зун	9	54	70 гаруй	2001-2002 оны өвөл	8	114
2002 оны зун	13	77	70 орчим	2002-2003 оны өвөл	7	60

1999-2002 онд ган зудад нийт 8.6 сая мал хорогдож 333 тэрбум төгрөгийн шууд хохирол учирчээ (Хүснэгт 3.2).

Цаг уурын үзэгдлээс мал аж ахуйд үзүүлэх нөлөөллийг 2002-2003 оны жишээн дээр дэлгэрэнгүй судалж үзэв.

Хүснэгт 3.2. 1999-2003 оны зудад хорогдсон малын тоо

Он	Зуд болсон аймаг, сум ¹⁷		Зудад өртсөн өрхийн тоо, мянган өрх	Зудтай нутгийн малын тоо, сая мал	Хорогдсон малын тоо, мянган мал	Малгүй болсон өрхийн тоо	Шууд хохирол, тэрбум төгрөг
	Ус цаг уур	ХХААЯ					
1999-2000	13 аймгийн 158 сум	15 аймгийн 157 сум	80.9	7 сая	2399.2	2369	91.7
2000-2001	20 аймгийн 192 сум	17 аймгийн 98 сум,	118.3	19,5 сая	3491.3	4995	133.4
2001-2002	7 аймгийн 65 сум	8 аймгийн 114 сум,	32.2	4.4	2689.0	4736	108
2002-2003		11 аймгийн 60 гаруй сум	?		400 гаруй мянга	?	

2002-2003 он

2002 оны зун хэт хуурай халуун болов. 7, 8 сард бороо хур бага, олон хоногоор 30 хэмээс давж халсан нь бэлчээрийн өвс ургамлын гарцыг муутгаж 2001-2002 оны өвөл хаврын зуд хавсаргад сульдаж доройтсон малд тарга хүч авахуулахад хүндрэл учруулж мал аж ахуйн үйлдвэрлэлд муугаар нөлөөлөв.

Цаг уурын ажиглалт хийдэг 114 станцын мэдээгээр УЦУХ-ийн мэргэжилтнүүд мал бэлчээрлэлтэнд тохиромжгүй өдрийн тоог тооцоолж гаргажээ. Үүнд зуны халуун агаарын эрхшээлийг салхины хурд, агаарын температураар тодорхойлох Т.Туваансүрэн, Б.Данзанням нарын шалгуурыг ашиглажээ. Эл тооцоогоор Увсын Тэсэд 65 хоног, Булганы Хутаг, Өмнөговийн Сайхан, Хөвсгөлийн Рэнчинлхүмбэд 40-41 хоног мал бэлчээрлэлтэнд тохиромжгүй байжээ. Нийт станцын дунджаар 7, 8 сард тохиромжгүй өдрийн тоо хамгийн олон тохиожээ (Хүснэгт 3.3).

Хүснэгт 3.3. Малын бэлчээрлэлтэд тохиромжгүй өдрийн тоо

ᠨᠠᠳᠤ ᠰᠤᠮᠤᠨ ᠨᠢᠷ	2002 оны зун				2002-2003 оны өвөл				Өвөл, зун	
	6	7	8	Дүн	11	12	1	2	Дүн	Дүн
114 станцаар дундажлаж гаргасан хоногийн тоо	2,1	6,1	5,6	14	0,4	2,9	1,9	1,1	6,29	20,2

Ус цаг уурын хүрээлэн 8 сарын сүүлээр өвлийн цаг агаарын мэдээ гаргаж намар эрт бэлчээрт зузаан цасан бүрхүүл тогтож болзошгүйг анхааруулсны улмаас төр засаг, орон нутаг, малчид цаснаас өрсөж өвөлжилтийн бэлтгэл хангах олон арга хэмжээ авч амжуулжээ.

¹⁷ Ус цаг уурын байгууллага, ХХААЯ-ны гаргасан зудтай аймаг, сумдын тоо мэдээлэл хоорондоо зөрж байгаа тул хоёуланг нь оруулав.

Зуны олон хоног үргэлжилсэн аагим халуун 8 сарын 20-оос хойш аажим буурсан ч 9 сард олон жилийн дунджаасаа дулаан, хур багатай байлаа. Харин 9 сарын сарын арвадаар Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн зарим сумдад бороо орж газрын өнгө засарч бэлчээр бага зэрэг сайжирсан. Дулааны улмаас цочир хүйтрэлт ердийнхөөсөө орой болсон нь хадлан тэжээл бэлтгэх, хашаа саравч, өвөлжөө бууц засах, отрын нутаг сонгох, тариа, ногоо хураах зэрэг хөдөө аж ахуйн цаг үеийн ажилд таатай нөлөө үзүүлсэн байна.

Зун гантай байсан нутгаар 10, 11 сард олон удаа (олон жилийн дунджаас 2-4 дахин олон хоногоор) их цас унаж, хүчтэй салхи шуурга болсон. Тогтвортой цасан бүрхүүл ерийн байдлаас 20-30 хоногоор эрт тогтсон байна. 10 сарын эхний арав хоногт Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнодын ихэнх, Завхан, Хөвсгөл, Архангайн зарим цас ихтэй нутгаар үе үе өдөртөө 13 хэм хүртэл дулаарснаас цас нягтаршиж, өнгөн хэсэг нь хайлмагтан мөстсөнөөс зун гантай, өвс ногоо тачир, мал тарга тэвээрэг муу нутгуудад өвөлжилт эртнээс хүндрэх суурь нөхцөл бүрдэж эхэлсэн.

11 сард олон удаа цас орсноос нутгийн ихэнхэд олон жилийн дунджийн орчим ба дунджаас ахиу хэмжээний тунадас унаж нийт нутгийн 60 орчим хувь цастай, ялангуяа нутгийн хойд хэсгээр зузаан цастай болсноос зам даваа хаагдсан, бог мал бэлчээрт гарах боломжгүй болж нэмэгдэл тэжээлд орж эхэлсэн байна.

УЦУХ-ээс гаргасан “Өвлийн улирлын урьдчилсан мэдээ”-нд 12, 1 сард ахиухан цас орж, цас хайлмагтан хатуурч өвөлжилт хүндрэх тухай тодорхой мэдээлсэн байна.

2002 оны 12 сард цастай нутгийн эзлэх хувь өмнөх сараасаа 10-20 хувиар нэмэгдэж нийт нутгийн 80-95 хувьд хүрсэн бөгөөд үүнээс 50 орчим хувьд нь буюу Увс, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв аймгийн ихэнх, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь, Өмнөговь аймгийн зарим нутгаар дунджаар 10-34 см болж, сарын дунд болон сүүлийн арав хоногт хүйтний эрч үе үе эрс чангарч шөнөдөө агаарын үнэмлэхүй бага температур -41-51 хэм хүрч, зарим нутгаар 2-4 хоног агаарт 30 хэмээс хүйтэрсэн нь мал бэлчээрлэлтэнд хүндрэл учруулсан байна.

2003 оны 1 дүгээр сарын эхээр хүчтэй салхи, шуурга болж, бүх нутгийн 70 орчим хувьд олон жилийн дунджаас их цас орж, нийт нутгийн 90 гаруй хувьд 10-40 см зузаан цасан бүрхүүлтэй болсон, агаарын температурын хэлбэлзэл ихтэй, Увс, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий аймгийн нутгаар 15-27 хоног, бусад нутагт 1-4 хоног агаарт -30 хэмээс доош хүйтэрч байснаас отор нүүдэл хийх гарцгүй болж, зарим аймгийн сум, багт байсан өвс тэжээлийн нөөц дуусаж, зам даваа цасанд хаагдаж мал аж ахуйд өвөлжилтийн байдал улам хүндэрсэн байна.

УЦУХ-нд ирсэн бүрэн бус мэдээгээр 12 дугаар сараас 3 сарыг дуустал хугацаанд 400 гаруй мянган мал хорогдсон байна. Мөн аймаг, сумын БОК-оос цасанд хаагдсан зам давааг саадгүй болгож байсан ч цас ихтэй нутгуудад явган шуурга байнга шуурч байснаас өдөртөө л зам даваа хаагдаж өвс тэжээл хүргэхэд ихээхэн хүндрэл учруулж байжээ.

Монгол Улсын Засгийн газар, ХХААЯ, УБОК 2003 оны 1 сарын 5-нд цагийн байдалтай уялдуулан өвөлжилт хүндэрсэн Булган, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул аймгуудад яаралтай тусламж үзүүлэхээр тогтжээ. Эдгээр 11 аймгийн 60-аад сум зудын байдалтай болсон гэж үзсэн байна. Засгийн газар, ХХААЯ, УБОК-оос гаргасан хүндрэлтэй аймаг, сумдын нэрс, тохиолдож байгаа бэрхшээл, авсан арга хэмжээг 2003 оны 1 сарын 6-ны өдрийн “Үнэн” сонинд нийтлэснийг хүснэгтээр хийж доор үзүүлэв. (Хүснэгт 3.4).

2 сард ихэнх нутгаар олон жилийн дунджаасаа дулаан, нутгийн 60 гаруй хувьд хэвийн хэмжээнээсээ ахиу тунадас орж эхний арав хоногт нь –30-44 градус хүрч хүйтэрсэн бөгөөд сарын сүүлийн хагаст температурын хэлбэлзэл ихтэй байснаас цас улам нягтарч мөстөж хатууран Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн ихэнх сумдад мал өвөлжилтийн байдал хүнд хэвээр байв. Мөн түүнчлэн цас багатай нутгуудад ч бэлчээртээ өвс ургамалгүйгээс мал өлдөж тамирдах явдал гарсаар байв. 2 дугаар сарын 7-8-нд болсон хүчтэй шуурганаар Төв, Дундговь аймагт тус бүр нэг хүн эрсдэж цаг агаарын нөхцөл хүндэрснээс олон толгой мал хорогдсон байна.

**Хүснэгт 3.4. 2002-2003 оны өвөл
цагийн байдал хүндэрсэн аймаг сумд, авсан арга хэмжээ**

Аймаг, сум	Цаг агаарын бэрхшээл	Авсан арга хэмжээ
<i>Булган:</i> Баян-Агт, Могод, Сайхан, Бүрэнхангай, Хишиг-Өндөр, Тэшиг, Хутаг- Өндөр, Сэлэнгэ, Рашаант	Гантай байсан, намар эрт цас орж 11-р сараас эхлэн малаа байнгын буюу нэмэгдэл тэжээлд оруулсан. Цас дунджаар 20-30 см, хатуурч нягтарсан цасан бүрхүүлтэй, зарим зам даваа хаагдсан. Өвс тэжээл дутагдалтай, отор нүүдэл хийх гарцгүй болсон. Бог мал бэлчээрт гарах боломжгүй.	ЗГ-ын 268-р тогтоолоор 1500тн өвс, 3,5 тн тэжээл хөнгөлттэй үнээр, 12 нэрийн 15,8 сая төгрөгийн хүнс, өргөн хэрэглээний бараа олгосон. Тус аймгийн ИХ-ын аврах салбарын аврагчид ЗХ-ний ИХ-ын томилгоот 186-р ангиас туулах чадвар сайтай машин гаргаж зам гарц гаргах, өвс тэжээлийг сум багт хүргэх ажлыг зохион байгуулсан.
<i>Булган:</i> Баян-Агт, Могод, Сайхан, Бүрэнхангай, Хишиг-Өндөр, Тэшиг, Хутаг- Өндөр, Сэлэнгэ, Рашаант	Гантай байсан, намар эрт цас орж 11-р сараас эхлэн малаа байнгын буюу нэмэг-дэл тэжээлд оруулсан. Цас дунджаар 20-30 см, хатуурч нягтарсан цасан бүрхүүлтэй, зарим зам даваа хаагдсан. Өвс тэжээл дутагдалтай, отор нүүдэл хийх гарцгүй болсон. Бог мал бэлчээрт гарах боломжгүй.	ЗГ-ын 268-р тогтоолоор 1500тн өвс, 3,5 тн тэжээл хөнгөлттэй үнээр, 12 нэрийн 15,8 сая төгрөгийн хүнс, өргөн хэрэглээний бараа олгосон. Тус аймгийн ИХ-ын аврах салбарын аврагчид ЗХ-ний ИХ-ын томилгоот 186-р ангиас туулах чадвар сайтай машин гаргаж зам гарц гаргах, өвс тэжээлийг сум багт хүргэх ажлыг зохион байгуулсан.
<i>Хөвсгөл:</i> Цагаан-Уул, Тариалан, Их-Уул, Рашаант	20-30 см нягтарсан цасан бүрхүүлтэй. Мал бэлчээрт гарах боломжгүй болсон. Сум, баг нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээл дууссан. Зарим зам даваа хаагдсан.	ЗГ-ын 268-р тогтоолоор 600 тн өвс, 12 нэрийн 15,8 сая төгрөгийн хүнс, өргөн хэрэглээний бараа олгосон. Тус аймгийн ИХ-ын аврах салбарын аврагчид малчдад өвс тэжээл хүргэх, зам даваа гаргахад дайчлагдан ажиллаж байна. Аймгийн Засаг дарга бөгөөд ИХ-ын дарга, ЦИХШ-ын дарга нар отрын штабуудаар явж газар дээр нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авсан.

Аймаг, сум	Цаг агаарын бэрхшээл	Авсан арга хэмжээ
<i>Дархан-Уул:</i> Орхон, Хонгор, Шарын гол, Дархан	20-30см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Мал бэлчээрт гарах боломжгүй болсон. Өвс, тэжээл дутагдалтай.	ЗГ-ын 268-р тогтоолоор 200 тн өвс, 100 тн тэжээл долоон нэрийн 4.6 сая төгрөгийн малын эм олгов.
<i>Өмнөговь:</i> Мандал-Овоо, Цогт-Овоо, Цогтцэций, Манлай, Баян-Овоо, Ханбогд, Булган	Аймгийн баруун хойд талын сумдад зудын нөхцөл байдал бий болсон. Мал бэлчээрт гарах боломжгүй болж зам даваа хаагдсан. Өвс тэжээл хомсдолтой. Түлш шатахууны нөөцгүй болсон. Аймгийн төвийн дулаанны станцын хэвийн ажиллагаа алдагдсан. 3000-аад мал хорогдсон.	Аймгийн удирдлагаас тавьсан хүсэлтийг үндэслэн ХХАА-сайдтай ярилцаж улсын нөөцөөс 300тн өвс, 35тн тэжээл олгох тухай ЗГ-ын шийдвэр гаргуулсан. Улсын нөөцийн газраас тус аймагт байгаа нөөц өвснөөс хямдарсан үнээр /700 төгрөг/ малчдад олгох зөвшөөрөл өгсөн. Аймгийн ЗД, ИХ-ын дарга 7 сумын байдалтай биечлэн танилцаж зохион байгуулалтын арга хэмжээ авсан. ДБ яамнаас мэргэжлийн хүмүүс газар дээр нь очиж станцын гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан
<i>Өвөрхангай:</i> Баруунбаян-Улаан, Богд, Баянгол, Төгрөг, Гучин-Ус	Аймгийн нийт нутгийн 70% нь 20-25 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй, Зун нь гантай байсан учир мал тарга тэвээрэг авч чадаагүй. Бэлчээрт гарч чадахгүй байгаа учир мал хорогдож байна. Өвс тэжээл дутагдалтай.	Орон нутгаас малчдад туслах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Аймгийн нөөцөд бэлтгэсэн өвс тэжээлээс сумдад 292,6 тн-ыг Орон нутгаас малчдад туслах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Аймгийн нөөцөд бэлтгэсэн өвс тэжээлээс сумдадаа 292,6тн-ыг олгосон. Энэ нь аймгийн нөөц тэжээлийн 3ны 2-той тэнцэж байна. Мөн хувиараа өвс, тэжээл бэлтгэсэн хүмүүс хямдруулсан үнээр малчдад худалдаж байна
<i>Баянхонгор:</i> Жинст, Заг, Жаргалант, Гурванбулаг	Өвс тэжээл дутагдалтай. Дөрвөн сумдад онцгой хүндрэл бий болсон.	Аймгийн удирдлагаас тавьсан хүсэлтийг үндэслэн ХХАА-сайдтай ярилцаж 400тн өвс 50тн тэжээл олгох тухай ЗГ-ын шийдвэр гаргуулсан. Урьдчилсан байдлаар улсын нөөцийн газраас тус аймагт байгаа улсын нөөцийн өвснөөс хямдарсан үнээр /700 төгрөг/ млчдад олгох зөвшөөрлийг өгсөн.
<i>Дундговь:</i> Адаацаг, Эрдэнэдалай, Дэлгэрхангай	Мал өвөлжилтйн байдал хүндэрсэн. Өвс тэжээл дутагдалтай.	УБОК-оос Адаацаг, Эрдэнэдалай сумдад тус бр 770 мянган төгрөгийн өргөн хэрэглээний эм тусламж олгосон.
<i>Хэнтий:</i> Биндэр, Дадал, Норовлин, Баян-Адрага, Баян-Овоо	15-20 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Орон нутгийн зарим зам, даваа хаагдсан.	Орон нутгаас малчдад туслах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.

Аймаг, сум	Цаг агаарын бэрхшээл	Авсан арга хэмжээ
Дархан-Уул: Орхон, Хонгор, Шарын гол, Дархан	20-30см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Мал бэлчээрт гарах боломжгүй болсон. Өвс, тэжээл дутагдалтай.	ЗГ-ын 268-р тогтоолоор 200 тн өвс, 100 тн тэжээл долоон нэрийн 4.6 сая төгрөгийн малын эм олгов.
Сэлэнгэ: Жаргалант, Шаамар, Орхон, Ерөө, Цагааннуур, Хушаат, Баянгол	20-30 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Орон нутгийн ихэнх зам даваа хаагдсан. Өвс тэжээл дутагдалтай.	ЗГ-ын 268-р тогтоолоор 1000тн өвс, 100тн тэжээл, 12 нэрийн 15,8 сая төгрөгийн хүнс өргөн хэрэглээний бараа олгосон. Тус аймгийн ИХ-ын аврах салбарын аврагчид ЗХ-ний ИХ-ын томилгоог 186-р ангиас туулах чадвар сайтай машин гарган хаагдсан зам, даваанд гарц гаргах, өвс тэжээлийг сум, багт хүргэж байна. Аймгийн Засаг дарга бөгөөд иргэний хамгаалалтын дарга бүх багийнхаа радио холбоог шалгаж радио хурал зохион байгуулан гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл дамжуулахад онцгой анхааран ажиллаж байна.
Төв: Цээл, Заамар, Жаргалант, Угтаал, Лүн, Өндөрширээт Эрдэнэсант, Борнуур, Алтанбулаг, Батсүмбэр	15-20 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Цээл, Заамар, Жаргалант, Угтаал сумууд онцгой хүндрэлтэй. Малаа байнгын нэмэгдэл тэжээлд оруулсан.	ЗГ-ын 268-р тогтоолоор 2000тн өвс, 200тн тэжээл, 12 нэрийн 15,8 сая төгрөгийн хүнс, өргөн хэрэглээний бараа олгосон. Аймгийн Засаг дарга бөгөөд ИХ-ын дарга Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд отрын штаб байгуулан сар тутамд оторчдын нөхцөл байдлыг шалган шаардлагатай арга хэмжээг авч байна.
Орхон: Жаргалант, Баян-Өндөр	20-30 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Мал бэлчээрт гарах боломжгүй болсон. Өвс тэжээл дутагдалтай.	ЗГ-ын 268-р тогтоолоор 400тн өвс, 100тн тэжээл, 7 нэрийн 4,6 сая төгрөгийн малын эм олгосон. Аймгийн Засаг дарга 8 чиглэлд тусгай бүлэг гарган малчдад туслах ажил зохион байгуулж эхлээд байна (14 хоногийн давтамжтйгаар 4-р сарын 1 хүртэл хэрэгжүүлэх юм).

3.2. Судалгаа хийсэн аймаг, сумдад

Судалгаанд хамрагдсан 5 аймгаас Дундговь аймаг 1999-2000, Завхан, Төв аймаг 1999-2000, 2000-2001 оны өвөл хавар малаа их алджээ. Булган, Хэнтий аймагт малын хорогдол бусад аймгуудаас бага хэдий ч 2000-2001 онд үхэр нилээд хорогдсон байна.

Дундговь аймагт 2000 оны зудын дараа малын тоо өсч байгаа бол Завхан, Төв, Булган аймгийнх үргэлжлүүлэн буурсаар байна. Дундговь, Завхан, Төв аймагт 1999, Булган, Хэнтий аймагт 2000 оноос хойш үхэр сүргийн тоо цөөрч байна.


Судалгаа хийсэн 5 аймгийн малын өсөлт, бууралтын байдлаас харахад:


- Сүүлийн 3-4 жилийн малын хорогдол нь жил дамнан эхлэл, өрнөлт, бууралтын явцтай гарчээ.

- Их хорогдлын өмнөх жил бага хэмжээний хорогдол гарч дохио сануулга өгдөг ажээ.
- Ямаа, тэмээ ган зудад өртөөгүй байна.
- Ган тэмээний идшинд нөлөөлөөгүй, харин тэмээний тоо цөөрсөн нь үхэр, хонь, адуу их хорогдсоноос тэмээний махын хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой. Тэмээ өсгөх бодлого нь уур амьсгалд зохицох арга хэмжээнүүдийн нэг мөн.
- Сүүлийн 4 жилд ямааны тоо толгой Булган, Хэнтий аймагт 17-19 хувь нэмэгдсэн байна. Зудад сүрхий өртсөн Төв аймагт ямааны тоо буураагүй нь малчид орлогын гол эх үүсвэр болсон ямаандаа илүү анхаарал тавьдаг, тоо толгойг нь өсгөхийг хичээдэгтэй холбоотой.

Хүснэгт 3.5. Судалгаа хийсэн 5 аймгийн малын тоо толгойн өсөлт, бууралт (өмнөх онтой харьцуулсан, %)

	бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Булган аймаг						
1999	10,30	0,00	7,80	6,66	12,33	10,18
2000	-5,37	0,00	-9,43	-14,60	-4,22	1,76
2001	-4,28	-10,00	-8,25	-29,14	-2,47	10,31
2002	-4,80	-22,22	-10,20	-11,81	-7,67	6,37
Дундговь аймаг						
1999	-4,86	-3,40	-0,55	-7,86	-0,51	-10,46
2000	-39,07	-25,70	-47,79	-65,80	-31,32	-42,44
2001	8,93	-8,06	-1,06	-30,48	3,18	24,81
2002	5,55	0,00	10,18	8,31	0,09	13,20
Завхан аймаг						
1999	-6,59	-2,70	-6,24	-3,72	-6,63	-7,75
2000	-20,18	-19,44	-27,68	-41,78	-16,88	-15,66
2001	-23,42	-9,20	-26,69	-43,80	-27,85	-9,35
2002	-2,93	-11,39	-8,34	-6,42	-5,66	2,70
Төв аймаг						
1996	5,75	-2,33	5,78	9,84	1,60	16,95
1997	9,66	-2,38	7,15	5,69	7,29	21,37
1998	9,28	0,00	7,99	5,87	7,12	17,92
1999	-0,91	2,44	0,30	-8,46	0,21	-0,32
2000	-8,84	-14,29	-17,82	-23,63	-6,29	-2,11
2001	-17,51	-19,44	-22,77	-34,80	-18,76	-5,31
2002	-4,20	-6,90	-3,58	-8,99	-9,81	7,97
Хэнтий аймаг						
1999	5,30	0,00	6,06	5,62	8,10	-0,20
2000	0,62	0,00	-0,77	-4,85	1,61	3,11
2001	-7,80	-12,33	-9,49	-31,15	-5,90	3,56
2002	1,61	-3,13	-2,69	-4,06	-0,60	9,72

Хорогдлын хувиар  < 10%




Зураг 3.4. Судалгаа хийсэн аймгуудын малын тоо толгой

Судалгаанд хамрагдсан аймаг тус бүрээр малын өсөлт, буууралтыг тухайн жилийн цаг агаарын байдалтай холбож судалсан дүнг доор дурьдав.

Булган аймаг

Зураг 3.5.
Булган аймгийн
малын тоо
толгой



Булган аймагт 1998-1999 онд мал 5 төрөл дээрээ өсч нийт малын тоо 10,3 хувиар нэмэгдсэн. Гэвч 2000-2002 онд 3 жил дараалан ямаанаас бусад төрлийн мал, үүнээс үхэр 11.8-29.1%, адуу 8.2-10.2%, тэмээ 10-22.2% тус тус хорогдсон. Ган зудтай 3 жилээс 1999-2000 он адуунд, 2000-2001 он үхэрт, 2001-2002 он тэмээ, хонинд илүү халтай байжээ.

Мал хорогдсон жилүүдийн цаг агаарын байдлыг авч үзвэл зун нь 30 хэмээс халуун өдөр олон хоногоор үргэлжилсэн, 34, 38, 40 хэм хүрсэн аагим халуун болсон, бэлчээр гандсан, өвөл нь 20, 29 см хүртэл цастай, хавар нь 24, 40 м/с хурдтай салхи шуургатай байжээ. Үхэр ихээр хорогдсон 2001 оны 1 сард 35-40 хэм хүрч хүйтэрсэн байна (Хүснэгт 3.6).

Хүснэгт 3.6. Булган аймгийн малын өсөлт, бууралт ба цаг агаар

он	Малын төрөл	өсөлт, бууралт		Цаг агаарын байдал
		1000 толгой	хувь	
1998-1999	Бүгд	150,3	10,3	1998-1999 оны өвөл цас багатай сайхан өвөл болсон 1999 оны зун нь Могод, Гурванбулаг, Бүрэгхангай, Хишиг-өндөр сумын нутгаар гандуу, бусад нутгаар зуншлага сайн байв 1999 оны 7 дугаар сард 5-10 хоног агаарын температур 30 хэмээс давж зарим өдөр 38 хэм хүртэл халсан.
	Тэмээ	0,0	0,0	
	Адуу	15,2	7,8	
	Үхэр	16,5	6,7	
	Хонь	87,6	12,3	
	Ямаа	31,0	10,2	
1999-2000	Бүгд	-86,4	-5,4	1999-2000 оны өвөл Хангал, Бугат, Орхон сумын нутгаар 5-20 см, бусад нутгаар 0-5 см цастай 2000 оны 4 сарын эх, эцсээр нийт нутгаар салхины хурд 28-40 м/с хүрч хүчтэй шороон шуурга шуурсан 2000 оны 6 сард 10, 7 сард 19 хоног агаарын температур 30 хэмээс дээш зарим үед 34 хэм хүрч халсан 2000 оны зун Могод, Бүрэгхангай, Гурванбулаг сумын нутгаар гандуу, бусад сумдад зуншлагатай байв.
	Тэмээ	0,0	0,0	
	Адуу	-19,8	-9,4	
	Үхэр	-38,6	-14,6	
	Хонь	-33,7	-4,2	
	Ямаа	5,9	1,8	
2000-2001	Бүгд	-65,2	-4,3	2000-2001 оны өвөл Баян Агт, Хангал, Сэлэнгэ сумын нутгаар 10-20 см , бусад нутгаар 0-10 см цастай байв. 2001 оны 1 сарын эцсээр агаарын үнэмлэхүй бага температур хасах 35-40 хэм хүрч хүйтэрсэн. 4 сарын 5-9-нд аймгийн хэмжээнд салхины хурд 16-24 м/с, Рашаантад 28-40 м/с хүрсэн. 2001 оны зун нь Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Бугат, Хутаг-Өндөр сум зуншлага сайтай, бусад нутгаар гандуу байв.
	Тэмээ	-0,1	-10,0	
	Адуу	-15,7	-8,2	
	Үхэр	-65,8	-29,4	
	Хонь	-18,9	-2,5	
	Ямаа	35,2	10,3	

2001-2002	Бүгд	-69,2	-4,8	2001-2002 оны өвөл Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Баян агт, Бугат, Хангал сумдын нутгаар 10-29 см, Тэшиг, Сайхан сумдын нутгаар 5-10 см, бусад нутгаар 0-5 см цастай байв 2002 оны зун Сайхан, Могод, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг гантай, бусад сумын нутгаар гандуу 2002 оны 12 сарын 2-4 нд салхины хурд нийт нутгаар 16-20 м/с, зарим үед 20-24 м/с хүрсэн
	Тэмээ	-0,2	-22,2	
	Адуу	-17,8	-10,2	
	Үхэр	-18,9	-11,8	
	Хонь	-57,2	-7,7	
	Ямаа	24,0	6,4	

2002 2003 онд

Булган аймаг зун гантай байсан. Өвөл Баян-Агт, Могод, Сайхан, Бүрэнхангай, Хишиг-Өндөр, Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Рашаант сумд зудтай байсан.

Намар эрт цас орж 11 сараас эхлэн мал байнгын буюу нэмэгдэл тэжээлд оруулсан. Цас дунджаар 20-30 см, хатуурч нягтарсан цасан бүрхүүлтэй, зарим зам даваа хаагдсан. Өвс тэжээл дутагдалтай, отор нүүдэл хийх гарцгүй, бог мал бэлчээрт гарах боломжгүй болсон.


Засгийн газрын 268 дугаар тогтоолоор 1500 тн өвс, 3,5 тн тэжээл хөнгөлттэй үнээр, 12 нэрийн 15.8 сая төгрөгийн хүнс, өргөн хэрэглээний бараа олгосон. Тус аймгийн Иргэний хамгаалалтын аврах салбарын аврагчид зам гарц гаргах, өвс тэжээлийг сум багт хүргэх ажлыг зохион байгуулсан.

Гурванбулаг, Хутаг, Могод сумдад 7, 8 сард 20 гаруй хоног, Ингэт толгой, Хутаг, Тэшигт сумдад 12, 1 сард 15-20 хоног цаг агаар малын бэлчээрлэлтэнд тохиромжгүй байжээ. Өвөл, зуны нийлбэр дүнгээр Хутаг, Тэшиг суманд 37-40 хоног цаг агаар тохиромжгүй байжээ.

Хүснэгт 3.7. Булган аймаг, мал бэлчээрлэлт хүндэрсэн өдрийн тоо

Улирал, сар	2002 оны зун					2002-2003 оны өвөл					Өвөл, зун		
	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Сумын нэр													
Гурванбулаг	5	11	9	25	1,55	0	0	0	1	1	-0,80	26	0,62
Булган	0	4	2	6	-1,10	0	0	0	0	0	-0,96	6	-1,52
Ингэт толгой	2	6	6	14	0,02	0	9	4	2	15	1,32	29	0,94
Могод	4	10	6	20	0,86	1	1	1	1	4	-0,35	24	0,41
Хутаг	4	12	9	25	1,55	0	13	2	0	15	1,32	40	2,12
Тэшиг	2	6	9	17	0,44	0	16	4	0	20	2,08	37	1,80

Дундговь аймаг



Зураг 3.6. Дундговь аймагт 1998-1999 онд бүх мал 4,9 хувиар, төрөл бүр дээрээ 0,6-10,5 хувиар хорогдсон

1999-2000 онд хамгийн их хорогдол гарсан жил болжээ. Нийт мал 39,1 хувиар, төрөл тус бүрээр 25,7-65,8 хувиар хорогдсон. Үүнээс адуу 47,8 хувиар, үхэр 65,8 хувиар хорогджээ.

Харин 2001-2002 онд мал 5 төрлөөр өссөн

Хүснэгт 3.8. Дундговь аймгийн малын өсөлт, бууралт ба цаг агаар


Он	Малын төрөл	өсөлт, бууралт		Цаг агаарын байдал
		толгой	хувь	
1998-1999	Бүгд	-107,6	-4,6	<ul style="list-style-type: none"> • 1999оны 7 дугаар сарын 13-25 нд бүх нутгаар агаарын үнэмлэхүй их температур 36-44 градус хүрч халсан • 1999 оны зун Адаацаг, Эрдэнэдалайн хойд тал, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-угтаал, Баянжаргалан, Гурвансайхан гандуу, бусад сумын нутаг гантай
	Тэмээ	-1,0	-3,4	
	Адуу	-1,2	-0,6	
	Үхэр	-10,8	-7,9	
	Хонь	-5,0	-0,5	
	Ямаа	-89,6	-10,5	
1999-2000	Бүгд	- 822,4	-39,7	<ul style="list-style-type: none"> • 1999-2000 оны өвөл Дэлгэрхангай, Хулд, Луус сумын зааг, Говь-угтаал орчим хэсэгхэн газар 20-40 см, бусад нутгаар 5-20 см цастай • 2000 оны 4 дүгээр сарын эх, эцсээр нийт нутгаар салхины хурд 28-40 м/с хүрч хүчтэй шороон шуурга шуурсан • 2000 оны 6, 7 дугаар сард агаарын үнэмлэхүй их температур 35-42 градус хүрч халсан. 6 дугаар сард 28-30 хоног агаартаа 30 градуусаас давж халсан • 2000 оны зун Сайхан-овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Адаацаг Дэлгэрцагт, Баянцагаан гандуу, бусад сумын нутаг гантай. • 2000 оны 11 дүгээр сарын 2-7 нд нийт нутгаар салхины хурд 16-28 м/с, үүнээс баянжаргалад 28-40 м/с хүрч хүчтэй салхилсан
	Тэмээ	-7,3	-25,7	
	Адуу	-103,6	-47,8	
	Үхэр	- 83,3	-65,8	
	Хонь	-302,7	-31,3	
	Ямаа	-325,5	-42,4	
2000-2001	Бүгд	114,6	8,9	<ul style="list-style-type: none"> • 2000-2001 оны өвөл Сайхан-овоо, Дэлгэрхангай, Хулд Өлзийт цасгүй, бусад сумын нутгаар 0-10 см цастай. • 2000-2001 оны заагаар нийт нутгаар салхины хурд 16-28 м/с хүрч цасан ба шороон шуурга шуурсан • 2001 оны 4 дүгээр сарын 5-9 нд нийт нутгаар хүчтэй салхитай байв. Дэлгэрхангай, Өлзийт, Адаацаг, Дэрэн, Хулд, Луус сумын нутгаар салхины хурд 28-40м/с шороон шуурга шуурсан.
	Тэмээ	-1,7	-8,1	
	Адуу	-1,2	-1,1	
	Үхэр	-13,2	-30,5	
	Хонь	21,1	3,2	
	Ямаа	109,5	24,8	
2001-2002	Бүгд	77,6	5,6	<ul style="list-style-type: none"> • 2001-2002 оны өвөл Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн сумын хойд талаар 10-20 см, төв, өмнө талаар нь 5-10 см цастай бусад сумдын нутгаар 0-5 см цастай. • 2002 оны 3 дугаар сарын 18, 19 –нд нийт нутгаар хүчтэй салхитай, Гурвансайхан, Хулд суманд 28-40 м/с хүрсэн. • 2002 оны 4 дүгээр сарын 4-8 -ны өдрүүдэд нийт нутгаар хүчтэй салхитай, үүнээс Адаацаг, Баянжаргалан, Баянцагаан сумдад салхины хурд 28-38 м/с хүрч шороон шуурга шуурсан • 2002 оны 6 дугаар сарын эх, дундуур агаарын үнэмлэхүй их температур 33-37 градус хүрч халсан • 2002 оны 7 дугаар сарын эцэс гэхэд Дэлгэрцогт, Дэрэн, Гурвансайхан, Сайхан-овоо, Дэлгэрхангай гантай, бусад сумын нутгаар гандуу байв • 2002 оны 12 дугаар сарын 2-4 –ны өдрүүдэд нийт нутгаар хүчтэй салхитай байснаас Мандалговь, Гурвансайхан, Дэлгэрхангай, Хулд сумын нутгаар салхины хурд 20-24 м/с хүрсэн
	Тэмээ	0,0	0,0	
	Адуу	11,4	10,2	
	Үхэр	2,6	8,3	
	Хонь	0,6	0,1	
	Ямаа	72,7	13,2	

1999-2000 оны зудын сургамжийг судлах явцад хөдөө аж ахуйн цаг уурч эрдэмтэн С.Сангидансранжав цагаан зудын хүчийг үнэлэх аргагүй боловсруулж зудын үнэлгээ

хийсэн¹⁸. Хамаарал нь тоон утгаар тодорхой илэрхийлэгдээгүй ч хоорондоо харилцан уялдаатай олон үйл явдлыг мэргэжилтний үнэлэмжээр чанарын зэрэглэл тогтоон тоонд харгалзуулж харьцуулах зарчимд тулгуурласан үнэлгээний эл аргазүйг С.Сангидансранжав байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэхэд олон улс оронд түгээмэл хэрэглэгддэг Леопольдийн матриц, сүлжээ, хяналтын хүснэгтийн арга гэх мэтээс санаа авч боловсруулжээ.

Үнэлгээгээр 1999-2000 оны зудын “**их хүчтэй**” голомт Дундговь аймагт тохиож мал сүргийнх нь 39 % -г хорогдсон (Зураг 3.7).

Зураг 3.7. 1999 2000 оны зудын үнэлгээ



Зураг 3.8. 1999 - 2000 оны зудын малын хорогдол

1999-2000 оны өвөл, хавар Дундговь аймгийн хэмжээгээр 602.5 мянган толгой мал хорогдсон.
2000 оны 1сарын эхээр болсон их хүйтнээр 150 мянган мал хорогдсон.




Зураг 3.7, 3.8 - ын эх сурвалж: 1999-2000 оны зудын сургамж, 2000

¹⁸ С.Сангидансранжав, Зудын үнэлгээний аргачлал, 1999-2000 оны зудын сургамж, 2000


Зураг 3.9. Дундговь аймаг, малын тоо

1999-2000 оны зудын улмаас Дундговь аймгийн мал 2000 онд 1999 оны эцсээс 822 мянган толгой буюу 39% иар хорогдож 1990 оноос өмнөх төвшинд ухарсан.




Зураг 3.10. Дундговь аймаг, Нэг хүнд ногдох малын тоо

Зудын улмаас Дундговь аймгийн нэг хүнд ногдох малын тоо 6-аар цөөрчээ.



Зураг 3.11. Дундговь аймаг, халдварт өвчнөөр өвчлөгсөд

Зудын жилд Дундговь аймагт 989 хүн халдварт өвчнөөр өвдсөн нь өмнөх оныхоос бараг 3 дахин олон байна. 2000 оны зудад нэрвэгдсэн Өвөрхангай аймагт мөн халдварт өвчнөөр өвдсөн хүний тоо 1999 оныхоос мөн 3 дахин олон байна.



Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000

2002-2003 онд

Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай, Дэлгэрхангай сум зудтай байсан. Мал өвөлжилтйн байдал хүндэрсэн. Өвс тэжээл дутагдалтай. УБОК-оос Адаацаг, Эрдэнэдалай сумдад тус бүр 770 мянган төгрөгийн өргөн хэрэглээний эм тусламж олгосон

Дундговь аймгийн цаг уурын станц бүхий 4 сумд өвөл, зуны нийлбэр дүнгээр 20 гаруй хоног цаг агаар тохиромжгүй гэж гарсан нь улсын дундажийн орчимд байна.

Хүснэгт 3.9. Дундговь аймаг, мал бэлчээрлэлт хүндэрсэн өдрийн тоо

Улирал сар	2002 оны зун					2002-2003 оны өвөл						Өвөл, зун	
	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Сумын нэр	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Гурвансайхан	5	6	5	16	0,30	2	0	4	0	6	-0,04	22	0,20
Мандалговь	1	5	1	7	-0,96	1	3	6	5	15	1,32	22	0,20
Сайхан-Овоо	2	5	11	18	0,58	0	0	3	1	4	-0,35	22	0,20
Эрдэнэдалай	1	7	6	14	0,02	0	0	5	1	6	-0,04	20	-0,02

Сумын малын хорогдлын жишээг Эрдэнэдалай сумын жишээгээр дараах хүснэгтүүдэд харуулав. Зудын өмнө Эрдэнэдалай сум малын тоогоороо улсад тэргүүлж байсан. Зудын жил 110 мянган толгой мал хорогдуулж 4 тэрбум гаруй төгрөгийн шууд хохирол үзсэн. Хэрэв хорогдсон малын ашиг шимийг тооцвол бараг 6 тэрбум төгрөгийн хохирол учирсан. Үхэр 4 дахин, адуу бараг 3 дахин цөөрсөн.


Хүснэгт 3.10. Эрдэнэдалай сумын малын тоо, хорогдол

Он	Мал тооллогын дүн (төрлөөр)						Малын хорогдол (төрлөөр)					
	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд
1998	36 564	26 906	2 784	165 446	115 277	346 977						
1999	32 499	22 054	2 445	150 930	93 201	301 129	209	84	2	218	84	597
2000	11 255	5 646	1 328	92 105	49 769	160 103	13 698	15 450	397	46 702	34 313	110 560
2001	14 375	6 175	1 186	102 672	67 219	191 627	282	101	8	3 372	2 103	5 475
2002	12 229	6 972	1 181	98 865	72 502	191 749	495	370	1	775	549	2 190
Дүн							14 684	16 005	408	51 067	37 049	118 822
Он	Мал тооллогын дүн (сүргийн бүтцээр)						Хорогдол (сүргийн бүтцээр)					
	Эцэг мал	Эх мал	Төл	Бод	Бог	Сувай	Эцэг мал	Эх мал	Төл	Бод	Бог	Сувай
1998	3 619	142 765	94 429	66 254	280 723	106 164						
1999	2 584	121 619	101 080	56 998	244 131	75 836	4	339	254	295	302	
2000	3 322	81 881	21 967	18 229	141 874	52 933	896	65 828	22 310	29 545	81 015	21 526
2001	2 435	77 902	69 659	21 736	169 891	41 631	34	3 284	2 940	391	6 072	205
2002	2 180	79 634	58 894	20 382	171 367	51 041	8	2 089	93	666	1 324	

Хүснэгт 3.11. Эрдэнэдалай сумын мал, хорогдлын үнэлгээ

Он	Малын үнэлгээ, 1000 төгрөг						Хорогдлын үнэлгээ, 1000 төгрөг						Ашиг шимийг тооцсон үнэлгээ
	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Дүн	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Дүн	
1998	2 120 712	2 959 660	306 240	3722 535	2 190 263	11 299 410							
1999	1 884 942	2 425 940	268 950	3395 925	1 770 819	9 746 576	12 122	9 240	220	4 905	1 596	28 083	39 316
2000	652 790	621 060	146 080	2072 363	945 611	4 437 904	794 484	1 699 500	43 670	1050 795	651 947	4 240 396	5 936 554
2001	833 750	679 250	130 460	2310 120	1 277 161	5 230 741	16 356	11 110	880	75 870	39 957	144 173	201 842
2002	709 282	766 920	129 910	2224 463	1 377 538	5 208 113	28 710	40 700	110	17 438	10 431	97 389	136 344
Дүн							851 672	1 760 550	44 880	1149 008	703 931	4 510 041	6 314 057

Завхан аймаг



Зураг 3.12. Завхан аймгийн малын тооны өөрчлөлт

Завхан аймагт 1999-2002 онуудад жил бүр малын хорогдол 5 төрөл дээр гарсан. Үүнээс 1999-2000, 2000-2001 онд нийт мал 20,2-23,4 хувь, адуу 26,7-27,7 хувь, үхрийн 41,8-43,8 хувь нь хорогджээ

Хүснэгт 3.12. Завхан аймгийн малын өсөлт, бууралт ба цаг агаар

Он	Малын төрөл	Өсөлт, бууралт		Цаг агаарын байдал
		1000 толгой	хувь	
1999-2000	Бүгд	-490,7	-20,2	1999-2000 оны өвөл Завханмандал цасгүй, Ургамал, Сантмаргац 0-5 см, Тэс, Баянтэс 20-40 см, бусад бүх сумын нутгаар 5-20 см цастай 2000 оны 4 дүгээр сарын эх, эцсээр нийт нутгаар салхины хурд 28-40 м/с хүрч цасан шуурга шуурсан 2000 оны 6 дугаар сараас 7 дугаар сарын дунд үе хүртэл нийт нутгаар агаарын үнэмлэхүй их температур 30-34 градус хүрч халсан
	Тэмээ	-2,1	-19,4	
	Адуу	-53,2	-27,7	
	Үхэр	-113,4	-41,8	
	Хонь	-213,4	-16,9	
	Ямаа	-108,6	-15,7	
2000-2001	Бүгд	-454,6	-23,4	2000-2001 оны өвөл Завханмандал 0-10 см, Урамал, Сантмаргац, Дөрвөлжин 10-20 см, бусад бүх сумдын нутгаар 20-40 см цастай 2001 оны 7 дугаар сарын эцэс гэхэд Идэр сумын нутгаар гантай, бусад бүх нутгаар гандуу байв
	Тэмээ	-0,8	-9,2	
	Адуу	-37,1	-26,7	
	Үхэр	-69,2	-43,8	
	Хонь	-292,6	-27,8	
	Ямаа	-54,7	-9,4	


2002-2003 онд

2002 оны зун цаг агаар мал аж ахуйд харьцангуй тохиромжтой байсан. Өвөл, зуны нийлбэр дүнгээр Баянтэс, Дөрвөлжин, Тосонцэнгэл сумдад 25-30 хоног тохиромжгүй байжээ.

Хүснэгт 3.13. Завхан аймаг, мал бэлчээрлэлт хүндэрсэн өдрийн тоо

Улирал сар	2002 оны зун					2002-2003 оны өвөл					Өвөл, зун		
	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Сумын нэр													
Баянтэс	1	5	5	11	-0,40	0	11	0	3	14	1,17	25	0,52
Дөрвөлжин	1	10	8	19	0,72	0	5	3	1	9	0,41	28	0,84
Отгон	0	4	1	5	-1,24	0	6	2	2	10	0,56	15	-0,55
Нөмрөг	0	4	2	6	-1,10	0	9	1	1	11	0,72	17	-0,34
Улиастай	0	4	5	9	-0,68	0	0	0	0	0	-0,96	9	-1,19
Тосонцэнгэл	0	5	5	10	-0,54	0	14	5	1	20	2,08	30	1,05
Цэцэн-Уул	0	4	6	10	-0,54	0	2	1	1	4	-0,35	14	-0,66

Төв аймаг



Зураг 3.13. Төв аймгийн малын тоо толгойн өөрчлөлт

Төв аймагт 1999-2002 онуудад жил дараалан малын хорогдол гарсан. 1999-2000, 2000-2001 онуудад нийт мал 8,8-17,5 хувь, тэмээ 14,3-19,4 хувь, адуу 17,8-22,8 хувь, үхэр 23,6-34,8 хувиар хорогджээ.

Хүснэгт 3.14. Төв аймгийн малын өсөлт, бууралт ба цаг агаар

Он	Малын төрөл	өсөлт, бууралт		Цаг агаарын байдал
		1000 толгой	хувь	
1999-2000	Бүгд	-8.8	-8.8	<ul style="list-style-type: none"> 1999-2000 оны өвөл Мөнморьт, Баян, Баянжаргалан, Баянцагаан, Сэргэлэн, Алтанбулаг сумдын нутгаар 0-5 см, бусад сумдын нутгаар 5-20 см цастай 2000 оны 4 дүгээр сарын эх, эцсээр нийт нутгаар салхины хурд 28-40 м/с хүрч шороон шуурга шуурсан 2000 оны 6 дугаар сараас 7 дугаар сарын дунд үе хүртэл нийт нутгаар агаарын үнэмлэхүй их температур 30-34 градус хүрсэн, 6 дугаар сард 10-19 өдөр 30 градусаас давж халсан 2000 оны 7 дугаар сарын эцэс гэхэд Цээл, Заамар, Угтаал, Жаргалант сумын нутгаар зуншлага сайн, бусад сумдын нутгаар гандуу байв.
	Тэмээ	-14.3	-14.3	
	Адуу	-17.8	-17.8	
	Үхэр	-23.6	-23.6	
	Хонь	-6.29	-6.3	
	Ямаа	-9.1	-2.1	

2000-2001	Бүгд	-17.5	-17.5	<ul style="list-style-type: none"> • 2000-2001 оны өвөл Заамар, Эрдэнэсант, Лүн, Өндөрширээт, Бүрэн, Дэлгэрхаан, Баян-өнжүүл, Баянцагаан, Баян сумдын нутгаар 0-10 см, бусад сумдын нутгаар 10-20 см цастай байв • 2000-2001 заагаар нийт нутгаар салхины хурд 16-28 м/с хүрч хүчтэй салхилсан • 2001 оны 1 дүгээр сард агаарын үнэмлэхүй бага температур хасах 35-40 градус хүрч эрс хүйтэрсэн. • 2001 оны 4 дүгээр сарын 5-9 –нд нийт нутгаар салхины хурд 16-24 м/с, Лүн, Цээл, Баянжаргалан, Баянцагаанд 28-40 м/с хүрч шороон шуурга шуурсан • 2001 оны 7 дугаар сарын эцэс гэхэд Заамар, Угтаалцайдам, Алтанбулаг, Сэргэлэн сумдын нутгаар зуншлага сайн, бусад сумдын нутгаар гандуу байв
	Тэмээ	-19.4	-19.4	
	Адуу	-22.8	-22.8	
	Үхэр	-34.8	-34.8	
	Хонь	-18.8	-18.7	
	Ямаа	-5.3	-5.3	

2002-2003 онд


Цээл, Заамар, Жаргалант, Угтаал, Лүн, Өндөрширээт Эрдэнэсант, Борнуур, Алтанбулаг, Батсүмбэр сумд зудтай байсан. 15-20 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Цээл, Заамар, Жаргалант, Угтаал сумууд онцгой хүндрэлтэй. Малаа байнгын нэмэгдэл тэжээлд оруулсан. ЗГ-ын 268-р тогтоолоор 2000тн өвс, 200тн тэжээл, 12 нэрийн 15,8 сая төгрөгийн хүнс, өргөн хэрэглээний бараа олгосон. Аймгийн Засаг дарга бөгөөд ИХ-ын дарга Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд отрын штаб байгуулан сар тутамд оторчдын нөхцөл байдлыг шалган шаардлагатай арга хэмжээг авсан.

2002 оны зун Бүрэн, Эрдэнэсантад 22-25 хоног мал аж ахуйд тохиромжгүй байсан. Өвөл өнтэй оржээ. Өвөл, зуны нийлбэр дүнгээр Эрдэнэсант 29 хоног, Жаргалант 22 хоног тохиромжгүй байжээ.

Хүснэгт 3.15. Төв аймаг, мал бэлчээрлэлт хүндэрсэн өдрийн тоо

Улирал сар	2002 оны зун					2002-2003 оны өвөл					Өвөл, зун		
	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Сумын нэр	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Бүрэн	2	8	12	22	1,14	0	0	0	1	1	-0,80	23	0,30
Баянчандмань	3	7	5	15	0,16	1	0	0	1	2	-0,65	17	-0,34
Баян-Өнжүүл	1	8	5	14	0,02	0	1	1	1	3	-0,50	17	-0,34
Жаргалант	2	8	8	18	0,58	1	1	1	1	4	-0,35	22	0,20
Алтанбулаг	1	8	8	17	0,44	0	0	1	0	1	-0,80	18	-0,23
Зуун мод	0	7	3	10	-0,54	1	0	4	1	6	-0,04	16	-0,45
Лүн	1	7	3	11	-0,40	0	7	1	0	8	0,26	19	-0,13
Мааньт	0	3	3	6	-1,10	1	1	2	2	6	-0,04	12	-0,87
Мөнгөнморьт	0	6	1	7	-0,96	0	0	1	1	2	-0,65	9	-1,19
Угтаал	4	8	5	17	0,44	0	0	0	1	1	-0,80	18	-0,23
Эрдэнэсант	7	10	8	25	1,55	1	0	3	0	4	-0,35	29	0,94

Хэнтий аймаг



Зураг 3. 14. Хэнтий аймгийн малын тоо толгойн өөрчлөлт

᠐ᠦᠶᠢᠳᠡᠡ ᠠᠡᠢᠯᠠᠭᠠᠳᠤ 1998-1999 ᠶᠢᠠ ᠠᠵᠢᠳᠤ ᠶᠢᠰᠢ 5,3᠔᠔ᠠᠡᠳᠠᠳᠤ, ᠵᠵᠢᠭᠦᠨ ᠠᠠᠳᠠᠳᠤ, ᠵᠳᠦᠳᠤ, ᠳᠢᠶᠢ 5,6-8,1 ᠳ᠔᠔ᠠᠡᠳᠠᠳᠤ ᠶᠢᠨᠶᠢ 2001 онд ямаанаас бусад мал хорогдсон. Үүнээс адуу 9,5 хувь, үхэр 31,2 хувиар хорогдсон байна.

Хүснэгт 3.16. Хэнтий аймгийн малын өсөлт, бууралт ба цаг агаар

Он	Малын төрөл	өсөлт, бууралт		Цаг агаарын байдал
		1000 толгой	хувь	
2000-2001	Бүгд	-114,7	-7,8	<ul style="list-style-type: none"> 2000-2001 оны өвөл Дадал, Биндэр, Батширээт 20-40 см, Дархан, Галшар, Баянхутаг 0-10 см, бусад сумдын нутгаар 10-20 см цастай байв 2000-2001 оны заагаар нийт нутгаар салхины хурд 16-28 м/с хүрч салхилсан 2001 оны 1 дүгээр сарын сүүлчээр нийт нутгаар агаарын үнэмлэхүй бага температур хасах 41-48 градус, Батширээт суманд 49-51 градус хүрч эрс хүйтэрсэн 2001 оны 3 дугаар сарын эхээр салхины хурд нийт нутгаар 16-34 м/с хүрч цасан ба шороон шуурга шуурсан 2001 оны 4 дүгээр сарын 5-9 –нд салхины хурд нийт нутгаар 16-24 м/с, Хэрлэнбаян улаанд 28-40 м/с хүрч шороон шуурга шуурсан 2001 оны 7 дугаар сарын эцсээр Дархан, Баянмөнх, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Галшар, Баянхутаг, Баян-овоо сумдын нутгаар гандуу, бусад сумдын нутгаар зуншлага сайн байв.
	Тэмээ	-0,9	-12,3	
	Адуу	-18,3	-9,5	
	Үхэр	-67,9	-31,2	
	Хонь	-40,6	-5,9	
	Ямаа	13,0	3,6	

2002-2003 онд

Биндэр, Дадал, Норовлин, Баян-Адрага, Баян-Овоо сумд зудтай байсан. 15-20 см-ийн нягтарсан цасан бүрхүүлтэй. Орон нутгийн зарим зам, даваа хаагдсан. Орон нутгаас малчдад туслах талаар зохион байгуулалтын зарим арга хэмжээ авсан. 2002 оны зун цаг агаар мал аж ахуйд харьцангуй тохиромжтой байсан. Өвөл, зуны нийлбэр дүнгээр Баян-Овоо 27 хоног, Оргил 19 хоног тохиромжгүй байжээ.

Хүснэгт 3.17. Хэнтий аймаг, мал бэлчээрлэлт хүндэрсэн өдрийн тоо

Улирал сар	2002 оны зун					2002-2003 оны өвөл						Өвөл, зун	
	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Сумын нэр	6	7	8	Дүн	Δ/δ	11	12	1	2	Дүн	Δ/δ	Дүн	Δ/δ
Дадал	0	6	3	9	-0,68	0	4	0	1	5	-0,20	14	-0,66
Галшир	2	6	1	9	-0,68	1	0	2	2	5	-0,20	14	-0,66
Баян-Овоо	0	3	6	9	-0,68	1	11	3	3	18	1,78	27	0,73
Биндэр	0	6	8	14	0,02	0	0	0	1	1	-0,80	15	-0,55
Өндөрхаан	1	4	4	9	-0,68	0	0	1	3	4	-0,35	13	-0,77
Оргил	1	7	6	14	0,02	1	0	3	1	5	-0,20	19	-0,13

4.0 Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьсал малчин өрхийн амьжиргаанд нөлөөлсөн нь

Байгаль, цаг уурын өөрчлөгдөл, хувьслаас малчин өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг 1999-2002 оны ган, зудын бодит жишээн дээр статистик мэдээ, малчин өрхөөс авсан анкетийн судалгааны өгөгдөл мэдээлэлд тулгуурлан улсын болон судалгаанд хамрагдсан 5 аймаг, 14 сумаар үнэлсэн ба судалгаа, үнэлгээний үр дүнг энэ бүлэгт тайлбарлан бичив.


Бүлгийн эхэнд 5 аймгийн судалгааны нэгдсэн дүнг, сүүлийн хэсэгт аймаг тусбүрээр гарсан үр дүнг тайлбарлан бичив.

4.1. Улсын хэмжээнд

Мал хувьчлалаар олон мянган малчид малтай болсон. Одоо Монгол Улсын нийт малын 97.2% нь хувийн өмчинд байна. 2002 оны эцсээр мал бүхий 243 мянган айл өрх байгаа ба үүний 72% буюу 176 мянга нь малчин өрх байна.

1999 оноос хойшхи байгаль, цаг уурын аюул бэрхшээл нь малчдын амьжиргааг доройтуулсан. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй тэмцэх мэдлэг, туршлага дутсаны улмаас олон сая мал хорогдож хөдөөд ажилгүйдэл, ядуурал үлэмж нэмэгдсэн. Сүүлийн хэдэн жилд мал бүхий болон малчин өрхийн тоо буурах хандлагатай байна (Зураг 4.1).

Зураг 4.1. Малчин өрхийн тоо



Малчдын тоо, насны байдалд өөрчлөлт орж байна. 2002 онд малчдын тоо 1999 оныхоос 28 мянгаар цөөрч 389765 болсон. Малчдын 54 хувь нь 16-34, 33 хувь нь 35-аас тэтгэвэрийн нас хүртэлх насны малчид байна. 2000 оноос хойш залуу малчдын тоо цөөрч байна.

Малчин өрхийн амьжиргааг харуулах үзүүлэлт нь өрхөд ногдох малын тоо гэж үздэг хэдий ч энэ талаар статистик мэдээлэл байхгүй. Харин мал бүхий өрхийг малын тоогоор ангилсан мэдээлэл байдаг. Эл мэдээллээс жил жилийн өөрчлөлтийг бодож Хүснэгт 4.1-д үзүүлэв. Үүнээс харахад 1990-1998 онд олон малтай өрхийн тоо

нэмэгдэж байсан бол 1999 оноос хойш олон малтай нь цөөрч, цөөн малтай өрхийн тоо эрс нэмэгдэх болжээ.

Хүснэгт 4.1. Өрхөд ногдох малын тооны өөрчлөлт, 1990-2000

	1991-1990	1992-1991	1993-1992	1994-1993	1995-1994	1996-1995	1997-1996	1998-1997	1999-1998	2000-1999	2001-2000	2002-2001
<10	-11,4	-6,1	-10,5	-1,6	-3,1	-3,9	-4,2	-3,9	-3,0	2,7	2,4	-0,6
11-30	-16,4	-2,4	-12,2	-3,2	-3,2	-3,5	-6,1	-4,2	-0,9	4,5	2,6	-0,3
31-50	8,2	-0,7	-6,5	-1,7	-1,8	-2,7	-2,7	-1,1	-1,8	3,2	1,0	0,1
51-100	21,3	2,4	-2,9	-0,4	-1,9	0,4	2,3	-0,8	-1,6	1,7	-2,9	-4,3
101-200	21,2	10,9	8,6	1,8	0,4	1,8	9,9	2,2	0,4	-8,0	-8,4	-5,3
201-500	5,2	8,0	10,9	3,7	3,1	1,6	1,6	1,7	1,4	-4,2	-5,5	-2,6
501-999	0,00	0,38	0,89	0,85	0,97	0,58	0,46	0,98	0,33	-0,85	-1,19	-0,25
1000-1499	0,00	0,01	0,04	0,09	0,14	0,17	0,09	0,33	0,20	-0,17	-0,25	-0,04
1500-2000	0,00	0,00	0,00	0,00	0,01	0,02	0,02	0,01	0,01	-0,03	-0,01	0,00
2001<	0,00	0,00	0,00	0,00	0,01	0,00	0,00	0,02	0,01	0,00	-0,01	-0,01

1999 онд 100-аас цөөн мал бүхий өрхийн тоо 58.5% байсан бол 2002 онд энэ тоо 69% болж өссөн. 101-200 малтай өрхийн тоо 18.9% болж нэмэгдсэн (Хүснэгт 4.2). 1999 - 2002 оны зурад нийт 12100 өрх огт малгүй болж, мал бүхий өрхийн тоо 26.7 мянга, 200- аас олон малтай өрх 12.3 мянга, 500- аас олон малтай өрх 2.8 мянгаар тус тус цөөрсөн. Ингэснээр 200 - аас олон малтай өрх 1999 онд нийт мал бүхий өрхийн 16.4% байсан бол 2002 онд 12% болж буурчээ.

Table 4.2. Мал бүхий өрхийн тоо

Өрхөд ногдох малын тоо	Мал бүхий өрхийн тоо				
	1999	2000	2001	2002	2002-1999
<10	28 669	31 361	33 797	33 183	4 514
11-30	35 970	40 436	43 082	42 796	6 826
31-50	31 874	35 041	36 030	36 165	4 291
51-100	61 347	63 096	60 195	55 905	-5 442
101-200	67 840	59 821	51 383	46 051	-21 789
<i>Дүн < 200</i>	<i>225 700</i>	<i>229 755</i>	<i>224487</i>	<i>214100</i>	
201-500	37 635	33 408	27 949	25313	-12 322
501-999	5 438	4 591	3 406	3160	-2 278
1000-1499	1 061	893	639	601	-460
1500-2000	75	48	38	36	-39
2001+	41	37	31	24	-17
<i>Дүн > 200</i>	<i>44 250</i>	<i>38 927</i>	<i>32 777</i>	<i>29134</i>	
Total	269950	268 732	256 550	243 234	
100-аас цөөн малтай өрхийн эзлэх хувь	58%	63%	67%	69%	

Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл

1999-2000 оны өвөл хавар Монгол орны нийт нутгийн 70 гаруй хувийг хамарсан зуд болж улсын эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйд ноцтой хохирол учирсан.

1999-2000 онд улсын хэмжээгээр 190-ээд мянган өрхийн 33.5 сая өвөлжсөнөөс 13 аймаг, 157 сумын нутаг, 80.9 мянган өрхийн 452 мянган хүн, 7 сая зудын нөхцөлд байв. Зудад 2.4 сая мал хорогдсоныг Статистикийн төв газраас орон нутгийн зах зээлийн ханшаар үнэлж 91.7 тэрбум төгрөгийн хохирол учирсныг тогтоосон¹⁹.

2000 оны зудын уршгаар 2369 айл өрх малгүй болсны дээр 10 гаруй мянган өрх 100 хүрэхгүй толгой малтай үлдэж амьжиргаа нь доошилж хөдөө орон нутагт ажилгүйдэл, ядуурал эрс нэмэгдсэн.

Зудад ихээхэн нэрвэгдсэн Дундговь, Өвөрхангай, Завхан, Увс, Баянхонгор, Төв аймгуудын нийт малын 5,7-28,6 хувь нь хорогдсон бөгөөд эдгээр аймгийн малын хорогдол нь улсын хэмжээнд гарсан хорогдлын 84,4 хувь, үүний дотор Дундговь, Өвөрхангай, Завханы хорогдол нь улсын нийт хорогдлын 61,7 хувийг эзэлж байсан.

Өнөөдөр малчин өрхийн чухам хэдэн хувь нь нэн ядуу, ядуу, бага орлоготой гэдэг албан ёсны тоо баримт байхгүй байна. Тооцоогоор 1999-2002 онд 100 хүрэхгүй малтай малчин өрхийн тоо 20 гаруй мянгаар нэмэгдсэн ба нийт малчин өрхийн олонхийг эзлэх болсон. НҮБХХ, Дэлхийн банкнаас ядуурлын талаар зарим судалгааны ажлыг санхүүжүүлж хийлгэсэн ба эдгээрийн үр дүн нь ядуурлын талаархи албан ёсны мэдээлэл болон хэрэглэгдэж байна. Бид ч энэ мэдээлэл дээр суурилан судалгаагаа явуулсан.

- Хөдөөгийн хүн амын олонхи нь ядуурлын төвшнөөс доогуур орлоготой байна. Малчдын орлого олон зүйлээс хамаардагийн дотор малын төрөл, тоо толгой, цаг уур, улирал, гадаад, дотоод зах зээлийн үнэ, зах зээлээс алслагдсан байдал гэх мэт. 2001 оны судалгаагаар малчдын орлогын 52.8% нь ноолуур, 28.6% нь амьд малын арилжаа, 6.4% нь арьс, шир, 5.4% нь мах, 4.3% нь ноос, 1.2% нь сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтаас олдог гэж гарсан байна.
- Дэлхийн банкны 2000 оны амьжиргааны төвшний судалгаагаар малчдад учирч буй дараах бэрхшээлийг нэрлэсэн байна:
 - Усан хангамж хүрэлцээгүй
 - Малын хашаа, хороо хүрэлцээгүй
 - Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй
 - Нийгмийн үйлчилгээ, ялангуяа боловсрол, эмнэлгийн үйлчилгээ авахад хүндрэлтэй
 - Зах зээлээс алслагдсан байдал ба унааны хүндрэл
 - Зээлийн үйлчилгээ авах боломжгүй
- 2002 онд Статистикийн газраас өрхийн орлого, зарлагын дэлгэрэнгүй судалгаа явуулсан, үр дүн нь хараахан гараагүй байна. 2002 оны эхний хагас жилээр гаргасан өрхийн орлого, зардлагын судалгааны дүнг Хүснэгт 4.3-т үзүүлэв. Судалгаанаас харахад хөдөөгийн айл өрхийн орлого нь зарлагаасаа илүү байна. Улаанбаатар хотод орлого, зарлагын тэнцэл хасах гарсан нь энд ядуурал бодитой нүүрлэснийг нотолж байна.

Хүснэгт 4.3. Өрхийн сарын орлого, зарлага, 2002 оны 7 сар

	Орлого	Зарлага	Тэнцэл	Үр ашиг %
--	--------	---------	--------	-----------

¹⁹ 1999-2000 оны зудын сургамж, НҮБХХ, Монгол Улсын Засгийн газар, ЖЭМР ХХК, 2000

Улсын дундаж	120 884,4	98 940,9	21 943,5	18
Нийслэл хот	144 659,5	153 370,7	-8 711,2	-6
Аймгийн төв	104 967,8	98 008,1	6 959,7	7
Сумын төв	106 369,1	85 192,4	21 176,7	20
Хөдөө	112 266,9	70 256,2	42 010,7	37

Эх үүсвэр: Статистикийн газар

Өөр нэгэн сонирхолтой үр дүн бол хот, хөдөөгийн айл өрхийн орлого, зарлагын бүтцийн ялгаа юм (Хүснэгт 4.4). Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн өрхийн орлогын 60-65% нь цалингаас бүрддэг бол хөдөөгийн айл өрхийн орлогын 70 хувийг мал аж ахуй бүрдүүлдэг байна. Мал аж ахуй нь байгаль цаг уурын эрхшээлд байдаг тул хөдөөгийн хүн амын амьжиргаа нь хот, суурин газрын хүн амаас илүү байгаль цаг уурын сөрөг нөлөөлөлд илүү өртөмтгий байна. Сумын хүн амын амьжиргаа нь мал аж ахуйгаас хамаардаг хэдий ч малчдыг бодвол 2 дахин бага хамааралтай ажээ.

1999-2002 оны уур амьсгалын аюул гамшиг нь хэдийгээр байгалийн давагдашгүй хүчин зүйл мөн боловч түүний үр дагавар нь нийгэм, эдийн засгийн байдал, хүний үйл ажиллагаатай холбоотой. Зудын гамшиг нь ганц нэг жил, улирлын асуудал биш. Зудын хохирол нь өмнөх жилүүд, өнөөгийн чадавхийн бодит үнэлгээ бөгөөд цаашид ч 5-15 жилийн хөгжилд нөлөөлнө.

Хүснэгт 4.4 Сарын мөнгөн орлогын бүтэц

	Улсын дундаж	Нийслэл хот	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Цалин хөлс	0,29	0,46	0,39	0,29	0,03
Тэтгэвэр тэтгэмж	0,08	0,095	0,089	0,08	0,07
Нийгмийн даатгал	0,00	0,00	0,01	0,00	0,00
МАН-н олого	0,30	0,01	0,07	0,31	0,70
Газар тариалангийн	0,005	0,001	0,007	0,009	0,007
ХАА н бус ажил, үйлчилгээний орлого	0,07	0,07	0,10	0,07	0,04
Худалдааны орлого	0,15	0,19	0,21	0,17	0,07
Үл хөдлөх хөрөнгийн орлого	0,02	0,03	0,01	0,01	0,01
Мөнгөн тусламж	0,03	0,07	0,03	0,01	0,01
Зээл	0,03	0,02	0,03	0,04	0,03
Бусад орлого	0,04	0,06	0,05	0,03	0,02

Эх үүсвэр: Статистикийн газар

4.2. Судалгаа хийсэн аймаг, сумдын малчдын амьжиргаа

Судалгаанд хамрагдсан өрх

Анкетийн судалгааны төлөөллийг сумын нийт малчин өрхийн 6 хувийн төвшинд байлгах үүднээс тухайн аймгаас сонгосон сумдын малчин болон мал бүхий өрхийн 2001 оны статистик мэдээ ашиглан асуулганд хамрагдах өрхийн тоог тогтоосон (Хүснэгт 4.5).

Хүснэгт 4.5. Малчин өрхийн статистик мэдээлэл, 2001 он

Аймгийн нэр	Сумын нэр	Малчин өрхийн тоо	Малчин өрхийн ам бүлийн тоо	16-аас дээш насны малчдын тоо	үүнээс эмэгтэй	Амины малтай өрхийн тоо	Асуулга авах/авсан малчин өрхийн тоо
Завхан	Тосонцэнгэл	873	3662	1946	987	1273	52
	Дөрвөлжин	494	2094	1162	529	596	30
	Алдархаан	676	2795	1712	816	932	41
	Аймгийн дүн	11081	46283	26762	12050	15369	123/114
Төлөөллийн аймагт эзлэх хувь		18.4	18.5	18.0	19.4	18.2	
Төв	Алтанбулаг	567	2323	1253	518	682	34
	Баяннөжүүл	566	2355	1407	575	584	34
	Аймгийн дүн	9804	39504	21323	7687	15755	68/70
Төлөөллийн аймагт эзлэх хувь		11.6	11.8	12.5	14.2	8.0	
Дундговь	Эрдэнэдалай	1341	5543	3310	1241	1576	80
	Өлзийт	591	2425	1345	624	676	35
	Гурвансайхан	482	1995	1071	466	592	29
	Аймгийн дүн	8077	363163	18255	7999	9587	145/134
Төлөөллийн аймагт эзлэх хувь		29.9	2.7	31.4	29.1	29.7	
Хэнтий	Баян - овоо	248	1030	523	169	339	15
	Дадал	421	1614	809	349	480	25
	Өмнөдэлгэр	923	3733	1862	540	1235	55
	Аймгийн дүн	8016	31697	16509	6494	10271	
Төлөөллийн аймагт эзлэх хувь		19.9	20.1	19.3	16.3	20.0	96/107
Булган	Булган	328	1274	681	299	844	20
	Бугат	385	1319	762	400	467	23
	Тэшиг	577	2308	1646	823	755	35
	Аймгийн дүн	7808	29681	17045	7336	11760	
Төлөөллийн аймагт эзлэх хувь		16.5	16.5	18.1	20.7	17.6	77/120
Төлөөллүүдийн дундаж		19.3	13.9	19.9	20.0	18.7	508/545

Судалгаанд малчин өрхийг 100% төлөөлж чадах бүх насны, эрэгтэй, эмэгтэй, янз бүрийн боловсролтой хүмүүс хамрагдсан. Асуулганд хариулсан хүмүүсийн олонхи нь малчид байв. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд зонхилсон.

Судалгаанд хамрагдагчдыг насны бүлгээр нь авч үзвэл, 21-30 насныхан 13.6 хувь, 31-40 насны 25.8 хувь, 41-50 насны 27.6 хувь, 51-60 насны 17.7 хувь, 61-ээс дээш насныхан 14.0 хувь, 20 хүртлэх насны хүмүүс 1.2 хувийг тус тус эзэлж байна. Иймд тэдний дийлэнх буюу 71.1 хувь нь 31-60 насны мал маллагааны дадлага туршлагатай

хүмүүс хамрагдсан байна гэж үзэж болохоор байна. Тэдний ихэнх нь асуултад бие даан хариулт өгөх чадвартай байв.

Хүснэгт 4.6. Судалгаанд хамрагдагсдын хүйс, эрхэлдэг ажил

	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Судалгаанд хамрагдсан өрх	545	120	134	114	70	107
Үүнээс хөдөө амьдардаг, %	81,5	95,2	91,8	60,5	70	83,2
Хүйс:						
Эрэгтэй, %	66,6	56,6	84,3	64	47,1	71
Эмэгтэй, %	33,4	43,4	15,7	36	52,9	29
Эрхэлдэг ажил:						
Малчин, %	82,0	86,7	94	64	77,2	84,1
Бусад ажил, %	3,7	3,7	3,7	7,9	10,0	
Тэтгэвэрт, %	2,9	4,8		4,4	5,7	
Ажилгүй, %	3,5	4,8		7,9		

Хүснэгт 4.7. Судалгаанд хамрагдагсдын нас

Нас	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
20 хүртэл, %	2,4		1,5	7,9		1,9
21-30, %	13,4	10,8	11,9	11,4	17,1	17,8
31-40, %	26,1	28,9	28,4	23,7	30	19,6
41-50, %	26,6	13,2	26,9	27,2	41,4	30,8
51-60, %	18,5	28,9	16,4	19,3	5,7	16,8
61-ээс дээш, %	14,3	18,1	14,9	15,8	5,7	13,1

Боловсролын хувьд, 29 хувь нь бага, 38 хувь нь бүрэн бус дунд, 15 хувь нь бүрэн дунд, 12 хувь нь тусгай мэргэжлийн, 3 нь хувь нь дээд боловсролтойгоос гадна 2 хувь боловсролгүй байна. Боловсролоор судалгаанд оролцогсод жигд дундаж түвшинд, бүрэн бус дунд ба бага боловсролтой нь зонхилж байв.

Хүснэгт 4.8. Судалгаанд хамрагдагсдын боловсрол

Боловсрол	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Дээд, %	2,8	3,6	1,5	3,5		4,7
Тусгай мэргэжил, %	11,7	13,2	4,5	11,4	21,4	13,1
Бүрэн дунд, %	14,7	16,9	14,2	8,8	20	15,9
Бүрэн бус дунд, %	38,0	45,8	41	35,1	31,4	32,7
Бага, %	28,8	16,9	36,6	36,8	22,9	28
Боловсролгүй, %	2,2	2,4	0,7	3,5		3,7

Ам бүлийн хувьд, 2.4 хувь нь ганцаараа, 22.4 хувь нь 2-3 хүнтэй, 41.3 хувь нь 4-5, 26.0 хувь нь 6-7, 7.1 хувь нь 8-9, 2.0 хувь нь 10-аас дээш хүнтэй гэр бүлд амьдарч байгаагаас гадна судалгаанд хамрагдагсдын 39.6 хувь нь ясли цэцэрлэгийн насны, 61.6 хувь нь ЕБС-ийн насны, 14.4 хувь нь дээд ТМС-ийн сурагчид, хүүхдүүдтэй байна. Мөн 30.9 хувь нь тэтгэвэрийн насны, 74.0 хувь нь хөдөлмөрийн насны ажил

эрхэлдэг, 36.0 хувь нь хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүмүүстэй гэр бүл байна.

Хүснэгт 4.9. Судалгаанд хамрагдагсдын ам бүлийн хэмжээ

Ам бүл	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Ганцаараа, %	2,4	1		4,4		5,6
2-3 хүнтэй, %	22,4	22,9	28,4	19,3	15,7	22,4
4-5 хүнтэй, %	41,3	44,6	39,5	36,8	52,9	38,3
6-7 хүнтэй, %	26,0	26,5	24,6	30,7	24,3	23,4
8-9 хүнтэй, %	7,1	3,6	8,2	7,9	5,7	8,5
10-аас олон, %	2,0	1	0,7	3,5	1,4	2,8

Дунджаар нэг гэр бүл 4-5 хүнтэй, талаас илүү хувь нь ЕБС-ийн сурагч хүүхдүүдтэй, 74.0 хувь нь хөдөлмөрийн насны ажил эрхэлдэг хүнтэй гэр бүл ажээ. Гэвч гэр бүл дотор хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүмүүс 36.0 хувь байгааг анхаарах хэрэгтэй юм.

Хүснэгт 4.10. Судалгаанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлт, хүүхэд

	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Хөдөлмөр эрхлэлт:						
Хөдөлмөрийн насны, ажил эрхэлдэг, %	74,7	84,3	88,8	59,6	58,6	72,9
Хөдөлмөрийн насны, ажил эрхэлдэггүй, %	36,3	41	12,7	49,1	60	31,8
Тэтгэврийн насны, %	31,9	44,6	30,6	31,6	21,4	26,2
Гэр бүлдэх хүүхэд:						
Ясли, цэцэрлэгийн, %	39,1	33,7	43,3	34,2	45,7	41,1
Сургуулийн (1-10 р анги), %	61,7	61,4	61,2	65,8	65,7	55,1
ТМС-ийн, %	14,5	15,7	9,7	13,2	17,1	18,7

Ам бүлийн хувьд тэдний дийлэнх буюу 70.1 хувь нь эхнэр нөхөр хүүхдүүдтэйгээ буюу элэг бүтэн дан гэр бүл зонхилж байна.

Малчин өрхийн амьжиргаа

Судалгаанд хамрагдсан малчдын амьдрал ахуй 5 жилийн өмнөхөөс ямар болсныг судлахад, 7.9 хувь нь сайжирсан, 35.4 хувь нь хэвэндээ, 54.3 хувь нь дордсон гэж хариулсан байна. Үүнээс Завхан аймгийн малчдын амьдрал хамгийн их дордсон (78.1%), харин Хэнтий аймгийнх гайгүй (21.5%) байна.

Амьдрал дордсон шалтгаанаа тэдний 92.1 хувь нь байгаль, цаг уурын аюул гамшиг, эрсдэлтэй холбоотой гэж тайлбарласан юм. Үүнээс үзэхэд малчдын амьжиргааны гол үндэс нь мал сүрэг бөгөөд орлогын зонхилох хэсэг нь мал, түүний ашиг шимээс олж буй орлогоос бүрдэж, түүнээс хамаарч буй нь тодорхой байна.

Малчин өрхийн хөрөнгө, орлогод байгаль цаг уурын үзэгдлийн нөлөөлөл ямар байгааг судлахын тулд малчин өрхийн хөрөнгийг мал, гэр орон, хашаа хороо, техник тоног хэрэгсэл, бусад гэсэн үзүүлэлтээр авч үзэв. Үндэсний статистикийн газраас 2002 онд хийсэн Өрхийн орлого зарлагын судалгааны урьдчилсан дүнгээр нийт

малчин өрхийн орлогын 70 хувь нь мал, түүнээс гарах ашиг шимээс бүрдэж байгаа учраас орлогын эх үүсвэрийг малын тоогоор нь үнэлэх нь зөв гэж тогтсон.

Хүснэгт 4.11. Сүүлийн 5 жилд амьдрал сайжирсан эсэх

Сүүлийн 5 жилийн амьжиргаа	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Сайжирсан, %	7,9	4,8	0,7	3,5	5,7	14
Хэвэндээ, %	35,4	37,3	40,3	14	25,7	64,5
Дордсон, %	54,3	56,6	59	78,1	65,7	21,5

Судалгаанд хамрагдагсдын малын талаар судалж үзэхэд, 58.5 хувь нь малгүй буюу 100 хүртэл толгой малтай, 20.6 хувь нь 101-250, 10.3 нь 251-400, 6.2 хувь нь 400 аас олон толгой малтай байна. Энэ нэг талаас судалгаанд ядуу, дунд, чинээлэг малчдын төлөөлөл орсныг илтгэхийн зэрэгцээ ядуу малчид зонхилох болсныг харуулж байна. Завханд малгүй айл олон байна. Завхан аймгийн судалгаанд хамрагдсан 3 сумын малчин өрхийн 67% нь 100-аас цөөн малтай байхад Дундговь аймагт 35% байна.

Сарын орлогын байдлаар малчин өрхийн 33.3 хувь нь өдөрт 1000 төгрөгөөс бага орлоготой байна. Ер нь малчид малын тоо, өрхийн орлогын талаар мэдээлэл өгөхдөө дуртай биш тул эдгээрийг ерөнхий баримжаа авахад л хэрэглэж болно. Малын тоог мал тооллогын А данснаас түүвэрлэн авсан болно.

Хүснэгт 4.12. Судалгаанд хамрагдагсдыг малын тоогоор ангилсан нь

	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Малгүй, %	5,2		1,5	8,8		5
50 хүртэл малтай, %	35,7	51,8	13,4	47,4	24,3	30,8
51-100 малтай, %	17,5	19,3	20,9	10,5	24,3	20,6
101-150 малтай, %	9,3	8,4	16,4	9,6	7,1	10,3
151-250 малтай, %	11,3	9,6	14,2	6,1	25,7	7,5
251-300 малтай, %	5,5	3,6	14,2	5,3	7,1	4,7
301-400 малтай, %	4,8	3,6	7,5		8,6	7,5
401 –ээс дээш малтай	6,2			10,4	5,2	2,9

Хүснэгт 4.13. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын орлого

Өрхийн сарын орлого	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
15000 хүртэл төгрөг, %	17,2		4	18,8	17,1	15,9
15001-25000 төг, %	9,6		13,4	12,3	7,1	8,4
25001-30000 төг, %	6,5	11,1	10,4	6,1	7,1	6,5
30001-40000 төг, %	8,2	7,4	9	5,3	15,7	6,5
40001-50000 төг, %	9,3	25,9	8,2	7,9	11,4	9,3
50001-60000 төг, %	5,2		3,7	3,5	4,3	7,5
60001-ээс дээш, %	10,7	7,4	27,7	11,4	5,7	13,1

Малчин өрхийн 37 хувь нь жилд 500000 төгрөгөөс бага, 7 хувь нь 1 сая төгрөгөөс их орлоготой байна. Өрхийн жил, сарын орлогын хэмжээгээр аймгууд хоорондоо нэг их ялгарахгүй байна. Их орлоготой өрх нь Дундговьт олон байхад бага орлоготой нь Хэнтий, Булган, Төв аймагт байна.

Хүснэгт 4.14. Судалгаанд хамрагдсан өрхийн жилийн орлого

Өрхийн жилийн орлого	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
200000 хүртэл төгрөг	13,7	16,9	6	8,8	15,7	17,8
200001-300000 төг, %	11,0	13,2	13,4	9,6	12,9	11,2
300001-400000 төг, %	6,5		6	7,9	4,3	6,5
400001-500000 төг, %	5,8	4,8	6,7	3,5	15,7	1,9
500001-700000 төг, %	11,3	14,5	11,2	14	10	9,3
700001-900000 төг, %	4,8	4,8	10,4	4,4	2,9	6,5
900001-1100000 төг, %	5,5	4,8	6	5,3	7,1	4,7
1100001-дээш, %	7,2	3,6	17,9	8,8		10,3

Сард хүсэнд зарцуулж байгаа мөнгөн дүнгээс үзвэл малчдын хэрэглээ маш даруухан юм. Малчдын зонхилох хэсэг буюу 57.8 хувь нь сард 50 000 хүртлэх төгрөгийг хоол хүсэндээ зарцуулдаг ажээ. Хүнсний бүтцийг судлахад мах, сүү, гурил, будаа, давс, элсэн чихэр, ургамлын тос зонхилдог ба ногоо харьцангуй бага, загас, тахианы мах, жимс, жигнэмэг зэргийг бараг хэрэглэдэггүй байна. Зуны цагт хотоос хүүхэд, хөгшид, амрагсад ирдэг, гурил, будааны хэрэглээ нэмэгддэг аж. Малчид хэдэн малынхаа буянаар өөрсдөө “үнэгүй” мах, сүү хэрэглээд, ирсэн зочин гийчнээ “үнэгүй” хооллоод зогсохгүй сум, аймгийн төв, нийслэлд байдаг үр хүүхэд, ах дүү, хамаатан саднаа “үнэгүй” мах, сүүгээр хангаж байна.

Хүснэгт 4.15. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын хүнсний зардал

Сарын хүнсний зардал	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
20000 хүртэл төгрөг, %	21,6	12	24,6	19,3	32,8	16,8
20001-30000 төг, %	17,5	19,3	17,9	22,8	20	10,3
30001-40000 төг, %	11,0	15,7	11,9	13,2	10	9,3
40001-50000 төг, %	6,2	8,4	6	5,3	4,3	8,4
50001-60000 төг, %	3,1	2,4	4,5	4,4		3,7
60001-ээс дээш, %	4,5	2,4	9	2,6		9,3

Байгаль, цаг уурын үзэгдэл малчин өрхийн амьжиргаа, хөрөнгө, орлогод нөлөөлсөн нь

Байгаль цаг уурын аюул нь малчдын хөрөнгө, орлогот нөлөөлж байна. Малчдын амьжиргааны түвшин доогуур ядуурч байгаа шалтгааныг сум багийн удирдлагын зүгээс хэрхэн үзэж байдгийг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан дарга нарын 97 хувь нь байгаль, цаг уурын өөрчлөлт, эрсдэл, ган зудад малаа их хэмжээгээр хорогдуулж, орлогын эх үүсвэргүй болсноос гэж хариулсан.

Малчдын хөрөнгийн тоонд мал, гэр, малын хашаа хороо, машин тэрэг, бусад хэрэгслийг оруулсан бол орлогын үзүүлэлтийг авахдаа 2002 онд Статистикийн

газраас явуулсан өрхийн орлого, зарлагын судалгааны үр дүшнэг ашигласан. Тухайлбал, тэрхүү судалгаагаар хөдөөгийн хүн амын орлогын 91 хувийг бүрдүүлдэг дараах 5 үзүүлэлтийг авч үзсэн: Малын ашиг шим, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, МАА-н бус ажил үйлчилгээ, худалдаа (МАА-аас бусад).

Судалгаанд хамрагдсан өрхийн 92.4% нь сүүлийн 5 жилийн ган зуд, байгалийн бэрхшээлд хохирол амсчээ. Үүнд 16.8% нь бүх малаа, 36.5% нь малынхаа талаас илүүг хорогдуулжээ. Завхан аймагт хамгийн олон өрх бүх малынхаа олонхийг буюу бүх малаа хорогдуулсан бол Хэнтий, Булганд хамгийн гайгүй байна.

Хүснэгт 4.16. Сүүлийн 5 жилд үзсэн хохирол

	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Цөөн малаар хохирсон, %	40,2	42,2	14,9	16,7	34,3	69,2
Малынхаа талыг алдсан, %	10,0	20,8	35,8	10,5	14,3	6,5
Малынхаа олонхийг алдсан өрх, %	26,5	24,1	43,3	35,1	34,3	12,1
Огт малгүй болсон өрх, %	16,8	2,4	3	35,1	8,6	3

Ер нь Хэнтий, Булганд хадлан их авч өвөл, хаврын эрсдлийг хохирол багатай даван туулдаг байна. Дундговьд хадлан авдаггүй, гар тэжээл бэлтгэдэг, Завхан, Төв аймагт олон жил дараалан болсон гангийн уршгаар хадлангийн ургац буурч, өвлийн бэлтгэл хангах боломж муутай байсан байна. Ялангуяа мал нь цөөрч орлого багатай болсон айл өрхийн хувьд алс явж хадлан хадах, эсвэл өвс худалдан авах боломжгүй байсан нь жил дараалсан ган зудад хохирол улам их гарахад хүргэжээ.

Санал асуулганд хамрагдагсдын 35% нь хохирлоо мөнгөн дүнгээр үнэлсэн байна. Хохирлын хэмжээг 100 мянгаас 4 сая төгрөг гэж гаргасан байна.

Малчин өрхийн хөрөнгөд үзүүлэх байгалийн үзэгдлийн нөлөөллийн байдлыг тоон аргаар үнэлэхэд матрицын арга хэрэглэсэн. Энд хүчтэй нөлөөллийг 3, дунд зэргийг 2, сул нөлөөллийг 1, огт нөлөөлөлгүй бол 0 оноо өгөөд дүнг гаргавал хамгийн их нөлөөлөлд өртөж буй нь мал, малчдын хөрөнгөд хамгийн хүчтэй нөлөөлж буй үзэгдэл нь түймэр, үер гэсэн дүн гарч байна (Хүснэгт 4.17).

Үнэлгээнээс үзэхэд бүх төрлийн зуд, ган, цөлжилт, байгалийн гэнэтийн гамшигт үзэгдэл малчин өрхийн үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох мал аж ахуйд бүхий л талаараа хамгийн хүчтэй, мөн хор хохирол ихтэйгээр нөлөө үзүүлж байна. Малчин өрхийн үйлдвэрлэлийн бусад хэрэгсэл болох гэр орон, хашаа хороо, тоног хэрэгсэл, бусад зүйлд шууд болон дам нөлөөгөөр хохирол учруулж байна. Байгалийн эдгээр үзэгдэл мал сүрэгт хүчтэй нөлөө үзүүлдэг учир малчин өрхийн амьжиргааны эх үндэс болсон мал аж ахуй байнгын эрсдэлтэй нөхцөлд оршиж байна.

Малчид хохирлын улмаас давхардсан байдлаар 66 хувь нь сэтгэл санааны дарамттай, 26 хувь нь эрүүл мэнд муудаж, 18 хувь нь өр зээлтэй, 17 хувь нь хүүхдээ сургууль завсардуулан, 1.3 хувь нь аль нэг эрхтэнээ гэмтээсэн, тахир дутуу болсон, 10 хувь нь хааяа өлсөх болсоноо илчилсэн нь амьжиргааных нь гол эх сурвалж болсон малын тоо толгой байгаль цаг уурын өөрчлөлт, эрсдэлээс цөөрч, улмаар малчин өрхийн амьжиргаанд хүндрэл бэрхшээл үүсч байгаа нь тодорхой байна.

Малчид эрүүл мэндээр хохирч, сэтгэл санааны дарамттай байгаа боловч орон нутгийн эмнэлгийн байгууллагын зүгээс үзүүлж буй үйлчилгээнд сэтгэл ханамж муугүй байгаа нь нийт судалгаанд оролцогчдын 88.9 хувь нь эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж байна гэж хариулсанаас харагдаж байна. Харин эмнэлгийн үйлчилгээнд

хамрагдаж чадахгүй байгаа хүмүүсийн 65.2 хувь нь эм тариа авах мөнгө муутай, эмчилгээний үнэ их байдаг гэж хариулсан нь мөн л амьдралын түвшин доогуур байгаатай холбоотой юм.

Сургуулийн насны хүүхдээ сургуульд бүрэн хамруулах нь амьдрал ахуйгаа зах зээлийн нийгэмд зохицуулан ажиллах чадвар бүхий ирээдүйн иргэдийг бэлтгэхэд чухал нөлөөтэй юм. Сургуулийн насны хүүхдийн сургуульд хамрагдалт 1990-ээд оноос буурсан статистик үзүүлэлт байдаг, бидний судалгаагаар ч сургууль завсардалт 18.2 хувьтай байгаа нь тийм ч бага тоо биш юм. Шалтгаан нь голчлон мал маллах хүн хүч дутагдсан, өөрөө сонирхолгүй байсан гэсэн хариултыг илүүтэй өгчээ.

**Хүснэгт 4.17. Малчин өрхийн
хөрөнгөд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний матриц**

No	Хөрөнгө	Мал	Гэр орон	Хашаа хороо	Тоног хэрэгсэл	Бусад, (бэлчээр)	Онооны нийлбэр
	Аюулт үзэгдэл						
1	Зуд	3	3	1	2	1	11
	а/ Цагаан зуд	3	2	1	2	1	10
	б/ Хуяган зуд	3	2	1	3	1	11
	в/ Харын зуд	3	1	1	1	1	7
	г/ Туурайн зуд	3	1	1	3	1	9
	д/ Өлдөхийн зуд	3	1	1	1	3	9
2	Ган	3	1	0	1	1	7
3	Цөлжилт	3	1	0	1	1	7
4	Шируун аадар	3	1	2	1	0	8
5	Аянга	3	3	2	3	0	12
6	Үргэлжилсэн халуун	3	1	1	1	3	9
7	Мөндөр	3	1	2	2	0	9
8	Үер	3	3	3	3	3	15
9	Түймэр	3	3	3	3	3	15
10	Цасан шуурга	3	3	2	1	1	11
11	Үргэлжилсэн хүйтэн	3	1	0	1	1	7
12	Шороон шуурга	3	3	2	3	0	12
13	Газар хөдлөлт	3	1	3	0	0	7
	Онооны нийлбэр	54	32	26	33	21	

Эрдэнэдалай сум

Сумын төвшний дэлгэрэнгүй судалгааны жишээ болгон Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын мэдээллийг энд оруулав. Эрдэнэдалай сум 1700 гаруй өрх айлтай, 7000 гаруй хүн амтай. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2% олон. Хүүхэд 36%, тэтгэвэрийн насны хүн ам 9%, тахир дутуу хүн 4% байна. 1998 онтой харьцуулахад хүн ам 200 гаруй хүнээр цөөрчээ (Хүснэгт 4.18).

1700 гаруй өрхтэй. Үүний 10 хувь нь эмэгтэй тэргүүнтэй байна. 1999 оны зудаас хойш нэн ядуу, малгүй болсон өрхийн тоо олноор нэмэгджээ. 1998 онд малгүй 3, нэн ядуу 7 өрх байсан бол 2001 онд малгүй болсон 139 өрх, нэн ядуу 173 өрхтэй болсон байна (Хүснэгт 4.19).

2002 оны жилийн эцсээр сумын айл өрхийн 87% нь малтай, 73% малчин өрх, хүн амын 88% нь мал бүхий, 74% нь малчин өрхөд амьдардаг гэж тоологджээ.

Зуд болсон 2000 онд нэн ядуу өрх 100 бүртгэгдсэн бол дараагийн 2001 онд энэ нь 173 болж нэмэгджээ. 2002 онд нэн ядуу өрхийн тоо буурсан байхад малгүй болсон өрхийн тоо нэмэгдсээр байна.

1998 оноос хойш айл өрхийн 2-5 % нь шилжин нүүж байна. 5 жилд нийт өрхийн 19% буюу 328 айл шилжин явсан ч энэ хэмжээгээр өрхийн тоо буураагүй.

Хүснэгт 4.18. Эрдэнэдалай сумын хүн ам, 1998-2002 он

Он	Хүн амын тоо						Эзлэх хувь %				
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүүхэд	Өндөр насны	Тахир дутуу	Эрэгтэй	Эмэгтэй	Хүүхэд	Өндөр насны	Тахир дутуу
1998	7218	3528	3690	2773	684	230	49%	51%	38%	9%	3%
1999	7340	3650	3690	2317	672	284	50%	50%	32%	9%	4%
2000	7362	3564	3798	2688	674	344	48%	52%	37%	9%	5%
2001	7185	3541	3644	2509	672	358	49%	51%	35%	9%	5%
2002	7007	3468	3539	2566	669	213	49%	51%	37%	10%	3%
Дундаж	7222	3550	3672	2571	674	286	49%	51%	36%	9%	4%

Хүснэгт 4.19. Эрдэнэдалай сумын малчин өрх, 1998-2002 он

Он	Өрхийн тоо					Өрхөд эзлэх хувь %			
	Нийт өрх	Эмэгтэй тэргүүнтэй	Нэн ядуу	Малгүй болсон	Шилжиж явсан	Эмэгтэй тэргүүнтэй	Нэн ядуу	Малгүй болсон	Шилжсэн
1998	1724	150	7	3	41	9%	0,4%	0,2%	2%
1999	1673	162	16	89	48	10%	1,0%	5,3%	3%
2000	1759	184	100	126	77	10%	5,7%	7,2%	4%
2001	1767	169	173	139	81	10%	9,8%	7,9%	5%
2002	1723	196	142	172	81	11%	8,2%	10,0%	5%
Дундаж	1729	172	88	106		10%	5%	6%	4%

Хүснэгт 1, 2-ын эх сурвалж: Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар, 2003

Зуд малчдын орлогод сөргөөр нөлөөлсөн. Хүснэгт 4.20-д зудын өмнөх 1999, дараахи 2002 оныг харьцуулсан жишээ байна. 1999 онд малчин өрхийн 35% нь сард 30 мянган төгрөгөөс бага орлоготой байсан бол 2002 онд 81% нь 30 мянган төгрөгөөс бага орлоготой болжээ. 1999 онд малчин өрхийн 18% нь сард 60 мянган төгрөгөөс дээш орлоготой байсан бол 2002 онд ийм орлоготой өрхийн эзлэх хувь 4% болж буурчээ. Ийм харьцуулалтыг Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын жишээн дээр хийж Хүснэгт 4.21, 4.22-г үзүүлэв.

Хүснэгт 4.20 Малчин өрхийн эзлэх хувь, Эрдэнэдалай сум

Он	Өрхийн сарын орлого, мянган төгрөг							
	<10	10 - 20	20 - 30	30 - 40	40 - 50	50 - 60	60 - 70	70 <
1999	0%	11%	15%	26%	17%	13%	7%	11%
2002	24%	35%	22%	11%	3%	2%	2%	2%

Хүснэгт 4.21 Малчин өрхийн эзлэх хувь, Өлзийт сум

Он	Өрхийн сарын орлого, мянган төгрөг							
	<10	10 - 20	20 - 30	30 - 40	40 - 50	50 - 60	60 - 70	70 <

1999	0%	3%	15%	6%	12%	18%	18%	29%
2002	6%	21%	29%	26%	9%	6%	0%	3%

Хүснэгт 4.22 Малчин өрхийн эзлэх хувь, Гурвансайхан сум

Он	Өрхийн сарын орлого, мянган төгрөг							
	<10	10 - 20	20 - 30	30 - 40	40 - 50	50 - 60	60 - 70	70 <
1999	0%	3%	13%	10%	17%	7%	7%	43%
2002	13%	26%	23%	19%	6%	3%	0%	10%

Байгаль цаг уурын өөрчлөгдөл

Судалгаанд хамрагдсан малчдын 97.6 хувь нь нутаг орныхоо байгаль, цаг уур өөрчлөгдөж байгааг тэмдэглээд байгаль цаг уурын дараах өөрчлөлтүүдийг тодруулан нэрлэсэн байна. Булган, Хэнтийд нэг талаас цасны хэмжээ нэмэгдэж, нөгөө талаар ундны ус ховордож байгааг, Булган, Завханд ган гачиг дараалан тохиолдож байгааг, Төв, Завхан, Булганд зуд байнга нүүрлэх болсон гэж олонхи малчид үзэж байна. Булган, Завхан, Хэнтийд гол гохи ширгэж, хадлангийн ургац буурч, Булган, Дундговь, Хэнтийд ургамлын шим муудаж, Дундговь, Завхан, Төв аймагт элсний нүүдэл, цөлжилт эрчимшиж байгааг малчид нэрлэсэн байна.

Хүснэгт 4.17. Байгаль, цаг уурын өөрчлөгдөл

Цаг уур	Нийт	Булган	Дундговь	Завхан	Төв	Хэнтий
Цас их унах болсон, %	69,8	97,6	64,9	75,4	45,7	79,4
Зуд байнга нүүрлэх болсон, %	67,4	94	59,7	84,2	77,1	43
Ган гачиг дараалан болсон, %	59,1	91,6	68,7	86,8	61,4	28
Ундны ус хомсдсон, %	27,1	48,2	24,6	21	17,1	40,2
Бэлчээр						
Хадлан авах ургац багассан, %	67,7	87,9	27,6	73,7	50	73
Гол горхи, булаг ширгэсэн, %	55,7	87,9	9	52,6	24,3	79,4
Ургамлын шим муудсан, %	51,9	79,5	74,6	50,9	30	67,3
Бэлчээр багассан, %	40,5	75,9	37,3	37,7	40	43,9
Бэлчээр талхилагдсан, %	39,5	33,7	48,5	25,4	47,1	49,5
Элсний нүүдэл, %	17,2		13,4	35,1	14,3	
Цөлжилт ихэссэн	10,7	16,9	30,6		44,3	

Судалгаанд хамрагдагсад бороо татарч, их халуун ган болох, өвөл хаврын улиралд цас их хэмжээгээр унаж хүйтрэн зуд болох хандлага сүүлийн 10 шахам жил байнга давтагдсанаас булаг шанд, худаг хатаж ширгэх болсон, усан хангамж дутагдан бэлчээрийн ургамалын бүрхэвч өөрчлөгдөж шарилж хамхуул зэрэг ганд тэсвэртэй ургамал, мөн үл танигдах өргөст ургамалууд зонхилон ургах болсон зэрэг нь мал дуртай идээшилдэг хиаг, ерхөг, хялгана, царгас болон бусад шимт ургамалын хэмжээ

буурч, зарим газарт бүрэн арилснаас мал сүргийн тарга хүч, ноос, ноолуур, хөөвөр бүрдэх явц буурахаас гадна сүү сааль татран малын ашиг шим буурах хандлагатай байгааг ярьж байлаа.

Байгаль, цаг уурын хэдэн оны ямар тохиолдол хамгийн хүнд, хохирол ихтэй байсан бэ гэсэн асуултанд, судалгаанд хамрагдагчид дараах улирлыг онцлов:

- 40.3% - 2000 оны өвөл, хавар,
- 28.5% - 2001 оны өвөл, хавар,
- 23. % - 1999 оны өвөл, хавар,
- 21. % - 2002 оны өвөл, хавар,
- 15. % - 2003 оны өвөл, хавар

Ер нь 1999 оноос хойших өвөл, хаврын улирлуудад дараалан зуд болж, цас их хэмжээгээр унан, зундаа ган болж, малчдын амьдралд байгаль, цаг уурын хүндрэл, эрс үзэгдлүүд нэмэгдсэнийг судалгааны дүн харуулж байна. Судалгааны бүрэн материалыг www.agronet.mn вэбэд тавихаар бэлтгэж байна.

Жилийн аль улиралд нь байгаль, цаг уурын аюул их тулгардаг, аль улиралд нь мал их хорогддогийг судлахад судалгаанд хариулагчдын 79.5 хувь нь хавар, 72.6 хувь нь өвөл байгаль, цаг уурын аюул их тулгардаг гээд тэдний 89.8 хувь нь хавар, 62.4 хувь нь өвлийн улиралд мал их хорогддогийг дурджээ.

Чухам ямар мал аль улиралд илүү ихээр хорогддогийг цааш тодруулахад, бүх төрлийн мал хаврын улиралд илүү хорогддогийг малчид тэмдэглэсэн байна.

Малчдад хүрч буй байгаль цаг уурын мэдээлэл

Байгаль цаг уурын гэнэтийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд мэдээллийн ач холбогдол чухал гэдэг нь тодорхой юм. Байгаль цаг уурын гэнэтийн аюулын талаар хичнээн хугацааны урдаас, ямар сувгаар мэдээлэл авдгийг судлаж үзэхэд 31.4 хувь нь энэ талын мэдээллийг 1 өдрийн өмнөөс, 22.9 хувь нь олон өдрийн өмнөөс, 12.9 хувь нь 2 өдрийн, 11.4 хувь нь 3 өдрийн өмнөөс тус тус авч чадаж байгаагийн зэрэгцээ 7.1 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулсан нь харамсалтай байгаа юм. Тэдний мэдээлэл авч буй гол суваг нь радио /92.9%/ болж байгаа бөгөөд баг сумын удирдлага /31.4%/, телевизэр /10.0%/, нутгийн хүн /7.1%/, сонин хэвлэл /5.7%/ ч мэдээллийн чухал сувгууд болох нь харагдаж байна.

Байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүлээж аваад тэдний 60.0 хувь нь мал сүргийнхээ хариулгад анхаарч, 48.6 хувь нь өвс тэжээлээ бэлтгэн, 45.7 хувь нь хашаа хороогоо дулаалж, 25.7 хувь нь түлээ түлшээ бэлтгэн, 14.3 хувь нь хоол ундаа базаадаг гэсэн хамгийн өндөр давтамж бүхий хариулт өгсөн нь амьдралынхаа эх сурвалж болсон мал сүрэгтээ гол анхаарлаа хандуулж байдаг нь тодорхой байна.

Өрхийн аж ахуйдаа ногоо тарьдаг эсэхийг тодруулахад, 5.7 хувь нь ногоо тарьж амьдрал ахуйдаа хэрэглэдэг, 52.9 хувь нь тарьдаггүй гээд 41.4 хувь нь ямар нэгэн хариулт өгсөнгүй.

Зах зээлээс алслагдсан байдал

Малчин өрхийн амжиргаанд нөлөөлж байгаа нөгөө нэг хүчин зүйл бол Монголын өнөөгийн нийгэмд хэрэгжиж байгаа зах зээлийн харилцаа юм. Монгол орны өргөн уудам орон зайд тархмал байдлаар байршиж буй малчин өрхийн аж ахуйд төвлөрсөн зах зээлийн байдал хүчтэй нөлөөлдөг. Энэ нь дэд бүтцийн хөгжилтэй холбоотой боловч чухамдаа Монгол орны амжиргааны зардал өсөж улмаар бүс нутгууд дахь малчин өрхүүдийн амжиргааны түвшиний жигд илүү холбоотой. Төвлөрсөн зах

зээлээс алслагдах тусам малчдын амжиргааны зардал өсөж улмаар бүс нутгууд дахь малчин өрхүүдийн амьжиргааны түвшний жигд дадал алдагдаж, баян хоосны ялгаа их болох хандлага түгээмэл байна. Иймээс ч зах хязгаар нутгаас төвийн зах зээл нилээд давуутай район руу нүүдэллэж, шилжих хөдөлгөөн их болсон нь малчиддаа ч бэлчээр нутаг эзэмших байдалдаа ч сөрөг нөлөө үүсч нийт Монгол орныхоо түвшинд байршлын хэм алдагдаж, улмаар эдийн засагт хохирол учруулах талтай байна. Учир нь дэлхийн аливаа улс орон өөртөө хамгийн тохиромжтой аж ахуйн салбараар газар нутгаа эдэлбэрлэдэг. Монгол орны хувьд бэлчээр нүүдлийн мал аж ахуйг улс орны газар нутгийн 90 гаруй хувийг эдэлбэрлэдэг. Иймд өнөөгийн зах зээлээс 500, 1000, 155 км алслагдсан малчин өрхөд байвал зохих малын тооны судалгааг²⁰ хийж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 4.23. Төвлөрсөн зах зээлээс 500, 1000, 1500 км алслагдсан малчин өрхийн амьжиргааны төвшинг хангаж болохуйц малын тоо

Малчин өрхийн ам бүлийн тоо	500 км алсын малчин өрхөд байх мал						1000 км алсын малчин өрхөд байх мал						1500 км алсын малчин өрхөд байх мал					
	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
1 амаас бүрдсэн өрх	5	8	9	79	28	129	5	8	10	82	36	141	5	8	11	85	44	153
2 амаас бүрдсэн өрх	7	12	13	93	44	169	7	12	14	96	52	181	7	12	15	99	60	193
3 амаас бүрдсэн өрх	9	18	18	188	56	289	9	18	19	191	64	301	9	18	20	194	72	313
4 амаас бүрдсэн өрх	9	24	21	193	72	319	9	24	22	196	80	331	9	24	23	199	88	343
5 амаас бүрдсэн өрх	9	30	28	233	88	388	9	30	29	236	96	400	9	30	30	239	104	412
6 амаас бүрдсэн өрх	9	36	36	273	118	472	9	36	37	276	126	484	9	36	38	279	134	496
7 амаас бүрдсэн өрх	9	42	42	289	118	500	9	42	43	292	126	512	9	42	44	295	134	524
8 амаас бүрдсэн өрх	9	48	49	299	148	553	9	48	50	302	156	565	9	48	51	305	164	577
9 амаас бүрдсэн өрх	9	55	59	309	161	593	9	55	60	312	171	607	9	55	61	315	179	619
10 амаас бүрдсэн өрх	9	58	66	313	198	644	9	58	67	316	206	656	9	58	68	319	214	668

Энэ нь бүс нутаг газар зүйн байдлуудад зохих ялгаатай байхыг анхаарах ёстой.

Малчдад хүрч буй тусламж

Байгалийн гамшгийг даван туулахад малчдад бие сэтгэлийн хувьд тусламж дэмжлэг чухал нөлөөтэй. Энэ талаар малчдын 32.9 хувь нь улаан загалмай, 24.3 хувь нь орон нутгийн удирдах байгууллага, 15.7 хувь нь төр засаг, 11.4 хувь нь төрийн бус болон гадаадын байгууллага тусалж байдгийг дурдсаны зэрэгцээ 32.9 хувь нь тусламж дэмжлэг ирдэнгүй гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдагчдаас **ямар нэгэн төсөлд** хамрагдсан эсэхийг судлахад, тэдний **92.9 хувь нь хамрагдагүй**, харин 2 хүн хамрагджээ. Үүнээс үзэхэд тухайн судалгаанд хамрагдсан сумдын хэмжээнд малчдын дунд ямар нэгэн төсөл бараг хэрэгжээгүй нь харагдлаа.

²⁰ Судалгааны багийн гишүүн Цэвээний тооцоолсноор

Бид сум багийн удирдлага ган зудад малаа хорогдуулж, орлогын эх үүсвэргүй болсон эсвэл угаасаа мал цөөтэй, амьжиргааны түвшин доогуур малчин өрхийг ядуу өрх гэсэн шалгуурт сонгон оруулдаг байна.

Харин сум багийн удирдлага малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар ямар бодол, саналтай явдгийг судлахад тэдний дийлэнх нь малчдын хоршоог орон нутагт зохион байгуулах, нутгийн малын үүлдэр угсаа, чанарыг байгаль, цаг уурын өөрчлөлтийг даван туулах чадвартайгаар хөгжүүлэх нь ихээхэн ач холбогдол үзүүлнэ гэж санал гаргасан байна.

5.0 Бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтийн талаархи судалгааны үр дүнгээс

Малчдын амьжиргааг дээшлүүлэх бодлого нь нийгэм, эдийн засгийн хөгжил (ялангуяа хөдөөгийн болон мал аж ахуйн), ядуурлыг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ба уур амьсгалын өөрчлөгдөлд зохицох гэсэн олон бодлогын зааг дээр байна. Судалгаанд энэ чиглэлийн баримт бичиг хамрагдсан ба заримыг нь энд тоймлон өгүүлэв.

Төв аймгийн жишээн дээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, малын чанарыг сайжруулах, өрхийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр авч буй арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн талаархи судалгааны үр дүнг оруулав.

5.1. Хөгжлийн бодлого, стратеги

Эдийн засгийн хөгжил

Монголы Улсын Засгийн газар 2001 онд эдийн засгийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, үндэсний үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, хүний хөгжлийн тогтвортой байдлыг хангах, бүс нутгийн хөгжүүлэхэд анхаарч ажилласан²¹. Үүний үр дүнд макро эдийн засгийн үзүүлэлтүүд тогтворжиж, төсвийн дутагдал буурч, хувийн хэвшлийн оролцоо, үйлдвэрлэл нэмэгдсэн. 2002 онд эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, нийгмийн үйлчилгээг өргөжүүлэх, эдийн засаг, санхүүгийн нөхцлийг сайжруулах замаар хөдөөгийн хөгжлийг гүнзгийрүүлэх, экспортыг нэмэгдүүлэх үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилтуудыг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Засгийн газар дунд хугацааны зорилтоо амжилттай биелүүлж байна (Хүснэгт 5.1, 5.2).

Хүснэгт 5.1. 2002-2005 оны зорилт

	2002	2003	2004	2005
ДНБ өсөлт, %	4.0	5.0	6.0	6.5
Инфляци, %	6.0	5.0	5.0	5.0
Төсвийн алдагдал, ДНБ-д харьцуулсан %	-7.1	-6.6	-6.0	-5.5
Хүн ам, мянган хүн	2 443.8	2 479.9	2 515.2	2 549.3
Ажилгүйдэл, %	4.7	4.7	4.6	4.6

Эх үүсвэр: Санхүү, эдийн засгийн яам

Засгийн газрын зорилтын биелэлтийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5.2. 2002, 2003 оны зорилтын биелэлт

	2002	2003*
ДНБ өсөлт, %	4.0	5.3
Инфляци, %	1.6	5.0
Төсвийн алдагдал, ДНБ-д харьцуулсан %	-5.9	-5.6
Хүн ам, мянган хүн	2459.4	

²¹ Economic Development Report for 2001, Ministry of Finance and Economy of Mongolia, 2002

Ажилгүйдэл, %	3.4	
---------------	-----	--

* - Хүлээгдэж буй гүйцэтгэл

Засгийн газрын мөрийн хөтөлбөр

Засгийн газрын 2000-2004 онд дараах зорилтууд хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан:

- Эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлэн гүнзгийрүүлж, өндөр өсөлтийг хангах
- Экспортийн баримжаатай эдийн засгийн бодлого явуулж, тогтвортой өндөр өсөлтийг хангах
- Боловсрол, соёлыг дээдлэн хөгжлийн гол тулгуур-хүнээ хөгжүүлэх
- Нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг боловсронгуй болгон нийгмийн хамгааллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар амьдралын төвшний зөрүүг багасгах
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг Монгол орны өвөрмөц онцлогт тохируулан боловсруулж үр дүнтэй хэрэгжүүлэх, өндөр чадавхитай, хариуцлагатай сайн засаглал тогтооход оршино.

Нийгмийн бодлого

Нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг оновчтой болгож, ард иргэдийн амьжиргааны төвшний уналтыг зогсоон, нийгмийн доторхи орлогын ялгааг багасгаж, туйлын ядуурлыг арилгах зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

1. Өрхийн амьжиргаа доройтохоос урьдчилан сэргийлэх нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ядуу иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх үндсэн дээр амьжиргааны доод төвшнөөс бага орлоготой өрхийн тоог 1999 оныхоос хоёр дахин бууруулна.
Судалгаа хийсэн аймаг, сумдад малчдын амьжиргаа дордож ядуу, бага орлоготой өрхийн тоо нэмэгдсэн. Иймд энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд оновчтой, далайцтай арга хэмжээ авах шаардлагатай.
2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг энэ оноос эхлэн ээлж дараатай нэмэгдүүлэн 2000 оны эхэн үеийнхээс гурав дахин өсгөнө.
Энэ заалт малчдад хүртээлгүй бололтой. Малчдын хөдөлмөрийн хөлс тооцогддоггүй, орлогын хэмжээ 1999 оныхоос буурсан.
3. Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцоог боловсронгуй болгож, чадавхийг нь дэвшүүлнэ. Нийгмийн даатгалын харилцааг боловсронгуй болгож, үр хүүхэд, гэр бүл, төрөл саднаа даатгалд хамруулах замаар эрсдэлээс хамгаалах бололцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг ирэх жилээс эхлэн нэмэгдүүлж хоёр дахин өсгөнө. Тэтгэвэрийн даатгалын нэрийн дансыг бүрэн нэвтрүүлнэ. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэл, хураамжийг хугацаанд бүрэн төлөх хариуцлагыг дээшлүүлэн нийгмийн даатгалын сангуудын өөрийгөө санхүүжүүлэх чадварыг дээшлүүлнэ. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулж тэдний нийгмийн хамгааллыг сайжруулна.
Малчид байгаль, цаг уурын эрсдэлтэй нөхцөлд хөдөлмөр эрхэлдэг боловч нийгмийн хамгааллын тогтолцооны гадна байна гэж үзэж болохоор байна. Нэгдлийн гишүүн байсны хувьд тэтгэвэр авч буй хэдэн хөгшчүүдээс бусад

малчид нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй тул нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах нөхцлийг хангахааргүй байна.

4. Хөдөлмөрийн тухай хуультай уялдуулан хөдөлмөрийн аюлгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудыг шинэчлэн мөрдүүлнэ.
Хөдөлмөрийн хуулинд малчдын хөдөлмөрийн талаар тусгагдаагүй.
5. Ядуу болон тахир дутуу иргэд, олон хүүхэдтэй эхчүүдэд үзүүлэх нийгмийн халамжийг нэмэгдүүлнэ. Иргэдийг ажил эрхлэх болоцоогоор хангах цогцолбор арга хэмжээ авах замаар шинээр ажлын байр бий болгох санаачлагыг дэмжин урамшуулна. Жижиг зээлийг санхүүжилтын аргыг өргөн нэвтрүүлнэ.
Сумдын ажил эрхлэлт 1999 онтой харьцуулахад мэдэгдэхүйц сайжраагүй. Ган зудаар малгүй болсон айл өрх нийслэл, аймаг, сумын төвд орж ирж ажилгүйдэл, ядуурлыг нэмэгдүүлсэн.
6. Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах, хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй арга хэмжээнд оролцох боломжийг бүрдүүлнэ.
Малчид ийм төрлийн даатгалд хамрагддаггүй.
7. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын чиглэл, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
Малчдад зориулсан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд байхгүй.
8. Орон нутагт жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, тариалан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тахиа, шувуу, зөгий зэрэг аж ахуй эрхлэхийг дэмжих зээлийн сан байгуулах.
Одоогоор малчдад хүрсэн, тэдний аж ахуй эрхлэлтийг дэмжих зээлийн сан байхгүй.
9. Хүн амын шилжих хөдөлгөөний талаар төрөөс баримтлах бодлогыг бүс нутгийн хөгжилтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.
Бодлого боловсрогдоогүй, шилжих хөдөлгөөн буурахгүй байна.

Эдийн засгийн бодлого

Макро эдийн засгийн тогтворжилтийг бататган экспортийн баримжаатай, хувийн хэвшилд тулгуурласан бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх үндсэн дээр эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг хангана. Уул уурхай, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах төвшинг ахиулах, экспортийн үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгнө.

Эдийн засгийн өсөлтийн хурдцыг нэмэгдүүлж 2004 он гэхэд жилийн 6-н хувьд хүргэнэ. Энэ зорилгоор дараах бодлогыг хэрэгжүүлнэ.

- o Макро эдийн засгийн тогтворжилтыг хангана;
- o Банк санхүүгийн салбарыг эрүүлжүүлнэ.
- o Өмч хувьчлалыг үргэлжлүүлж, үр ашгийг нь дээшлүүлнэ;
- o Үндэсний үйлдвэрлэлийг сэргээж, экспортийг дэмжинэ;
- o Дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлнэ.

Хүснэгт 5.2-т үзүүлснээр дээрх зорилтууд амжилттай биелэж байна. Харин хөдөө аж ахуйн үйлдвэрлэл буурсан.

Бүс нутаг, хөдөөгийн бодлого

Эдийн засгийг нутаг дэвсгэрээр бүсчлэн хөгжүүлж, бүс нутагт дэд бүтэц бүрдүүлэх, хөдөөд чиглэсэн татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогыг хэрэгжүүлэх замаар иргэд тухайн нутагтаа суурьшин амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавьсан. Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зүйл нь:

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтыг бий болгож бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийн харьцангуй жигд хөгжлийг хангах дэс дараатай арга хэмжээ авна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах баримт бичиг батлагдан гарчээ:

- УИХ-ын тогтоол, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай, дугаар 57, 2001-6-14
Хавсралт: Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
- УИХ-ын тогтоол, Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалын тухай, дугаар 87, 1995-12-4
- Монгол Улсын хууль, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай, 2002-6-28
- УИХ-ын тогтоол, Алтанбулаг худалдааны чөлөөт бүс байгуулах тухай, дугаар 38, 2002-6-28
- УИХ-ын тогтоол, Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай, дугаар 01, 2003-1-2
Баруун бүс: Ховд, Улиастай
Хангайн бүс: Хархорин, Эрдэнэт
Төвийн бүс: Зуунмод, Дархан
Зүүн бүс: Чойбалсан, Өндөрхаан
- Монгол Улсын хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай, 2003-5-30
- УИХ-ын тогтоол, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, 2003-5-30
- УИХ-ын тогтоол, Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай, дугаар .., Эцсийн найруулга, 2003-06-18
Хавсралт: Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)

- Бүс нутгуудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийг урамшуулах гааль, татварын ялгавартай бодлого хэрэгжүүлнэ.
- Бүс нутаг бүрт түүхий эд, бараа, хүнсний бүтээгдэхүүний бөөний худалдааны сүлжээ бий болгож, хөдөөгийн хөдөлмөрчид, малчдыг харьцангуй хямд үнэтэй, чанар сайтай хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангана.
- Малчин өрхийн болон фермерийн аж ахуйн эрх зүй, эдийн засгийн харилцааг хуулиар зохицуулж, хоршоо, фермерийн аж ахуйг байгуулах замаар малчид хамтын хүчээр аж ахуй, амьдралаа өөд татах үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- Мал сүргийг төрийн хамгаалалтад байлгах тогтолцоог зах зээлийн нөхцөлд нийцүүлэн төгөлдөржүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ, бэлчээр усжуулалт, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд төрийн бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
2002 оны 6-р сард батлагдсан Газрын тухай хуулиар өвөлжөө, хаваржааны доорх газрыг өрхөд эзэмшүүлэхээр, өвөлжөө,

хаваржааны бэлчээрийг малчдын бүлэгт гэрээгээр ашиглуулахаар заасан нь энэ төрлийн бэлчээрийг удаан хугацаагаар тогтвортой ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Харин зуслан, намаржаа, отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана гэж заасан.

- Мал сүргийг даатгалд хамруулна.
Зудад хорогдсон мал даатгалд хамрагдаагүй байсан. Даатгалын компаниуд цаг агаар хүндэрсэн үед мал даатгах сонирхолгүй байдаг..
- Мал сүргийг байгалийн гамшгаас хамгаалах тогтолцоо, гамшгийн тусламжийн сүлжээг бүрдүүлнэ. Бүс нутгуудад аймаг дундын отрын нөөц бэлчээрийг бий болгоно.
Гамшигаас хамгаалах шинэ хууль батлагдан хэрэгжиж, гамшигийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох дэс дараатай арга хэмжээ авч байна. Аймаг, сумдад отрын нөөц нутаг бий болгох арга хэмжээ хэрэгжиж, сумдын газар ашиглалтын хянан баталгааны зураг шинэчлэгдэн хийгдэж байна.
- 1999-2000 оны зудын хохирлыг ойрын 2-3 жилд багтаан арилгах арга хэмжээ авна. Зудаар хохирол үзэж орлого нь амьжиргааны баталгаажих төвшнөөс доош орсон малчин өрхийг малжуулах арга хэмжээг олон нийтийн хяналт, оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
Ган зуд дараалан тохиолдож жил бүр хохирол гарч байгаагаас энэ зорилт хэрэгжих боломжгүй болсон. Хязгаарлагдмал хүрээнд явагдсан малжуулах арга хэмжээ малгүй болсон айл өрхийг бүгдийг хамарч чадаагүй. Байгаль цаг уурын нөхцөл болон малжуулалтын аргачлалын улмаас зарим нутагт малжуулалтын үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрч чадаагүй.

5.2. Ядуурлыг бууруулах бодлого

Хүний хөгжил болон ядуурлын талаархи албан ёсны мэдээ 1995, 1998 оны байдлаар гарчээ (Хүснэгт 5.3, 5.4). Гэтэл ядуурлыг үлэмж нэмэгдүүлсэн байгаль цаг уурын гамшиг 1999-2002 онд болсон. Ядуурлын байдлын мониторингийн өнөөгийн тогтолцоо нь ядуурлыг бууруулах талаархи засгийн газрын бодлого шийдвэр, арга хэмжээ, хандивлагчдын тусламж дэмжлэгийн үр дүнг шуурхай гаргах, ядуурлын үзүүлэлтүүдийг тодорхойлж бодит үнэлгээ өгөх ажлыг шуурхай зохион байгуулж чадахгүй байна.

Хүснэгт 5.3 Монгол дахь Хүний Хөгжлийн Индекс

	Дундаж наслалт /жилээр/	Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт /хувь/	Сургалтанд хамрагдалтын нийлбэр хувь	Нэг хүнд ногдох бодит ДНБ /PPP/ бодит ДНБ /PPP/	Дундаж наслалтын индекс	Боловсролын индекс	ДНБ-ий индекс	Хүний Хөгжлийн индекс
1990	63.7	96.5	60.4	1,640	0.640	0.845	0.467	0.652
1992	62.8	96.5	54.3	1,266	0.630	0.824	0.424	0.626
1995	63.8	96.5	57.0	1,267	0.647	0.833	0.424	0.635
1998	65.1	96.5	62.0	1,356	0.669	0.850	0.435	0.651

Эх сурвалж: YCG /1999/ Жич: Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдсан үзүүлэлтийг 1989 оны хүн амын тооллогын мэдээнээс авсан.

Хүснэгт 5.4 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 1995 ба 1998 он

	Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуурхи амьдралтай хүн амын эзлэх хувь		Ядуу хүмүүсийн тоо /мянгаар/		Ядуурлын гүнзгийрэлт		Ядуурлын туйдал	
	1995	1998	1995	1998	1995	1998	1995	1998
Улсын хэмжээнд	36.3	35.6	820.7	862.9	10.9	11.7	4.8	5.6
Хот суурин газарт	38.5	39.4	470.5	493.4	12.2	13.9	5.7	7.1
Улаанбаатарт	35.1	34.1	214.1	221.3	10.4	13.0	4.5	7.4
Бусад хотуудад	41.9	45.2	256.5	272.1				
Хөдөө нутагт	33.1	32.6	350.1	369.5	8.9	9.8	3.6	4.4

Эх сурвалж: АТТС, YCG, 1998

Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах бодлого

2002 оны 7 сард Засгийн газраас Зөвлөлдөх бүлгийн хуралд хэлэлцүүлэх зорилгоор Дунд хугацааны өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах бодлогын баримт бичиг²² боловсруулсан ба түүндээ нэн ядуу хүний тоог 2005 онд 25%, 2015 онд 50%, ядуу хүний тоог 2005 онд 50%, 2015 онд нэмж 15% бууруулсан байхаар заасан.

Эдийн засаг, нийгэм, байгаль орчин ба засаглалын цогц бодлогоор ядуурлыг бууруулж хүн амын тогтвортой амьжиргааг хангахыг стратегийн зорилт болгосон энэ баримт бичигт хөдөө орон нутаг, мал аж ахуйд холбогдох олон чухал заалт орсон байна. Эдгээр нь өнөөгийн бодит байдлыг тусгаж тулгамдсан асуудлуудыг хамарчээ. Хамгийн чухал ач холбогдол нь өрх гэрийн хөгжлийг хөгжлийн үндэс болгож бодлогын төвд тавьсан байна. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх, үр дүнгийн мониторинг хийхэд өрхийн тогтвортой амьжиргаанд уур амьсгалын өөрчлөгдөл, аюул хэрхэн нөлөөлж буйг үнэн зөвөөр үнэлж түүнд тохирох хариу арга хэмжээ авдаг байх хэрэгтэй. Гэтэл энэ талаар дээрх бодлогын баримт бичигт заалт ороогүй байна. Байгаль цаг уурыг малчдын амьжиргаатай холбон үзсэн энэ судалгааг цаашид гүнзгийрүүлж уур амьсгалын өөрчлөгдлийг тооцсон нийгэм, эдийн засгийн хэтийн төлвийг прогноزلж, түүнд зохицох бодлого боловсруулахад чиглүүлж болох юм.

²² Дунд хугацааны өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах бодлого, Монголын Зөвлөлдөх уулзалтанд хэлэлцэх баримт бичиг, Улаанбаатар, 2002

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг

Энэ баримт бичгийг Монгол улс шилжилтийн үеийн туулсан замнал, хүрсэн үр дүн, хуримтлуулсан туршлагаасаа сургамж авч, цаашид эдийн засгийн өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах шинэ стратеги баримтлах болсноо бүрэн хэмжээгээр томъёолон илэрхийлсэн анхны баримт бичиг гэж үздэг. Үүнийг 2003 оны 9 дүгээр сарын 9-нд Дэлхийн банкны захирлуудын зөвлөлөөр хэлэлцэн баталж, 2003 оны 9 дүгээр сарын 12-нд ОУВС-гийн захирлуудын зөвлөлийн хурлаас сайшаасан байна. Эл баримт бичгийг дараах онцлогтой гэж дүгнэж байна²³:

- Ядуурлыг бууруулах талаар 1990 ээд оноос хойш баримталж ирсэн стратеги нь үндсэндээ тусламж олгох замаар эсвэл нийгмийн хамгааллын сүлжээгээр дамжин хэрэгжиж байсан бол шинэ стратеги нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро түвшиний бүтцийн өөрчлөлт шинэчлэл хийх, хүний тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн. Ядуурлыг бууруулах стратегийг Засгийн газрын үйл ажиллагаа, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, хөдөөгийн хөгжил, эрчим хүч, мэдээлэл, холбооны технологийн салбарын хөгжлийн стратеги болон холбогдох бусад баримт бичгүүдтэй нягт уялдуулсан.
- Уг стратегийг боловсруулахад Засгийн газар удирдан, Санхүү, эдийн засгийн яам зохицуулах үүрэг гүйцэтгэж, салбарын яамд, иргэний нийгэм, хандивлагчид хамтдаа идэвхитэй, үр дүнтэй оролцсон. Цаашид стратегийг хэрэгжүүлэх, явцын хяналт, үнэлгээ хийх, дүгнэхэд хөгжлийн үйл хэрэгт оролцогч нийгмийн бүхий л хэсгүүд оролцохоор төлөвлөгдсөн байна.
- Баримт бичиг нь дараах 6 бүлэгтэй:
 - Бүлэг 1. Монгол улсын шилжилтийн үе
Энэ бүлэгт макро эдийн засаг, хүн ам зүйн хандлага, ядуурлын байдал, жендерийн асуудал, ядуурлын шалтгаан, Засгийн газраас ядуурлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ололт амжилт, туршилагын талаар оруулжээ.
 - Бүлэг 2. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги. Үүнд хамрагдах асуудал нь:
*Засгийн газрын хөгжлийн зорилт, бодлогын тэргүүлэх чиглэлүүд
Нийгмийн бүхий л хэсгийн оролцоог өргөтгөх
Эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, үр шимийг ядуурлыг бууруулахад чиглүүлэх, улмаар тогтвортой хөгжлийг хангах*
 - Бүлэг 3. Эдийн засаг, санхүүгийн тогтворжилтыг хангах
 - Бүлэг 4. Зах зээлийн орчныг сайжруулах
 - Бүлэг 5. Хүний тогтвортой хөгжлийг хангах
 - Бүлэг 6. Стратегийг хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх

Баримт бичигт тэргүүлэх 9 чиглэл заасан байна:

²³ Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги, Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Жаргалсайханы илтгэлээс, 2003

- Макроэдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, улсын салбарын үр ашгийг дээшлүүлэх, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх
- Банк, санхүүгийн салбарыг бэхжүүлэх
- Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцыг түргэтгэх хүчтэй институци, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хувийн хэвшлийг эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болгох, экспортын чиглэлийн үйлдвэрлэлд тулгуурлаж эдийн засгийн өсөлтийг хангах
- Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх
-
- Бүс нутаг, хөдөөг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах
-
- Байгаль орчинд халгүй тогтвортой хөгжлийг хангах;
- Хүний тогтвортой хөгжлийг хангаж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, эдийн засгийн өсөлтийн үр ашгийг иргэдэд тэнцвэртэй хүртээх
- Ардчилалын үзэл баримтлал, хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан шударга, ёс зүйтэй, ардчилсан нийгмийн хөгжлийг хангах
- Сайн засаглал, жендерийн тэгш байдлыг хангах.

Ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилт, хяналтыг Санхүү Эдийн Засгийн Яам зохион байгуулж Ядуурлын судалгааны нэгж хариуцан гүйцэтгэх юм байна.

Стратегийн зорилтуудыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх ба явцын тайланг жил бүр гаргана. Стратегийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд нь Мянганы хөгжлийн зорилтуудтай нягт уялдсан байна. Стратегийг хэрэгжүүлэх явцад иргэний нийгэм, бизнесийн нэгжүүдийн санал, бодлыг сонсон стратегийг 3 жил тутамд шинэчлэн сайжруулж тасралтгүй байдлыг хангах арга хэмжээ авах юм байна.

Стратегийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой Итгэлцлийн санг Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр байгуулахаар төлөвлөж байгаа ба урьдчилсан тооцоогоор жилдээ ДНБ-ий 40-45 хувь хүртэл хэмжээний санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байгаа аж.

5.3. Мал аж ахуйг хөгжүүлэх, эрсдлийг бууруулах бодлого

Төр, засгийн бодлого шийдвэр ба хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол улсын засгийн газраас мал аж ахуйн салбарт бодлогын шинэчлэл хийж эрх зүйн орчинг боловсронгуй болгож түүнийг хэрэгжүүлэхэд бодлого, зохицуулалтын арга хэмжээ авч байна. Сүүлийн 3 жилд мал аж ахуйтай холбогдон гарсан баримт бичгийн тоо:

- Засгийн газрын тогтоол: 36

- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл: 39
- Ерөнхий сайдын захирамж: 22
- Засгийн газрын албан даалгавар: 1

Мал аж ахуйн эрсдлийг бууруулах асуудлыг тусгасан шинээр батлагдсан хуулиуд:

- Малын удмын санг хамгаалах, мал эмнэлгийн тухай
- Улсын нөөцийн тухай
- Хоршооллын тухай

Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд:

- Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах үндэсний хөтөлбөр, 1997-2005
- Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, 2000-2010
- Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр, 2001-2004
- Хоршоолол хөгжүүлэх хөтөлбөр
- Ногоон хувьсгал хөтөлбөр
- Цагаан хувьсгал хөтөлбөр
- Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хангамж
- Шилмэл хээлтүүлэгч, дэд хөтөлбөр, 2002-2006

Хэрэгжүүлж буй төслүүд:

- Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллёз өвчинтэй тэмцэх төсөл, 2000-2010
- Үхрийн арьсны гууртах өвчинтэй тэмцэх төсөл, 2002-2004
- Малын зарим архаг өвчинтэй тэмцэх төсөл, 2003-2007
- Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл,
- Малын гоц халдварт өвчнийг оношлох чадавхийг бэхжүүлэх төсөл

2002 оны 10 сард Бодлого судлалы төвөөс хэвлүүлсэн хөдөөгийн хөгжлийн стратегийн баримт бичигт²⁴ дараах 5 асуудлаар дэлгэрэнгүй дүн шинжилгээ, үнэлгээ болон төлөвлөгөөт зорилтууд тусгагджээ:

- Нутгийн хүмүүсийн санаачлагыг дэмжих
- Эрсдлийн менежментийн чадавхийг нэмэгдүүлэх
- Малчдын бүлэг, хоршооллын хөгжлийг дэмжих
- Хөдөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэх
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл ба хүнсний аюулгүй байдал

Мал аж ахуйн эрсдэлийн менежментийн чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлэх стратегийн зорилгын хүрээнд дараах 12 үр дүн гаргахаар төлөвлөсөн байна.

1. Малчдын хоршоолол, хамтын ажиллагаа
2. Бэлчээрийн тогтвортой менежементийг нэвтрүүлэх
3. Тэжээлийн хангамжийг сайжруулах
4. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах
5. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах
6. Эрсдэлийн урьдчилсан мэдээллийн тогтолцоог сайжруулах
7. Хөдөөд даатгал санхүүгийн үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх
8. Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд шаардлагатай цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх

²⁴ Хөдөөгийн хөгжлийн стратеги, Бодлого судлалын төв, 2002 оны 10 сар

9. Мал аж ахуй газар, тариаланг зохистой хослон эрхлэх замаар салбарын эрсдэлийг бууруулах
10. Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнд чанарын хянан магадлагаа хийх эрдэм шинжилгээний чадавхийг сайжруулах
11. Малын чанарыг сайжруулах эрдэм шинжилгээний чадавхийг сайжруулах
12. Мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга, технологийн талаар мэдээлэлээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээг малчдад хүргэх зохистой тогтолцоог бий болгох

Бодлогын баримт бичиг болон мал аж ахуйн эрсдлийг судлах явцад судлаачдын дунд олон асуудал гарч байлаа. Тухайлбал, Монгол улс ядуурлыг бууруулж ард түмнийхээ амьжиргааг дээшлүүлэх зорилт хэрэгжүүлэхийг хичнээн хүсэвч хөрөнгө мөнгө муутай, цаг үеийн тулгамдсан олон асуудалд л анхаарлаа хандуулж байна.

Хандивлагчид олон талын судалгаа шинжилгээ, бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг санхүүжүүлж маш олон хөтөлбөр, баримт бичиг гаргасан ч тэдгээрийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй хөрөнгө мөнгө дутагдалтайгаас олон хүний оюун ухаан, санаачлага, хөдөлмөр шингэсэн сайхан санаа, төлөвлөгөө цаасан дээр л үлдэж байна. Ийм тохиолдолд эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд яах ёстой вэ? Судалгаа хийгээд л цаасаа үйлдвэрлээд л байх уу? Эсвэл, одоо хийгдсэн цаасыг хэрэгжүүлэхэд тус болох аргагүй гаргаж, хэрэгжүүлэх бодит ажилд нь гар бие оролцож тус болох уу? Эдгээр асуултын хариу нь одоогоор тодорхойгүй байна.

Засгийн газар 2000-VIII сараас 2003 – III сар хүртэлх хугацаанд МАА-н салбарт нийт 24.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Тухайлбал:

- Ган зудаас хамгаалах: 3.98 тэрбум төг.
- Өвс тэжээл бэлтгэх 4.7 тэрбум
- Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх 4.4 тэрбум
- Мал үржлийн ажилд 27.2 сая
- Ургамал хамгаалал 1.7 тэрбум
- Бэлчээр усжуулалт 1.4 тэрбум

Хандивлагчдаас мал аж ахуйн салбарт нийт 12 сая ам.долларын тусламж авсан байна. Үүнд:

- Японы засгийн газар, 10 сая
- НҮБХХ, Английн засгийн газар, 652 мянга
- Швед улс, 289 мянга
- Швейцарийн засгийн газар, 218 мянга,
- Грекийн засгийн газар, 26,4 мянга
- АНУ засгийн газар, 318 мянган ам.доллартай тэнцэх тусламж
- Италийн засгийн газар 300 мянган ам.доллартай тэнцэх тусламж
- БНСВУ засгийн газар 400 мянган ам.доллартай тэнцэх тусламж

Бид судалгааны явцад мал аж ахуйн эрсдлийг бууруулахд зарцуулж буй хөрөнгийн хэмжээг мэдэхийг оролдсон боловч энэ талаархи мэдээлэл нээлттэй биш, төсөвт ийм ангилал байдаггүй, статистикийн мэдээлэл ч байдаггүй юм байна. Энэ асуудлыг хариуцан ажилладаг байгууллага нь Улсын нөөцийн газар бөгөөд холбогдох мэдээлэл нь нууцын зэрэглэлд ордог байна.

Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод дараах үндсэн зарчим баримталж байна:

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлагад нийцэх
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, экологийн цэвэр, аюулгүй хүнсний бүтээгдхүүн үйлдвэрлэж, экспортыг нэмэгдүүлэх
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг байгалийн аливаа эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх
- Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох

Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын ерөнхий чиглэл нь:

- Байгаль, эдийн засаг, санхүү, хүнийн нөөцөө зохистой ашиглаж, үйлдвэрлэлийг эрчимжүүлж үр ашгийг нэмэгдүүлэн, бүтээгдхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.
- Мал аж ахуй, газар тариалангийн салбарыг хослуулан хөгжүүлэх.
- Өмчийн бүх хэлбэрт тулгуурлан байгаль, цаг уурын өөрчлөлтөд зохицсон үр ашигтай, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх.
- Экологийн цэвэр бүтээгдхүүн үйлдвэрлэдэг эрсдэл багатай, байгаль орчинд халгүй хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийг хөгжүүлж, нэвтрүүлэхийг бүх талаар дэмжих.

Бизнесийн орчинг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх талаар тавьж буй зорилт:

- Татвар,зээл, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны уян хатан бодлогоор дэмжих.
- Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож нэн тэргүүнд фермерийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Мал сүрэг, тариаланг эрсдлээс хамгаалах гамшигийн болон, даатгалын тогтолцоог боловсронгуй болгох.
- Салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ТББ_уудын үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй хамтран ажиллах.
- Гадаад орон ОУБ_ын тусламж, зээлийн хөрөнгийг тухайн салбарыг хөгжүүлэх сан болгож хөдөөгийн усан хангамжийг сайжруулах, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд зарцуулах.
- Хөдөөд банк, банк бус санхүүгийн үйлчилгээг сайжруулан, бэлэн болон бэлэн бус мөнгөний арилжаа, зээлийн үйлчилгээг өргөжүүлэх.
- Хөдөөд ажлын байр нэмэгдүүлэх, хоршоог хөгжүүлэх, ялангуяа хадгаламж зээл, дундын хоршоодуудыг хөгжүүлэхэд дотоод нөөц боломж, гадаадын дэмжлэг тусламжийг үр ашигтай ашиглах.
- Салбарын хэмжээнд үндэсний уламжилалт арга ажиллагаа шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг сургалтын бүх арга, хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авах.
- Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр гаднаас оруулж ирж байгаа техник, технологи, амьтан, үр хөврөлийг импортын татвар болон нэмэгдсэн өртөгийн татвараас хөнгөлөх арга хэмжээ авах,
- Мал аж ахуй эрхлэгчидэд бэлчээрийг эзэмшүүлэх эрх зүйн үндсийг бий болгож, малчид, тариаланчдын хоршоо, фермерийн аж ахуйг татвар, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих.

Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр

2001 оны 3 сард Засгийн газар 47 дугаар тогтоолоор энэ хөтөлбөрийг баталсан.

Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ, зардлыг 2001 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлдэг болсон. Мөн тогтоолд мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах тухай журам гаргах, татварын зохих хэсгийг санд төвлөрүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 10 дугаар сард ЗГ-т танилцуулж байх заалтууд орсон.

Хөтөлбөрийг боловсруулахдаа 1944-2000 онуудад ган, зуд тохиолдсон үед Засгийн газар, аймаг, сумаас авч хэрэгжүүлж байсан зохион байгуулалт, үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт, НҮБХХ-ийн санаачлага, дэмжлэгээр зохион байгуулсан 1999- 2000 оны зудын сургамж зөвлөмж, эрдэмтдийн дүгнэлт, санал, малчдын гамшгийг гэтлэн давдаг туршлага зэргийг үндэслэл болгосон.

Хөтөлбөрийн гол зорилго нь: Мал сүргийг ган, зудаас сэргийлэн хамгаалах, ган зуд тохиолдсон үед авах арга хэмжээ болон учирсан хохирлыг нөхөх тогтолцоог боловсронгуй болгож, тусламжийн сүлжээг бүрдүүлж, малчид, мал бүхий иргэд болон бүх шатны төрийн захиргааны байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалт, дэмжлэг тусалцаа үзүүлэхэд оршиж байна.

Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтуудаар хэрэгжүүлнэ гэж заасан:

1. Болзошгүй ган, зудаас урьдчилан сэргийлэх бэлтгэл хангах
2. Ган, зудын нөхцөлд хохирол багатай даван туулах ажлыг зохион байгуулах
3. Ган зудаас учирсан хохирлыг нөхөх тогтолцоо бүрдүүлэх

Мал аж ахуйн хөгжлийн тулгамдсан асуудлууд


Монголын хөдөө аж ахуйн хөгжлийн тулгамдсан асуудлыг хэлэлцсэн нэгэн чухал хурал 2002 оны 5 сард болсон²⁵. Энэ хуралд төр, засаг, иргэний нийгэм, хувийн хэвшил, хандивлагчид оролцож хөдөөг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулах асуудлыг олон талаас нь нухацтай хэлэлцсэн. Эрсдэл судлах ажлын хэсгийн судлаачид уг хуралд оролцож судалгааны ажлын үр дүн болон мал аж ахуйн эрсдэлд хамрагдах асуудлын хүрээг²⁶ танилцуулж хэлэлцүүлсэн (Зураг 5.1).

Дээрх хурлын үр дүнд хандивлагчдаас санал авч мал аж ахуйн хөгжлийн тулгамдсан 19 асуудлын жагсаалтыг гаргаж баримт бичигт хэвлүүлсэн байна:

1. Хоршоо хоршоологчдод хөгжих дэвшиж үйл ажиллагаа явуулахад нь тус дэм болох нөхцөл байдлаар хангах
2. Хөдөөг хөгжүүлэхэд төрийн яамдын хамтын ажиллагаа, тэдгээрийн хэлтэс газруудын үйл ажиллагааны харилцан уялдаа, ойлголцол шаардлагатай
3. Хандивлагчид хамтран ажиллах шаардлагатай

²⁵ “Хөдөөгийн хөгжил” бага хурал Монгол Улсын Засгийн газар - Хандивлагчдын уулзалт, Үр дүнгийн баримт бичиг, 2002 оны 5 сарын 27-28

²⁶ Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл ба хөгжил, Эрсдэл судлах ажлын хэсэг, ЖЭМР ХХК, 2002 оны 2 сар



Зураг 5.1. Мал аж ахуйд тохиолдох аюул эрсдэлд хамрагдах асуудлууд

4. Хөдөөгийн олон нийтийн үйлчилгээ тухайлбал боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээг шинэчлэн сайжруулах
5. Хөдөөд ЖДҮ-ийг хөгжүүлэх асуудлыг дэмжих, ажлын байр буй болгох
6. Ил тод зөвшилцөх замаар хөдөөг хөгжүүлэх стратеги боловсруулах үйл ажиллагаанд Монголын засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, хандивлагчид, олон улсын байгууллагууд болон бусад олон нийтийн байгууллагыг оролцуулах
7. Бэлчээрийн байгалийн эрсдлийг зохицуулах
8. Хөдөөгийн санхүүжилт, микро үйлчилгээг дэмжин сайшаах
9. Хөдөөгийн эрчим хүч зэрэг хөдөөгийн үндсэн дэд бүтцийг тогтворжуулан буй болгох
10. МАА, газар тариалангийн бүтээгдхүүний тоог бус чанарыг чухалчилж сайжруулах ба тогтвортой байдлыг хангах
11. Газар эзэмшилтийг сайжруулахын тулд газрын холбоотой асуудлыг шийдэх
12. Хөдөө олон нийтийг мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлэх
13. Хөдөөгийн зах зээлийн тогтолцоог сайжруулах

14. Макро эдийн засгийн нөхцлийг бүрдүүлж, хөдөөгийн хөгжлийг үл дэмжсэн сөрөг бодлогын оронд салбар тус бүрт хөдөөгийн хөгжлийг дэмжсэн бодлого боловсруулах
15. Малын тоог хянах (Малаас байгаль орчныг хамгаалах)
16. Хөдөөг хөгжүүлэх стратеги нь хөдөөгийн ядуурал, түүний шалтгааны тухай тодорхой ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх
17. Хөдөөг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө нь бүсийн хөгжлийн асуудлыг тусгах ёстой бөгөөд үүний тулд бүс нутгуудын өнөөгийн байдлыг үнэлэх ажлыг эхлэх
18. Малчид, тариаланчдад зориулсан сургалт явуулах
19. Бэлчээр нутгийг нөхөн сэргээх

Дээрх жагсаалтад уур амьсгалын өөрчлөгдөл болон малчдын амьжиргааг сайжруулах талаар тусгайлсан зүйл тусгагдаагүй ч эдгээр зорилтуудыг хэрэгжүүлбэл хөдөөд ядуурлыг мэдэгдэхүйц бууруулна гэж найдаж болохоор байна.

Монгол улс нь хөгжиж буй бусад орны нэгэн адил хөрөнгө боломж хязгаарлагдмал, түүнийгээ өнөөгийн тулгамдсан олон асуудалд (эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах, хүн амын боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, дэд бүтэц гэх мэт) хүргэх гэж зүтгэж байгаа билээ. Ийм нөхцөлд хандивлагчдын дэмжлэг туслалцаа маш чухал үүрэгтэй. Мөн төрөл бүрийн салбарын байгууллага, хүмүүсийн хамтын ажиллагаа нь зардал мөнгө хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой. Ялангуяа уур амьсгалын өөрчлөгдөл, байгалийн хүчин зүйлсийн талаархи судалгаа шинжилгээний ажлын үр дүнг нийгэм, эдийн засгийн бодлого шийдвэр болон хөгжлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэрэглэх нь зүйтэй. Эрсдэл судлах ажлын хэсгийн мэргэжилтнүүд өөрсдийн боломж чадвараа ашиглан энэ талаар тодорхой зорилго, чиглэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

..

5.4. Уур амьсгалын өөрчлөгдлийн талаархи бодлого

Уур амьсгалын өөрчлөгдлийн засгийн газар хоорондын хорооны 3 дугаар тайлан

Эл тайлан²⁷ 2001 онд хэвлэгдсэн бөгөөд түүнд тив дэлхий, олон улс оронд уур амьсгалтай холбогдон гарч буй өөрчлөгдлийн талаархи судалгааны үр дүн, шинжлэх ухааны үндэслэл бүхий тайлбар нотолгоо болон өөрчлөгдлийг сааруулах, түүнд зохицох асуудлыг үндсэн 9 асуултаар задлан дэлгэрэнгүй задлан шинжилсэн байдаг. Мөн 21 дүгээр зуунд дэлхийн уур амьсгалын дулааралт хэрхэн явагдах, түүний улмаас байгаль орчинд ямар өөрчлөлт хувьсал гарч болох дүр төлвийг ч тусгасан байдаг. Тухайлбал, дэлхийн уур амьсгал 1.4 – 5.8⁰С дулаарч үүний улмаас цаг агаар, улирлын өнгө, усны нөөц, савшим тогтолцоо өөрчлөгдөх, эрс үзэгдлийн давтагдал нэмэгдэж болзошгүй гэж үзэж байна.

Дэлхийн уур амьсгал өөрчлөгдөж буй нь өнгөрсөн зууны эцэс, энэ зууны эхэнд хүн төрөлхтний анхаарлыг ихэд татаж байгаа билээ. Эрдэмтдийн судалгаагаар агаар дахь хүлэмжийн хийн хэмжээ 1750 оноос 2000 онд 31 хувь өсчээ. XX зуунд дэлхийн жилийн дундаж агаарын температур 0.6 хэм, далайн түвшин 10-25 см-ээр нэмэгджээ.

²⁷ The Third Assessment Report of Intergovernmental Panel on Climate Change, UNEP, UNFCCC, 2001

Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасыг сүүлийн мянган жилээр авч үзэхэд ХХ зуун нь хамгийн дулаан, халуун өдрийн тоо, ган, эрчимтэй аадар тунадасны давтагдал ихэссэн зуун болов. Зуун дотор хамгийн дулаан 10 жил нь 1990-2000 он, 10 жил дотор 1998 он хамгийн халуун нь байв. Шинэ зууны эхлэл 2001 он ч 1998 онтой эн зэрэгцэхүйц дулаан болов. Сүүлийн 50 жилийн байгаль цаг уурын өөрчлөгдөл нь хүний бодлогогүй үйл ажиллагааны уршиг гэж үзэж байна. Цаашлах тусам уур амьсгалын өөрчлөгдлийн эрчим нэмэгдэж болзошгүйг судлаачид тооцоолон гаргаж хойшлуулалгүй арга хэмжээ авах хэрэгтэй болж байгааг хүн төрөлхтөнд анхааруулан сэрэмжлүүлж байгаа²⁸.

Уур амьсгалын өөрчлөгдлийн Үндэсний хөтөлбөр

Даян дэлхийн уур амьсгал, түүний өөрчлөгдөл нь Монгол оронд ч нөлөөлж байна. Сүүлийн 30-аад жилд усны нөөц багасаж, ган, зуд, бэлчээрийн талхигдал, хөрсний элэгдэл эвдрэл ихсэж, цөлжих явц хурдасч, үер ус, мөндөр, шуурга, өвөл, хаврын их цас зэрэг цаг агаарын аюултай үзэгдлийн давтагдал эрс нэмэгдэж улс орны хөгжлийг сааруулж, хүн ардын амьжиргааг дордуулж байна.

Монгол орны уур амьсгалын өөрчлөгдөлтэй холбогдолтой бодлогын баримт бичиг нь Үндэсний хөтөлбөр юм²⁹. Монголд улсад ус цаг уурын байнгын ажиглалт хийсэн сүүлийн 60 жилд агаарын дундаж температур 1.56 хэм нэмэгдэж дулаарсан. Өвөл 3.61°C, хавар 1.5°C дулаарч, зун нь 0.3°C сэрүүссэн байна. Цаашид дулааралт эрчимшиж жилийн дундаж температур 2040 онд 1.8-2.8°C, 2070 онд 2.8-4.6°C хэмээр өсөх тооцоо гарсан байна. Уур амьсгал өөрчлөгдөхийн хэрээр цаг агаарын аюулт үзэгдлийн давтагдал, үргэлжлэх хугацаа, эрчимшил нэмэгдэхийг судлаачид тогтоожээ. Үүний зэрэгцээ байгалийн бүс бүслүүрийн хил шилжих, бэлчээр, усны нөөц багасах, улмаар малын ашиг шим буурах дүртөлөв тодорч буй аж.

Хүснэгт 5.5. Байгалийн бүс бүслүүр өөрчлөгдөх төлөв, 2040, 2070 онд

Байгалийн бүс бүслүүр	Одоогийн байгаа талбай	Болзошгүй өөрчлөгдөл			
		2040		2070	
	Сая га	%	Сая га	%	Сая га
Өндөр уул	5.66	-2.5%	5.52	-8.5%	5.05
Хангай	28.71	-3.2%	27.89	-7.1%	25.91
Хээр	35.12	-0.5%	35.06	-2.9%	34.03
Говь	35.33	-7.2%	33.16	0.3%	33.25
Цөл	20.36	13.3%	23.09	18.1%	27.28

Ойрын арав, тавь, зуун жилийн уур амьсгалын төлөв болон байгалийн бүс бүслүүрийн болзошгүй өөрчлөгдлийг цаг уурчид ийнхүү гаргасан байхад хэдэн зуу, мянган жилийн уур амьсгалын хэлбэлзлийг геологчид судалж байна. Монгол орны 5 нуурын хурдсанд хийсэн судалгаагаар алсдаа Монгол орны уур амьсгал дулаан, чийгтэй болох хандлагатай байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ³⁰.

Уур амьсгалын өөрчлөгдөлд зохицохын тулд Засгийн газраас дараах арга хэмжээ авах хэрэгтэйг Үндэсний хөтөлбөрт тусгасан байна:

1. Олон нийтийн мэдээлэл, малчдын сургалтанд анхаарах

²⁸ Climate change information kit, UNEP, 2002

²⁹ Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөр, 2000

³⁰ П.Хосбаяр, С.Алтанцэцэг, Уур амьсгалын төлвийг нуурын хурдсаар судалсан нь, Геолог сэтгүүл, 2001

2. Бэлчээрийн болон мал аж ахуйн менежментийг сайжруулах
3. Хадлангийн талбайг хамгаалах, нөхөн сэргээх, малын тэжээлийн хангамжийн системийг сайжруулах
4. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх
5. Ган зудын нөлөөллөөс хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээ
6. Уур амьсгалын аюулыг прогнолох, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх систем
7. Малын даатгалын системийг боловсронгуй болгох
8. Зах зээлийн тогтолцоог сайжруулах
9. Татварын системийг боловсронгуй болгох
10. Цаг уурын тааламжгүй нөхцөлд хөдөөгийн хүн амын орлогын өөр эх үүсвэр бий болгох
11. Хүн, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах
12. Цөлжилттэй тэмцэх

Дээрх 12 заалтын 7 нь мал аж ахуйн тулгамдсан асуудалд багтсан байна. Бид судалгааныхаа үр дүнд дээрх заалтуудыг нарийвчилж зохицох бодлого, арга хэмжээг удирдлагын төвшин, албан ба албан бус сектороор ялгавартай гаргахыг зорин ажиллаж байна.

5.5. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар Төв аймагт авч буй арга хэмжээ, үр дүн

Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийн алба, өрхийн амжиргааны чадавхийг дээшлүүлэх төсөл болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах арга хэмжээ авч тодорхой үр дүнд хүрч байна. Бодлогын ямар баримт бичгийн хүрээнд, ямар үйл ажиллагаа хаанахын санхүүжилтээр хэрэгжиж байгааг Хүснэгт 5.5-д нэгтгэн харуулсан ба доор нь дэлгэрүүлэн тайлбарлав.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албанаас 2000-2002 онд хийсэн ажил, хүрсэн үр дүн

2000 оны 1-р сарын 1-ний байдлаар Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 1248 хүн байснаа 2720 хүн шинээр бүртгүүлж, 943 хүн бүртгэлээс хасагдаж, 2178 хүнийг ажилд зуучлан байнгын ажлын байраар хангаснаар 2002 оны жилийн эцэст 899 бүртгэлтэй ажилгүйчүүдтэй болж ажилгүйчүүд 2000-н оноос 28 хувиар буурсан байна. Ажилд зуучлагдсан иргэдээс 4.5 % нь улсын үйлдвэрийн газарт, 19.5 % нь төрийн төсөвт байгууллагад, 46.0 % нь компанид, 1.5 хувь нь хоршоонд, бусад газарт 28 % тус тус ажилд орсон байна Энэ хугацаанд ажилгүйдлийн түвшин аймгийн хэмжээнд 2000 онд 3.3 %, 2001 онд 2.8 %, 2002 онд 2.1 % болж буурсан байна. 4399-н ажлын байр шинээр бий боллоо.

2000 онд хөдөлмөр эрхлээгүй хүн ам 8278 байснаа 2002 оны жилийн эцсийн байдлаар 7432 болж 846 хүнээр буюу 10.2 хувиар буурсан байна. Нийтийг хамарсан ажил, мянганы зам засварын ажил, ойг цэвэрлэх нөхөн сэргээх ажил ургац, төмс хүнсний ногоо хураах ажилд нийт ажил мэргэжилгүй 3738 хүнийг хамруулж түр ажлын байраар хангажээ.

Хүснэгт 5.5. Төв аймаг: ядуурлыг бууруулах арга хэмжээний нэгтгэсэн хүснэгт

	Байгууллага, төсөл	Бодлогын баримт бичиг	Санхүүжилт	Үйл ажиллагаа
1	Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн алба	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн сан	Ажилгүйчүүдийн бүртгэл хөтлөх
				Ажилгүйчүүдийг зуучлан ажилд оруулах
				Шинэ ажлын байрны бүртгэл хийх
				Нийтийг хамарсан үйлст ажилгүйчүүдийг хамруулах ажлыг зохион байгуулах
				Ажиллах хүч-Ажлын сэдэвт байр өдөрлөг явуулах
				Мэргэжлийн болон давтан сургалт явуулах
2	ӨАЧД төсөл, сумдад орон тооны нарийн бичгийн дарга ажиллуулж байна	Өрхийн амжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр, ӨАЧД төсөл хэрэгжүүлэх журам	Бэлчээрийн МАА-н эрсдлийн удирдлагын сан	Сургалт явуулах
				Төсөл шалгаруулж санхүүжүүлэх
				Худаг ус гаргах төсөл: төлөгдөхгүй
				Бусад төсөл: 6 сарын хугацаатай, сарын 4 хувийн хүүтэй
3	Бусад	Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	хувийн	Фермерийн аж ахуй
			хувийн	Үржлийн аж ахуй
			хувийн	Хонины аж ахуй

Мэргэжлийн болон давтан сургалт

Эсгий, тогооч нарийн боовчин, үсчин гоо сайханч, хоршооны сургалт, сантехникч гагнуурчин, худалдагч-нярав, хүлэмжинд хүнсний ногоо тариалах сургалтуудад нийт 1278 хүнийг хамруулж мэргэжилтэй болгож сургалтанд хамрагсадын 60 хувийг ажлын байраар хангажээ. Сургалтын үр дүнд Хоршоолол мэдээлэл сургалтын төв, Конрад Адинауредын сангаас хэрэгжүүлж буй Ядуурлыг бууруулах ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд Зуунмод, Архуст, Баянжаргалан, Жаргалант сумдад сургалт явуулан тухайн сумдад хоршоо байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр

Эл хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Ажиллах хүч-Ажлын байр сэдэвт тайлан өдөрлөг явуулсан. Өдөрлөгт сум, аймгийн удирдлагууд, ажил олгогч албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга эрхлэгч, сумдын ажилгүй иргэд өргөнөөр оролцлоо. Өдөрлөгийн үеэр хөдөлмөр эрхлэлтийн албанаас жижиг зээл аван хувийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдийн бүтээлээр үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 172 иргэн, 5-н аж ахуй нэгжид 26.5 сая төгрөгийн зээл олгож 197 ажлын байр бий болгосон байна.

Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр (ӨАЧДҮХ) - ийн суурь он болох 1999 онд 5431 өрх ядуу үүнээс 2700 өрх нэн ядуу амьдралтай ба нийт хүн амын 24.8 хувийг эзэлж байсан. ӨАЧДҮХ-ийн эхний үе шат болох "Тогтвортой амьжиргаа" төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь Бэлчээрийн МАА-н эрсдэлийн удирдлагын сан юм.

Энэ сангаас цаг агаарын эрсдэл, гэнэтийн аюулын урьдчилсан мэдээллийг малчдад хүргэх, бэлчээрийг удирдах, сэргээх зүй зохистой ашиглах, хадлан тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээх, малчдын бүлэг хоршоог дэмжих чиглэлээр Угтаал, Баян-Өнжүүл сумдад сургалт зохион байгуулж, орон тооны нарийн бичгийн дарга ажиллуулснаар төслүүд эхлээд байна.

Угтаалцайдам сумаас хадлан, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр 7 төсөл ӨАЧДХ-ийн Газар хүргэгдсэн ба Малчдын бүлэг хоршоо, худаг засварлах төслүүд боловсруулалтын шатандаа явж байна.

Бэлчээрийн эрсдэлийн менежментийг сайжруулахад зориулж 300 сая төгрөгийн тусламж үзүүлнэ гэж төлөвлөж байгаа. Энэ хөрөнгө нь бэлчээрийг усжуулахад зориулагдвал эргэж төлөгдөхгүй. Худаг ус гарга х ажил нь төслөөр хийгдэнэ. Ашиглалтын зардалыг ашиглагч хариуцах нөхцөлтэй тул төлбөрийн чадваргүй малчид уг төслийг хэрэгжүүлэх талаар эргэлзэж байна. Энэ нь бэлчээр дэх ус төлбөртэй болгоход хүргэж байгаа үүнийг малчид хүсэхгүй. Гар худаг, голын ус ашиглах нь илүү гэж үзэж байна. Хэрэв малчид бэлчээр усны төлбөр төлдөг болбол мал, түүний ашиг шимийн өртөг өндөр болж мах, сүүний үнэ нэмэгдэнэ. Энэ нь зөвхөн малчдад төдийгүй Монголын бүх хүн амын амжиргаанд нөлөөлнө. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг бууруулна.

Бэлчээрийн худаг уснаас бусад чиглэлийн төсөлд сарын 2-4 хувийн хүүтэй, 6 сарын дотор эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл өгөх журамтай. Ийм зээлээр хөрөнгө оруулалт хийж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах боломжгүй.

Сангийн яамнаас гаргасан ӨАЧД төсөл хэрэгжүүлэх журамд төсөл хэрэгжүүлэх нэгж нь малчдын хоршоо байна гэж заасан. Гэтэл амьдарлд малчдын бүлгийн олон хэлбэр байна: Тухайлбал, хот айл, малчдын холбоо, малчдын хамтлаг, фермерийн аж ахуй гэх мэт. Фермерийн аж ахуйн талаар хууль байхгүй байна.

Бэлчээрийн талхигдлаас хамгаалах талаар авч буй арга хэмжээ

Төв аймаг нь 7,404,237 га газар нутагтайгаас 5,546,416 га буюу 74.9%-ийг бэлчээр эзэлдэг. Газар зүйн байршлын хувьд улсын нийслэл Улаанбаатар хотыг тойрон оршдог онцлогтой тул бэлчээрийн даац их, талхлагдалд өртөх магадлал өндөр байдаг. Иймээс тус аймаг бэлчээрийн талбайг бууруулахгүй байх бодлого барьж ажиллахын зэрэгцээ талхлагдлаас урьдчилан сэргийлэх талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Аймгийн ИТХ-ын 2000 оны хуралдаанаас өвөлжөө, хаваржааны газрын ашиглалтын тухай Малчдын холбоо байгуулах тухай тогтоолууд гарч малчинд, Малчдын холбоонд өвөлжөө хаваржааны газрыг гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулах чиглэл сумдад өгснөөр одоо тус аймагт 3000 гаруй гишүүнтэй 267 Малчдын холбоо

байгуулагдан 921980.0 га өвөлжөө, хаваржааны бэлчээрийг эзэмшлээр ашиглан тэнд байгаа ой ан, ус ургамал, түүхийн дурсгалт зүйлсийг хамгаалан ажиллаж байна.

Энэ нь бэлчээр ашиглалтыг сайжруулж өөр аймаг, сумын малаас хамгаалах, талхлагдлаас урьдчилан сэргийлэх, бэлчээр дэх уст цэгийг хот айл дундаа ашиглах, хадлан тэжээлээ хамтран хурааж авах хэлбэрээр малчдын хамтран хөдөлмөрлөх нөхцөл бүрдсэн ач холбогдолтой ажил болж байна.

Малчдын холбоонд 25 хүртэлх өрх өвөлжөөний ойр байршлаас шалтгаалан хамрагддаг бөгөөд тэд өвөлжөө хаваржааны газрыг сумаас хэмжиж, тогтоож өгсөн хэмжээнд сумтай гэрээ байгуулан ашиглаж байна.

Гэвч ТББ – ын хуулиар малчдын холбоог хууль зүйн ямаар бүртгүүлэх шаардлагатай. Энэ нь хөдөө орон нутагт цөөн тооны малчид холбоо байгуулаад түүнийгээ бүртгүүлэх гэж Улаанбаатар хот руу зардал гарган ирэхэд хүргэж чирэгдэл учруулж байна.

Мөн сумдын ИТХ-ын хуралдааны шийдвэрээр бэлчээрийг өнжөөх, нөхөн сэргээх талаар газрын нэр хэмжээ заан орон нутагт хэрэгжүүлж байгаа нь бэлчээрийг талхлагдлаас сэргийлэх арга хэмжээний нэг хэсэг болж байна. Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 5 дугаар сарын 15 наас 10 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд өвөлжөө хаваржааны бэлчээрийг чөлөөлөх арга хэмжээ авахаар тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд цаг агаарын таагүй нөхцөлд ашиглах зорилгоор сум дундын отрын бүс нутгийг 4 газар байгуулж 90600 га газар нутгийг аймгийн сум дундын отрын бүс нутгийн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд авч түүнийг хамгаалах 8 харуул гарган ажиллаж байгаа бөгөөд цаашид бүс нутагт, хашаа барих уст цэгийг бий болгох, ургамлын бүрхэвчийг сайжруулах зэрэг арга хэмжээ авахаар төлөвлөөд байна.

Газар өмчлөлтэй холбогдуулан аймаг, сумын төвийн газрын зураглалыг аймгийн газрын алба, сумын газар хариуцсан түшмэл хариуцан хийж эхэлж байна. Өмнө газрын үнэлгээний шугамаар хийсэн зургийг суурь болгон ашиглаж байна.

Бэлчээрийн газрын хувьд жил жилээр зураглал хийгддэггүй. ээгүй. Засгийн газрын 2002 оны 01 тоот албан даалгавараар бэлчээрийн өвс, ургамлын гарцыг жил бүрийн 8 дугаар сард багтаан тогтоож мал өвөлжилтийн асуудлыг боловсруулах даалгавартай. Сумын газрын болон хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд өвсний гарцыг тодорхойлж өвөлжилтийн төлөвлөгөө гаргасан. Сум комисс томилоод явуулж үзээд төлөвлөгөө хийж байна. Комиссын бүрэлдэхүүнийг журмаар зохицуулагддаг. Журам нь албан даалгаварт нь бий.

Фермерийн аж ахуй

Төв аймагт 8 суманд саалийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 26 ферм байна. Эдгээр фермд алатау, хар тарлан, сименталь, казакын цагаан толгойтын эрлийз 825 үхэр байгаагаас 703 саалийн үнээ байна.

Байгаль цаг уурын өөрчлөлтийн үед тогтвортой үйл ажиллагаа явуулж, зах зээлийн харилцаанд нийцсэн чамгүй орлоготой, ажлын шинэ байр буй болсон давуу талтай фермерийн аж ахуй болон хөгжиж байна.

Батсүмбэр сумын Америк фермерийн аж ахуй

Д.Отгонбат эзэнтэй тус ферм нь 1999 онд сүүний алатау үүлдрийн 20 үнээтэй үйл ажиллагаагаа эхэлсэн. Одоо 20 үнээний байр дотроо гүний худагтай, 40-өөд үхрийн багтаамжтай өсвөр үхрийн байртай. Байр нь дулаалга сайтай, салхивч, ялгадас гаргах конвейер, саалийн үнээний дэвсгэр зэргийг технологийн дагуу барьсан.

Саалийн үнээний тэжээллэгийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. 8 га-д царгас тариалж, үнээг өвлийн цагт уурагт ногоон тэжээлээр хангадаг учир сүү, ашиг шим нь өвлийн цагт буурдаггүй. Өвсийг өөрийн хүчээр хангалттай бэлтгэж авдаг, хүчит тэжээлийг сүүний гарцын байдлаар үнээгээ ялгавартай тэжээдэг.

Өвсийг хадгалахдаа технологийн дагуу буюу салхи нэвтрэх, чийг, бороо нэвтрэхээргүй саравчинд хурааж хадгалдаг.

2 бухтай, үржлийн бэлтгэл, хээлтүүлэг, төллөлт, ширгээлт, хяналтын саам, сар, жилийн сүүний гарц зэргийг маш сайн хөтөлдөг.

Үржлийн үнээний заазлалтыг 15-20 хувиар хийдэг учраас сүүн ашиг шимээр 1 үнээнээс саалийн хугацаанд 3500-4000 л сүү саадаг. Сүүний тослог дунджаар 3.6 %, үржлийн шилмэл үнээнээс дунджаар 6000-6500 л сүү саадаг.

2002 онд Баянчандмань суманд зохион байгуулагдсан үржлийн малын үзэсгэлэн худалдаанд 1 үнээ, 1 өсвөр үхэртэй оролцсон. Энэ үнээний ашиг шимийн байдал:

Сүүний гарц /хоногийн/	19.6 л
Амьдын жин	685 кг
Сэрвээний өндөр	144 см
Биеийн ташуу урт	172 см
Цээжний өндөр	54 см
Цээжний гүн	77.5 см байсан.

Уг уралдаанд оролцсон үнээнээс бүх үзүүлэлтээр давуу тул алтан медаль, диплом, мөнгөн шагналаар шагнагдсан.

Энэ үнээ саалийн хугацаанд 6000-7000 л сүү өгдөг. Тус фермд өсвөр үхэр, үнээ тус бүр нь номертой, үржлийн бүртгэлийг саалийн аж ахуй өндөр хөгжсөн орнуудын түвшинд хөтөлдөг.

Ланс трейд ХХК-ний үйл ажиллагаа

Ланс трейд ХХК нь 2001 оны 9-р сард Зуунмод сумын ясли, цэцэрлэг, эмнэлэг, сургууль болон ард иргэдийн сүүний хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилготойгоор 10 үнээний ферм байгуулан үйл ажиллагаа эхэлсэн.

2002 онд үйл ажиллагаагаа өргөтгөн нэмж 10 үнээ худалдан авсан ба одоогийн байдлаар саалийн 20 үнээтэй. Өнгөрсөн жилд үнээний байраа томсгож байрандаа гүн өрмийн худагтай болсон. Хавар, намар ээлжлэн төллүүлдэг. Зохиомол хээлтүүлэг болон бухаар үнээгээ хээлтүүлдэг.

Сүүгээ аймгийн нэгдсэн эмнэлэгт гэрээний дагуу нийлүүлдэг. Мөн Зуунмод сумын иргэдийн хэрэгцээнд нийлүүлдэг.

Цаашид сүүний гарцыг нэмэгдүүлэхэд үнээний тэжээлд анхаарлаа хандуулж тэжээлийн ургамал тариалах төлөвлөж байна.

Мал үржлийн талаар

Гойд ашиг шимт малын үзэсгэлэн, дуудлага худалдаа

Жил бүр төвийн бүсийн гойд ашиг шимт малын үзэсгэлэн, дуудлага худалдааг Баянчандмань суманд 6 дугаар сарын сүүлчээр явуулж өндөр ашиг шимт мал, тэдгээрийн үр ашиг, өгөөжийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулдаг.

Уг үзэсгэлэн худалдаанд өөрийн аймгийн сумд хамрагдахаас гадна зэргэлдээ орших Сэлэнгэ, Булган, Өвөрхангай, Дундговь болон сонирхсон байгууллага, компани, хувь хмүүс өргөнөөр оролцдог.

Уг үзэсгэлэн дуудлага худалдаанд жил бүр дунджаар 80-120 шилмэл мал оролцсон малын төрөл бүр дээр хээлтэгч, хээлтүүлэгчийг шалгаруулж алт, мөнгө, хүрэл медаль, дипломоор шагнаж урамшуулдаг. Энд сүүний чиглэлийн хар тарлан, алатау, сименталь, мах-сүүний чиглэлийн казакын цагаан толгойт, монгол үүлдрийн үхэр, хурдан удмын азарга, гүү бусад насны өсвөр адуу, жороо морьд, мах-ноосны чиглэлийн хонь, нарийн нарийвтар ноост хонь, ноолуур, сүүний чиглэлийн ямаа зэрэг бүх төрлийн ашиг шимийг харуулсан үүлдэр, омгийн мал оролцдог.

"Хусан баганат" үржлийн аж ахуй

Аргалант сумын "Хусан баганат" ХХК-д үржүүлж буй ямаан сүрэг нь тоо толгой, амьдын жин, ноолуурын чанар, гарцаараа нутгийн омгийн малын шилмэл хэсгийн жишигт тэнцсэн гэж мэргэжлийн байгууллага үзэж 2002 онд үржлийн аж ахуйгаар баталсан.

Засгийн газрын "Шилмэл хээлтүүлэгч" дэд хөтөлбөрийн хүрээнд уг аж ахуйгаас жилд дунджаар 100-аас доошгүй өсвөрийн ухна бойжуулж борлуулах үйл ажиллагааг эхлээд байна.

Сүргийн зохистой бүтэц бүхий 900 гаруй ямаатай. Үүнээс 600 гаруй хээлтэгч, бусад нь өсвөр насны сүрэг болно. Нэг ямаанаас дунджаар 350 грамм, дээд тал нь 800-1000 грамм ноолуур авдаг. Цаашид ноолуурын гарцыг 400 граммд хүргэх зорилготой, ноолуурын микрон 13,0-13,5 мм хэмжээтэй.

Өөрийн аймгийн сумдын болон бүс нутгийн ямаан сүргийн ноолуурын чанарыг сайжруулах зорилгоор өсвөрийн улаан зүсмийн ухна бойжуулж борлуулах үйл ажиллагаа голлон эрхэлж байна. 2003 онд 100 ухна борлуулна.

Уг аж ахуй нь нийслэл Улаанбаатараас 46 км, Зуунмод хотоос 80 км-ийн зайд оршдог, засмал зам, өндөр хүчдэлийн шугамд холбогдож дэд бүтэц хөгжиж буй газар юм.

"Баянцагаан" хэвшлийн илүү нугаламт хонины аж ахуй

Төв аймгийн Баянцагаан сум нь Улаанбаатар хотоос 165 км, Зуунмод хотоос 115 км-т оршдог, тал хээрийн бүсэд ордог нутаг юм. Энэ бүс нутаг мах-ноосны чиглэлийн Баянцагаан хэвшлийн хонин сүргийг үржүүлж байна.

Баянцагаан хэвшлийн хонины амьдын жин нь монгол хонины амьдын жингээс 5.8-6 кг-аар, гарцаараа 50- гр-аар илүү байдаг.

Баянцагаан хэвшлийн хонины физиологийн нэг онцлог нь эрс тэс уур амьсгалыг даах чадвартай, тарга хүчээ багахан хугацаанд авч, өвөл хаврын улирлыг давж чаддаг чадвар юм

Энэ нутгаас жилд дунджаар 500-600 өсвөр хуц бойжуулж, бусад аймаг сумдад сайжруулагчаар худалдан борлуулдаг.

5.6. Бодлогод тусгах зарим санал

Нийгмийн ядуурлыг арилгах нь³¹

Ер нь нийгэм гэдэг нь явцуу утгаараа хүмүүсийн нэгдмэл цогц бөгөөд нийгмийн ядуурал гэдэг нь хүмүүсийн сэтгэл оюуны ба эдийн дутмагшил юм.

Хүн төрөлхтний түүхийн аль ч үед төгс нийгмийн байгуулал байсангүй. Иймээс хүн төрөлхтөн үүссэнээс хойш нийгмийн ядуурал үргэлжид байсаар ирсэн, хойшид ч байсаар байх болж байна.

Яагаад? Учир нь тэд “хүмүүс байгалиас 100% заяагдсан, эргээд 100% байгальдаа шингэнэ” гэсэн хэнд ч илэрхий энгийн үнэнийг гүн гүнзгий ухааж ойлгоогүйд л байгаа юм.

Хэрвээ хүн 100% байгалиас заяагдсан юм бол түүний тархи ч мөн 100% байгалиас заяагдсан байх ба хүний тархийг 100% заяасан байгалийн тархи нь хүнийхээс хавьгүй илүү байж л хүний тархийг 100% заяах нь хэн бүхэнд илэрхий. Иймээс хүмүүсийн нэгдмэл цогц болсон нийгмийн бүх харилцаа, хууль нь байгалийн хуулийн тусгал мөн.

Хүн төрөлхтөн хэдийгээр оюун ухаантан, суутан, мэргэд, гэгээрэгсэдтэй боловч тэднийхээ хэлсэн сургасан дээрх эгэл үнэнийг ойлгохыг хүсэхгүй, сонирхохгүй явна. Үүнээс болж байгалийн тархийг ойлгож, түүнтэйгээ төгс зохицсон нийгмийн байгуулал хүн төрөлхтөн үүссэнээсээ хойш өдий хүртэл зохиож чадаагүй явж байгаа билээ.

Нийгмийн ядуурлын хоёр хэлбэр болох сэтгэл оюуны ба эдийн хоёр дутмагшлын язгуур уг үндэс нь нийгмийн сэтгэл оюуны ядууралд л байгаа юм. Өөрөөр хэлбэл нийгмийн сэтгэл оюуны ядуурлыг бүрэн арилгаж байж л сая нийгмийн эдийн ядуурал болох наад захын таван зүйл - орон байр, хувцас хунар, хоол унд, эмнэлэг, боловсролын асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.

Боловсролыг эдийн асуудалд хамааруулж буй нь хүн төрөлхтөн үүссэнээсээ хойш сэтгэл оюунаа тэжээж байгаа боловсролын бүх систем нь байгалийн тархийг ойлгож гэгээрэхэд бус зөвхөн л өөрсдийн хэрэгцээгээ, өөрсдийн эдийн хэрэгцээгээ, хар амиа хичээсэн “би”-гээ хангах төдийд л үйлчилж ирсэн. Иймээс боловсрол нь эдийн асуудалд багтаж байгаа юм.

Харин сэтгэл оюуны ядуурлын хувьд хүн төрөлхтөн үүссэнээсээ хойш нэг ч удаа байгалийн тархийг бүрэн гүйцэт ойлгоогүй юм (үүнд хүн төрөлхтний дотор бурхад, гэгээрэгсэд гэж магтагдагсад ч багтана). Учир нь тэд бүх хорвоо ертөнц болох байгалийг бүхэлд нь “миний бие”, “би” гэж мэдэрдэг тэр нэгнийг таниагүй, олж хараагүй юм. Үүнийг хүн төрөлхтөн олж мэдэж, мэдэрсэн тэр тохиолдолд л байгалийн тархи болох түүнийг бүрэн ойлгох ба зөвхөн энэ тохиолдолд л байгалийн тархитай бүрэн зохицсон нийгмийн төгс байгуулал байгуулах бололцоотой. Зөвхөн энэ тохиолдолд л нийгмийн ядуурал бүрэн арилах болно. Өөрөөр энэ нь боломжгүй.

³¹ М. Ганболд, 2002 -12 – 2.

Одоо ирж буй 2003 он нь хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө огт гарч байгаагүй цоо шинэ эрин буюу хүн төрөлхтөн байгалийн тархийг ойлгон гэгээрэх, түүнтэй зохицох аугаа их эрин үеийн эхлэл юм.

*Бэлчээрийн мал аж ахуй, ган зуд, малчид*³²

Малчдад зориулсан мөнгө зээлийн бодлого

Бэлчээр нүүдлийн аж ахуйн үйлдвэрлэл борлуулалт нь улирлын шинж чанартай байдаг учир малчдын ажил амьдрал, үйлдвэрлэлийг хангах санхүүгийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн бусад салбарынхаас ялгаатай. Эл онцлогийг тусгасан мөнгө санхүүгийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Өнөөгийн Монгол банкнаас хэрэгжүүлж буй мөнгө, зээлийн бодлого нь малчин өрхийн аж ахуйн онцлогийг харгалзаж үзээгүй учир малчид ч зээл авдаггүй, авбал хүүгийн өсөлтийг төлж чадахгүй учир дампуурал, ядуурал зайлшгүй. Ингэснээр тэдэнд хөгжих эдийн засгийн үндэслэл муу байна. Олонхи малчин өрх амиа аргацаасан хэрэглээнээс хэтрэхгүй аж ахуй эрхэлж цаашид өсөх өргөжих боломж нөөц муутай байна. Байгаль цаг уурын бэрхшээлд өртөмтгий, ядуурал байнга отоостой байна. Үүнээс гарах замын нэг нь мал аж ахуйн талаархи төрийн мөнгө санхүүгийн өвөрмөц бодлого мөн.

Ган, зудын гамшиг

Дагнасан ган зудыг байгалийн эрсдэл гэсэн үзүүлэлтэд оруулж, зун нь ган болж өвөл нь зуд болсон тохиолдыг гамшиг гэсэн үзүүлэлтээр авах хэрэгтэй юм.

Ганд тэсвэртэй мал идээшилдэг ургамлын төрлүүдийг танин мэдэж аль бүс нутагт ямар ургамал давуу байршилтайг тогтоон тарималжуулах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах.

Мал сүргийг эрчимжүүлэн, эрчимжсэн мал аж ахуйг тохиромжтой бүс нутагт хөгжүүлэхдээ үндэсний аж үйлдвэр, газар тариалангийн сэргэлт хөгжилттэй хамт цогцолбороор шийдэх асуудал бөгөөд ялангуяа газрыг эрчимжүүлэхгүйгээр мал аж ахуйг эрчимжүүлэх боломжгүй.

Нэгэнт ган зуд болбол бэлчээр эзэмших малчдын холбоонд тулгуурлан хохирлыг барагдуулах ажил зохион байгуулах хэрэгтэй.

Ган зудад нэрвэгдэгсдийг малжуулахдаа нутгийн мал сүргээр баян иргэнд түшиглэн тодорхой сангаас гаргаж буй хөрөнгийг малаа таваар болгох сонирхолтой баячуудад оруулж уг баянаас тодорхой тооны малыг малгүйчүүдэд олгон гурван жилийн дараа анх авсан малыг хүйсээр нь буцаан тушаадаг мөн тэр үед уг баянаас сангаас хөнгөлөлттэй зээлдүүлсэн мөнгийг буцаан төлүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

Бэлчээрийн мал аж ахуй

Бэлчээрийн мал аж ахуй нь малчин өрхийн нүүдэллэн аж төрөх ёсонд суурилагдна. Чухамдаа мал нь бэлчээрээ дагаж, малчид нь малаа дагаж нүүдэллэх аж төрөх ёс бүрэлднэ. Энэ нь өнөөгийн бэлчээр нүүдлийн мал аж ахуй эрхлэлттэй салшгүй холбоотой.

Дэлхийн аливаа улс орон өөртөө хамгийн тохиромжтой мал аж ахуйн салбараар газар нутгаа эдэлбэрлэдэг. Монгол орны газар нутгийг эдэлбэрлэдэг үндсэн салбар нь бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй юм. Тухайлбал нутгийн 90 орчим хувь нь

³² Цэвээн, 2003-3 сар

бэлчээрийн талбай бөгөөд цаашид ч бэлчээр нүүдлийн мал аж ахуй урт удаан хугацаанд оршин байх нөхцөлтэй байна. Учир нь мал аж ахуй дангаараа эрчимжин хөгждөггүй. Мал аж ахуйн эрчимжилт нь шинжлэх ухааны хөгжил аж үйлдвэр, газар тариалангийн эрчимжилттэй нягт холбоотой явагддаг. Гэтэл үндэсний үйлдвэрлэл, газар тариаланг унаж нэлэнхүйдээ сэргэх шинж одоогоор алга байна. Мөн шинжлэх ухаан түүний дотор хөдөө аж ахуйн шинжлэх ухаан үйлдвэрлэлд нөлөөлөхүйц бүү хэл оршин байх эсэх нь тодорхойгүй орчинд байж байна. Улс орны өнөөгийн эдийн засгийн амьдрал ч хүнд байна. Энэ бүгд хоорондоо нягт холбоотой цогцолбор зүйлс бөгөөд чухам аль холбооноос нь ажлаа эхлэхийг ултай судалгаа, шинжилгээ нотлох юм.

1992 оноос мал сүргийг хувьд өгөхөөс үүдэн гарсан ганц дэвшил нь сүргийн бүтэц сайжрах төлөвийг олсноос өөр дэвшил байхгүй гэж хэлж болно.

Бэлчээрийн мал аж ахуйд чухал зүйл нь дулаан өвөлжөө байдаг. Өвөлжөө гаргадаг Монгол малчдын аргыг өнөөгийн нөхцөлд өргөн ашиглах.

Монгол бэлчээрийн мал 11 сарын 15-нд тарга хүчний дээд цэг 5 сарын 15-нд тураалын дээд цэгт хүрдэг. Энэ үеийн маллагаа хамгийн чухал үе болдог.

Малчдын хоршоо

Аливаа мэдлэгийн талаархи системтэй мэдлэгийг мэргэжил гэдэг ойлголтонд хамааруулдаг. Иймд малчин бол олон талын мэдлэгийг амьдралаас танин мэдсэн мэргэжилтэн юм.

Хөдөлмөрийг хоршин улмаар байнгын ажиллагаатай малчдын хоршоололын эрхэм зорилго бол: Хоршоолсноор өмнөх үеийн аж ахуй эрхлэлтээс илүү их орлого олж түүгээр малчид аж амьдралаа тасралтгүй дээшлүүлэх явдал бөгөөд ингэснээр байгалийн гэнэтийн гамшигт үйлээс урьдчилан сэргийлэх үүний тулд хашаа хороо барих, худаг ус гаргах, хадлан гэжээл бэлтгэх, дундын хөрөнгө хуримтлалаар мал эрүүлжүүлэх байгууламж, үүлдэр угсааг сайжруулах, улмаар мал аж ахуйг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах явдал юм.

Бэлчээр ашиглалт

Аймаг, сум, багийн бэлчээрийн нутгийг жилийн дөрвөн улирлын хүрээнд ашиглах нэгдсэн төлөвлөгөө гаргаж түүнээ иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажуулан даган мөрддөг байх хэрэгтэй. Өнө эртнээс нааш бэлчээр нүүдлийн мал аж ахуйг эрхлэж ирсэн амьдралын туршлага дээр суурилсан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа нь Монголын ард түмний оюуны болон материалын үнэт баялаг юм. Энэ нутаглалтын уламжлал алдагдсаныг дахин сэргээж мөрдөх хэрэгтэй. Үүнийг сэргээхэд зарим газар хэд хэдэн сумын нутаг хооронд хоршин хэрэглэгдэнэ гэдгийг анхаарах.

Сум нь оршин суух малчдын байршлын хувьд өвөрмөц онцлогтой. Үүнд 2-оос дээш айлаас хот айл, хэд хэдэн хот айлаас нэг усныхан, хэд хэдэн усныханаас нэг хонхорынхон, хэд хэдэн хонхорынхноос нэг нутаг усныхан, хэд хэдэн нутгаас нэг сум буй болдог. Бидний ажиглалт судалгаагаар 8-12 нутгаас сум бүрддэг бөгөөд нэг нутгийнхан бие биенээ сайн таньж мэдэхээс гадна зан ааш харилцаагаа бүрэн мэддэг зовлон жаргалаа хуваалцдаг. Мөн энэ нутагтаа идээшиж дассан мал сүрэг нь өөр нутагт идээшдэггүй нутаг ус руугаа хүртэл гүйж ээнэгшиж дассан байдаг. Энэ өвөрмөц байршилтанд түшиглэн бэлчээр нутаг эзэмших малчдын холбоо байгуулж үүний үндсэн дээр сумын бэлчээрийг улирлаар ашиглах хөтөлбөр гаргаж мөрдөх тэдний байнгын холбоонд түшиглэн хоршоолол болгон өргөжүүлж болох бөгөөд энэ

хоршоололын хөдөлгөөнийг төр засгаас оролцох оролцоо их уян хатан байх тухайлбал нэгэн ухаантны бичсэнээр төр засгаас үүнд нь захиргаадан оролцохгүй байхаас гадна урсгал зөнд нь орхиж болохгүй гэсэн тул түүний хөгжих хууль эрх зүйн үндсийг өөрийн орны онцлогт тохируулан бүрдүүлэх ёстой.

Өнөөгийн бодит байдалтай уялдан малчин өрхөөс борлуулж буй мал аж ахуйн бүтээгдэхүүнд байршлаас үүдэн гарах ялгааг тусгасан татварын бодлого баримтлах нь чухал.

Монголын бэлчээрийн мал аж ауйд газрын үржил шим онцын нөлөө үзүүлдэггүй. Харин 4 сарын дунд үеэс 8 сарын 20 хүртэл ороох хур тундас нь аль ч бүсэд ургамал ургахад нөлөөлөх бөгөөд энэ нь малын тарга хүч авах, ашиг шимд нөлөөтэй энэ нь бүс нутаг бүрд орох хур тунадас ялгаатай бөгөөд нөлөө нь ч өөр өөр байдаг. Иймд энэ ялгаа нөлөөллийг бүс нутаг бүрээр нарийвчлан тогтоох, мал аж ахуйн албан татварт ч тусгах шаардлагатай.

Эрсдлийн үнэлгээ, мэдээлэл

Эрсдэлийн үнэлгээг ерөнхий мэдээг цуглуулах, болзошгүй аюулт үзэгдлүүдийг газрын зурагт оруулах, эмзэг багуудын үнэлгээ хийх, болзошгүй хохирлын тооцоог гаргах, нөөц хөрөнгийн тооцоо судалгааг гаргах гэсэн логик дараалалтай хийх нь гамшигийн менежментийн үндэсний бодлогийг тодорхойлоход харгалзах тулгуур хүчин зүйл болж өгнө.

Байгалийн гамшигийн аюулыг үнэлэх, гамшигт бэлэн байхад зарцуулсан хөрөнгийг нь сэргийлж чадсан хохирлын зардалтай нь харьцуулахад 15 дахин бага байдгийг олон улсын туршлага харуулсан байна. Гамшигийн менежментийн үндэсний бодлогын талаар баримтлах гол үзэл баримтлал нь нөөц бололцоог хамгийн үр ашигтай ашиглаж зохицуулах, бие дааж гамшигтай тэмцэх чадавхийг бий болгох, бэлэн байдлыг хангах арга хэмжээнд орон нутгийн хүн амыг татан оролцуулах зэрэг асуудал болно.

Монголын бэлчээрийн мал аж ахуй нь ямар ч нөхцөлд тэнд ажиллагсдын амьжиргааны гол эх үүсвэр хэвээр байх бөгөөд малын тоо тэглэсэн тохиолдолд малчид амжиргааны өөр эх үүсвэрийн эрэлд гардаг. Бидэнд мэдэж тэмдэглэгдэж үлдсэн түүхэн сурвалжаас үзэхэд 1308-1309 оноос хойшхи зудын хохирол сургамж ямар нэг байдлаар бүртгэгджээ. Зуд нь мал аж ахуйд сөрөг, газар тариаланд эерэг байдаг үүнийг ашиглаж иржээ. Зудад малаа барахад газар тариалан эрхэлж өлбөрч үхэхээс хамгаалдаг байна. Улмаар тариалангийн бүтээгдэхүүнээр мал сольж малжин эргээд мал аж ахуйгаа эрхэлж байв.

19-р зуунд хаврын шар сүмийг барихад 4 аймаг, шавь таваас нас бие гүйцсэн хээлтэгч, хээлтүүлэгч малыг тодорхой тоогоор нийлүүлээд 3 жилийн дараа анхны өгсөн хээлтэгч хээлтүүлэгч малыг толгойн тоогоор буцааж аймаг, шавьд өгчээ. Үүнээс үзэхэд дан мал аж ахуй эрхэлдэг орны хувьд орчин үеийнхээр бол хүүгүй зээлийн арга юм. Нэгэнт малгүй болсон малчдыг малжуулхад мөнгө төгрөг биш уг аргыг орчин үеийн нөхцөлд ашиглаж болох талыг судлан улмаар мал хамгаалах сангийн ажиллагаанд ашиглаж болно.

Монголын радио, телевизээр цаг агаарын мэдээг өдөрт 3-аас доошгүй тогтмол цагт мэдээлдэг байх харин цаг агаарын аюултай, болон онц аюултай үзэгдлийг урьдчилан мэдэрсэн цагтаа мэдээлдэг байх нь зүйтэй.

Байгалийн гамшигт багтах төрөл, зүйл бүрт тохирсон төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.